Public Disclosure Authorized

Public Disclosure Authorized

Public Disclosure Authorized

82605

МОНГОЛ ДАХЬ ДЭЛХИЙН БАНКНЫ ГРУПП

Монгол улсын эдийн засгийн улирлын тойм

2013 ОНЫ 11 ДҮГЭЭР САР

Эдийн засгийн энэхүү тойм нь Монгол улсын эдийн засагт гарсан өөрчлөлтүүдийг үнэлэн дүгнэдэг нийтлэл юм. Чорчинг Гогийн (Монгол улс, БНХАУ, БНСУ хариуцсан тэргүүлэх эдийн засагч) ерөнхий удирдлага дор Таехүн Лигээр удирдуулсан (Монгол улсыг хариуцсан ахлах эдийн засагч), эдийн засагч Ш. Алтанцэцэг, зөвлөх Г. Хандцоож, Б.Даваадалай нарын баг тоймыг бэлтгэлээ. Мөн түүнчлэн Захид Хаснаин, Мариус Висмантас, Андрей Милютин, Д.Жигжидмаа, Транг Ван Нгуенг, Жуан Фенг нар хувь нэмрээ оруулаа. Корали Гэвэрс (суурин төлөөлөгч), Дийпак К Мишра (эдийн засгийн бодлогын ахлах эдийн засагч) нар энэхүү тоймыг бэлтгэхэд зөвлөлгөө өгч, хувь нэмэр оруулаа. Тоймыг бүрэн эхээр нь http://www.worldbank.org.mn хаягнаас татаж авах боломжтой. Нэмэлт мэдээлэл авах, санал дүгнэлт өгөх, тодруулбал П. Тинатай холбоо барина уу (tpuntsag@worldbank.org).

Агуулга

Хураангуй....4
Бүлэг I. Дэлхийн болон бүс нутгийн эдийн засгийн хөгжил, хэтийн төлөв....8
Сүүлийн саруудад томоохон хөгжсөн орнуудад сэргэлт гарч эхэллээ....8
Өсөлтийн эрч нэмэгдэж байгаа ч тус бүс нутаг дахь хөгжиж буй орнуудад эдийн засгийн өсөлт 2013 онд зөөлрөх хандлагатай байна....9
Тухайн бүс нутгийн эдийн засагт суурь эрсдэл байна....11
Бүлэг II. Монгол улсын эдийн засаг – Сүүлийн үеийн байдал болон хэтийн төлөв....13
Бодит салбарын байдал болон хэтийн төлөв....13
Инфляци....18
Ажил эрхлэлт....21
Төсвийн байдал болон хэтийн төлөв....24
Мөнгөний болон банкны салбар....31
Гадаад салбар....40
Бүлэг III. Эдийн засгийн хөгжлийн ерөнхий үнэлгээ болон бодлогын зөвлөмжүүд....49
Эдийн засгийн гол үзүүлэлтүүд....58

Зураг

Зураг 1. Голлох хөгжсөн орнуудад сэргэлт бий болж эхэллээ … .... **Error! Bookmark not defined.**
Зураг 2. … хөгжиж буй орнуудад ч мөн адил .... **Error! Bookmark not defined.**
Зураг 3. Тухайн бүс нутагт гол хөгжиж буй орнуудын өсөлт буурч байна....9
Зураг 4. Түүхий эдийн зах зээл сул байгаа нь тухайн бүс нутгийн байгалийн нөөц экспортлогч орнуудад хүнд тусч байна....10
Зураг 5. Хятадын өсөлт удаашрахад Монгол болон Лаос улсууд хамгийн их өртөнө....11
Зураг 1. Эдийн засгийн өсөлт хоёр оронтой тоонд хадгалагдсаар байна....13
Зураг 7.… хөдөө аж ахуй болон барилгын салбарын хүчтэй өсөлтөөр бий боллоо....13
Зураг 8. Барилгын өсөлт барилга болон замын барилгад гарлаа....13
Зураг 2. Уул уурхайн салбар багахан хэмжээгээр өсч, уул уурхайн бус салбарын ДНБ нь хоёр оронтой өсөлтийг бий болголоо....15
Зураг 10. Сүүлийн саруудад уул уурхайн үйлдвэрлэл нэмэгдэж байна....15
Зураг 11. Хоёр оронтой өсөлтийг хүчтэй дотоодын хэрэглээнээс бий болгожээ … 16
Зураг 12. … гэвч томоохон урсгал дансны алдагдлыг дагуулсан байна....16
Зураг 3. Тус бүс нутаг дахь хөгжиж буй эдийн засгийн өсөлтийн таамаглал....17
Зураг 14. Ядуурлын түвшин нэлээд буурчээ....18
Зураг 15. Сүүлийн саруудад инфляци өсч байна … 19
Зураг 16. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнүүд дахин өсч байна....19
Зураг 17. Суурь инфляци сүүлийн саруудад эргээд өсөх хандлагатай боллоо … 20
Зураг 18. Түрээсийн үнүүд мөн өсч байна....20
Зураг 19. Хөдөлмөрийн зах зээлийн гол үзүүлэлтүүд....21
Зураг 20. Ажилгүйдэл, хүйсээр....21
Зураг 21. Ажил эрхлэлт, салбараар....22
Зураг 22. Голлох салбараар ажиллах хүчний өөрчлөлт....22

Зураг 23. Төсвийн орлогын дутагдал их байна 24
Зураг 24. Төсвийн гүйцэтгэл нэлээд доогуур байна.....25
Зураг 25. Албан ёсны төсвийн алдагдал мөн харьцангуй бага байна.....25
Зураг 4. Төсвөөс гадуурхи зарлага нэмэгдэж байна.....27
Зураг 27. Төсвөөс гадуурхи зарлагыг оролцуулаад төсвийн нийт тэнцэл ДНБ-ий 11 гаран хувийг эзлэх болно 27
Зураг 28. Монгол улсын төсвийн алдагдал нь Зүүн Азийн орнууд дотроо хамгийн өндөр нь байна 27
Зураг 29. Засгийн газрын зардлын ДНБ-д эзлэх хувь ДНБ-ий 47 хувиас давахаар байна 27
Зураг 30. Улсын өрийн ДНБ-д эзлэх хувь 2012 онд 63 хувьд хүрсэн.....29
Зураг 31. Хөрөнгийн зардал хурдацтай өсч байна.....29
Зураг 32. Төв банкнаас арилжааны банкуудад хөрвөх чадварыг нэмэгдүүлэхээр мөнгө оруулсан нь хувийн салбарын зээлийн өсөлтийг хурдасгаж байна 31
Зураг 33. Тус бүс нутагийн хөгжиж буй бусад эдийн засагтай харьцуулбал зээлийн өсөлт өндөр, хэлбэлзэл ихтэй байна … 31
Зураг 34….мөн дотоодын зээлийн ДНБ-д харьцуулсан харьцаа өсч байна ….....31
Зураг 35. Зээлийн хадгаламжийн харьцаа өсч байна.....32
Зураг 36. Төгрөгийн болон гадаад валютын хадгаламж.....32
Зураг 37. Нөөц мөнгөний өсөлт саяхнаас буурлаа 33
Зураг 38. Барилгын зээл хурдацтайгаар өсч байна 34
Зураг 39. Барилгын салбарын зээлийн эзлэх хувь өсч байна.....34
Зураг 40. Сүүлийн саруудад ЧЗХ харьцаа өсч байна.....35
Зураг 41. ЧЗХ хэмжээ нь 9 сард өслөө 35
Зураг 42. Их хэмжээний гадаад худалдааны алдагдал үргэлжилсээр 40
Зураг 43. Нүүрсний экспорт огцом буурсан 40
Зураг 44. Нүүрсний экспортын хэмжээ болон үнэ буурсан.....40
Зураг 45. Сүүлийн саруудад зэсийн баяжмалын экспорт хурдан өслөө 41
Зураг 46. Урсгал дансны алдагдал өндөр хэвээрээ байна … 42
Зураг 47. …гэвч хөрөнгийн дотогшлох урсгал буурч байна….....42
Зураг 48. Гадаад валютын нөөц буурч байна 43
Зураг 49. Богино хугацаатай гадаадын хөрөнгийн түвшин бага байна 43
Зураг 50. Засгийн газрын бондын өгөөж хэлбэлзэлтэй байна 44
Зураг 51. Эдийн засгийн үндсэн параметрүүд болон бодлоны хувьсагчдаар хийсэн бүс нутагийн харьцуулалт 52

Хүснэгтүүд

Хүснэгт 1. Зүүн Ази болон Номхон Далайн бүс нутаг: ДНБ-ий өсөлтийн таамаглал.....11
Хүснэгт 2. Төрийн банкны баланс: Хадгаламжийн банкны үйл ажиллагааг шилжүүлэхээс өмнө болон дараа нь 36

Хайрцаг

Хайрцаг 1. Ядуурлын хэмжээ 2012 онд 27.4 хувьд хүрч буурсан.....14
Хайрцаг 2. Импортын барааны хэрэглээ болон суурь үнэ 20
Хайрцаг 3. Төсвөөс гадуурхи зарлага болон Чингис бонд 27
Хайрцаг 4. Хадгаламжийн банкны саяхны дампуурал 35
Хайрцаг 5. Үнийг тогтворжуулах хөтөлбөр 37
Хайрцаг 6. Барилгын болон Орон сууцны хөгжлийг дэмжих хөтөлбөр 38
Хайрцаг 7. Хөрөнгө оруулалтын шинэ хуулийн гол шинжүүд.....46
Хайрцаг 8. Монгол улс 2014 Бизнес хийх тайланд бизнес хийхийг хялбаруулах тал дээр амжилт гаргасан.....48
Хайрцаг 9. Монгол улс болон тус бүс нутагийн орнуудын макро эдийн засгийн бодлогууд 51

Товчилол

МБ	Монголбанк
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
МУХБ	Монгол улсын хөгжлийн банк
ГВ	Гадаад валют
ТТБТХ	Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ХХС	Хүний хөгжлийн сан
АХС	Ажиллах хүчний судалгаа
ЗГТ	Зүүн гар тал
МСХ	Монголын санхүүгийн холбоо
MNT	Монгол төгрөг
СЯ	Сангийн яам
өсх	өмнөх сартай харьцуулсан
сгд	сарын гулсмал дундаж
тн	тонн
ЧЗ	чанаргүй зээл
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ОТ	Оюу толгой
бгт	баруун гар тал
өух	өмнөх улиралтай харьцуулсан
өжх	өмнөх жилтэй харьцуулсан

Хураангуй

Монгол улсын эдийн засаг 2013 онд Оюу толгойн (ОТ) уурхайн зэсийн үйлдвэрлэл эхэлсэн, эдийн засгийн тэлэх бодлогуудын үр дүнд хоёр оронтой тоонд хэвээрээ байхаар байна. Гэвч эдийн засагт ГШХО-ын урсгал багассан, уул уурхайн экспорт сул байгаатай холбоотойгоор төлбөрийн тэнцэлийн хүчтэй дарамттай тулгарч байна. Төлбөрийн тэнцлийн энэхүү томоохон тэнцвэргүй байдал нь уул уурхайн зах зээл сул байгаагаас гадна сүүлийн хоёр жилд үргэлжилсэн эдийн засгийн мөчлөгийг дагасан удирдлагын үр дүнг илтээр илэрхийлж байгаа. Түүнээс гадна Монгол улсад дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал болон уул уурхайн зах зээлийн цаашдын сулралаас үүдэж эрсдэлд учрах талтай. Их хэмжээний төсвөөс гадуурхи зардал болон зээлийн хурдацтай өсөлтөд суурилан үргэлжилэн тэлж байгаа сангийн бодлогын улмаас макро эдийн засаг болон санхүүгийн өртөмтгий байдал улам нэмэгдэж байна. Засгийн газар үүсч байгаа асуудлыг даван туулах зорилгоор сүүлийн саруудад хэд хэдэн томоохон эерэг арга хэмжээг авч хэрэгжүүлсний дотор Хөрөнгө оруулалтын шинэ хууль гаргасан, төсвийг сайжруулах төлөвлөгөөг боловсруулсан явдал юм. Гэвч гадаад нөхцөл байдал тодорхой бус байдалтай байгаа, төлбөрийн тэнцэлийн тэнцвэргүй энэ нөхцөлд эдийн засгийн тогтвортой байдалд хүрэх, макро эдийн засгийн халхавч бодлогуудад чиглэгдсэн өсөлтөд чиглэсэн эдийн засгийн бодлогуудыг хэрэгжүүлэхэд илүү хүчин чармайлт шаардлагатай байна.

Бодит салбарын хөгжил

Монгол улсын эдийн засаг 2013 онд дахин хоёр оронтой тоонд байхаар байгаа боловч эрсдэлд өртөмтгий хэвээр байна. Төсвийн болон мөнгөний тэлэх бодлогууд болон ОТ уурхайн үйлдвэрлэл нэмэгдэж байгаатай холбоотойгоор эдийн засаг 2013 онд хоёр оронтой тоонд хэвээрээ байхаар байна. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн сайн гүйцэтгэл, барилгын салбар хүчтэй тэлсэн нь өсөлтөд нөлөөлсөн. Дэлхийн банк дөрөвдүгээр сарын эдийн засгийн тоймын үед хийгдсэн таамаглалаа (13 хувь) бууруулж 2013 онд 12.5 хувь болгон, БНХАУ-ын өсөлт суларсан, уул уурхайн салбарт сэргэлт таамаглаж байснаас удаан байгааг илэрхийлэн өөрчиллөө. Эдийн засгийн өсөлт 2014 онд мөн хоёр оронтой тоонд хэвээрээ байхаар байгаа бөгөөд энэ нь ОТ уурхайн үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбоотой юм. Гэвч эдийн засгийн төлөв байдалд гадаад орчны тодорхой бус байдал, төлбөрийн тэнцлийн тэнцвэргүй байдал нэмэгдэж байгаа энэ үед үргэлжлүүлсэн эдийн засгийн бодлогоос үүдэлтэй эрсдэл байсаар байна.

Инфляци

Инфляци нэг оронтой тоонд хадгалагдаж байгаа боловч сүүлийн саруудад инфляцийн дарамт өсч байна. Энэ оны эхэнд үндэсний хэмжээнд инфляцийн түвшин тогтвортой байсан боловч 8 дугаар сард 9.4 хувьд, 9 дүгээр сард 9.9 хувьд хүрч өслөө. Монголбанк Үнийг тогтворжуулах хөтөлбөрөөр үнүүдийг барьж инфляцийг нэг оронтой тоонд багтажж байна. Гэвч сүүлийн саруудад гарсан валютын ханшны сулралт нь импортлогдсон бүтээгдэхүүний өртөгийг нэмэгдүүлж, нийлүүлэгчдэд борлуулалтын үнийг тогтвортой барих боломжийг багасгаж байна. Валютын ханшны өнөөгийн хандлага, макро эдийн засгийн тэлэх бодлогуудаас үүссэн дарамттай байгаа энэ үед мөнгөний бодлогын удирдлагуудад инфляцийг нэг оронтой тоонд барихад төвөгтэй болох талтай.

Төсвийн байдал ба хэтийн төлөв

Төсвөөс гадуурхи зарлага нэмэгдэж байгаа нь санаа зовних асуудал хэвээрээ байгаа бөгөөд Чингис бондын орлогын томоохон хэсэг нь төсвөөс гадуурхи улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг, голчилон МУХБ-аар дамжуулан хийж байна. Засгийн газар ойролцоогоор 0.7 тэрбум ам.долларыг – энэ нь ДНБ-ий 6 орчим хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг – бондын орлогоос 9 дүгээр сар хүртэл зарцуулсан бөгөөд жилийн үлдсэн саруудад дахин 0.2-0.3 сая ам.долларыг зарцуулахаар байна. МУХБ нь 2012 оноос хойш төсвөөс гадуурхи зарцуулалтыг хийдэг гол санхүүжигч болсон бөгөөд түүний нийт төсвөөс гадуурхи зарцуулалт нь Чингис бондын төслүүдийг оролцуулаад 2013 онд ДНБ-ий 10 хувьд хүрэхээр байна. Чингис бондын орлого болон 2013 онд МУХБ-ны үйл ажиллагааны талаарх албан ёсны тайлан гараагүй бөгөөд энэ нь төсвөөс гадуурхи төслүүдийн ил тод байдал болон үр ашгийг талаар дахин санаа зовоосон асуудлыг үүсгэж байна.

Томоохон хэмжээний төсвөөс гадуурхи зарцуулалтын улмаас төсвийн бодлого 2003 онд хүчтэй тэлэх хэвээрээ байгаа ч төсвийг сайжруулах төлөвлөгөө гаргасан нь илүү тогтвортой төсвийн зам руу чиглэсэн эерэг алхам боллоо. Албан ёсны төсвийн зарцуулалтыг – энэ нь Монгол улсын Хөгжлийн банкны (МУХБ) зарцуулалтыг хасч тооцсон – хийхэд болгоомжтой байгаа бөгөөд учир нь төсвийн орлого анх

төлөвлөж байснаас нэлээд сул байна. Төсвийн удирдлагууд орлого дутагдаж байгаа энэ үед Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тэнцвэржүүлсэн алдагдлыг ДНБ-ий 2 хувьд хүргэж бууруулахын тулд төсвийг сайжруулах төлөвлөгөөг зарласан боловч төсвөөс гадуурх томоохон хэмжээний улсын хөрөнгө оруулалт нь төсвийн бодлогыг тэлэх хэлбэрт оруулж, төсвийн алдагдлыг төсвөөс гадуурхи томоохон улсын хөрөнгө оруулалтыг оруулан тооцвол ДНБ-ий 12 гаран хувьд хүргээд байна. Засгийн газрын зарлага 2010 онд 36.6 хувь байснаа огцом өсч 2013 онд ДНБ-ий 47 гаран хувьд хүрэхээр байна.

Мөнгөний болон банкны салбар

Мөнгөний бодлогын удирдлагууд энэ оны эхэнд зээлийн өсөлт сул байсныг даван гарах зорилгоор 2013 онд мөнгөний хүчтэй сулруулах бодлогыг хэрэгжүүлж байна. Мөнгөний сулруулах бодлого нь хөнгөлөлттэй нөхцөлтэйгээр зээлжих бодлогын хөтөлбөрүүдээр дамжин хэрэгжиж байна: (i) Үнийг тогтворжуулах бодлогын хүрээнд сонгогдсон салбаруудад 718 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгох; (ii) эдийн засгийг тэтгэхийн тулд нэг жилийн хугацаатай 900 тэрбум төгрөгийн хадгаламжийг банкуудад 5 сараас хойш байршуулсан; мөн (iii) нэмэлт барилгын болон орон сууцны хөтөлбөрүүд үүнд 6 сараас эхлэн бага хувийн хүүтэй 1.1 их наядын моргейжийн зээллэг мөн барилгын компаниудад 430 тэрбум төгрөгийн зээлийг гаргасан. Зээлийн бодлогын хөтөлбөрүүдээр дамжуулан төв банкны арилжааны банкуудад өгсөн зээл 2012 оны 11 сараас эхлэн буюу Үнийг Тогтворжуулах Хөтөлбөр эхэлнээс огцом 3.4 их наядаар өссөн байна.

Мөнгөний суларсан бодлого нь сүүлийн саруудад зээлийн өсөлтийг хурдасгаж байна, ялангуяа барилга болон орон сууцны салбарт өссөн байна. Хувийн салбарын зээлийн өсөлт 1 дүгээр сард 23.9 хувь байснаа 9 дүгээр сард 48 хувь болсон байна. Зээлийн хурдацтай өсөлтийн улмаас зээл хадгаламжийн харьцаа 2012 оны эцэст 99 хувь байсан бол 128 хувь болж огцом хурдацтай өсчээ. Зээлийн өсөлт барилгын салбарт голлон төвлөрсөн байна. Мөнгөний сулруулах хөтөлбөрийн гаргаж буй чөлөөтэй хөрвөх капиталын 60 гаран хувийг барилгын салбар болон орон сууцны салбаруудыг дэмжихэд хэрэглэсэн. Үүний үр дүнд, барилгын салбарт өгсөн банкны зээлийн өсөлт хоёрдугаар улиралд 67.7 хувьд хүрч өсөн, түүний банкны нийт зээлд эзлэх хувийн жин нь 37.7 хувь болон нэмэгджээ.

Зээлийн өсөлтийн одоогийн энэ огцом өсөлтөд мөнгөний бодлогын удирдлагууд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Мөнгөний бодлогыг сулруулсан нь эдийн засгийн өсөлтийг хоёр оронтой тоонд барихад нэмэр оруулж байгаа боловч ГШХО-ын урсгал буурч байгаа энэ үед зээлийн өсөлтийг нэмэгдүүлж байна. Гэвч эдийн засгийн сүүлийн үеийн үзүүлэлтүүдээс харахад сүүлийн саруудад гарсан хурдацтай зээлийн өсөлт нь гадаад болон дотоод тэнцвэргүй байдлыг муутгаж эхэллээ. Макро эдийн засгийн тогтвортой байдалд зээлийн огцом өсөлтийн сөрөг нөлөө нь валютын ханшны сулралтыг хурдасгаж, инфляцийг нэмэгдүүлэх байдлаар илэрч байна. Зээлийн өсөлт огцом байгаа энэ үед банкны салбар одоогийн эдийн засгийн байж болох уналтад нэрвэгдэх байдал улам нэмэгдэж байна, ялангуяа барилгын болон орон сууцны салбарт зээлийн төвлөрөлтэй энэ нөхцөлд. Төрөл бүрийн бодлогын зээлүүдэд тавигдах зөв зохицуулалтыг сулруулж, зөвшөөрөх нь ухамсрын эрсдлийг (moral hazard) нэмэгдүүлж, банкны тогтолцооны ил тод байдлыг бууруулснаар банкны салбарын эмзэг байдлыг улам нэмэгдүүлэх талтай байна.

Гадаад салбар

Төлбөрийн тэнцлийн дарамт улам нэмэгдэж байгаа нь ГШХО-ын урсгал буурч байгаа, уул уурхайн экспорт сул хэвээрээ байгаа энэ эдийн засагт улам том асуудал болж байна. Дэлхийн уул уурхайн зах зээл сул байгаа нь уул уурхайн экспорт, импортын эрэлтэд нөлөөлж байна – энэ нь ГШХО урсгал их байх үед 2011 онд хоёр дахинаас илүү хэмжээгээр нэмэгдэж байсан бол – дотоодын нийт эрэлт нь дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадлаасаа даван гарсан хэмжээнээс их хэвээрээ тогтлоо. Гадаадын хөрөнгийн дотогшлох урсгал нь буурсан нь хөрөнгө оруулалтын тогтолцоонд санаа зовниулах асуудал нэмэгдэж байгааг мөн ОТ уурхайн хөрөнгө оруулалт дуусаныг илэрхийлж байна. Урсгал дансны томоохон алдагдалтай байгаа энэ үед хөрөнгийн дотогшлох урсгал буурч байгаа нь их хэмжээний гадаад санхүүжилтийн цоорхойг үүсгэж, энэ нь ДНБ-ий 10 орчим хувьтай тэнцэж байна. Төлбөрийн тэнцлийн дарамт нэмэгдэж байгаа нь гадаад валютын нөөцийн байдал болон гадаад валютын зах зээлд илэрч эхэллээ. Дотоодын валютад гадаад нөхцөл байдал муудснаас үүдэж дарамт нэмэгдэн, 7 сараас эхлэн хүчтэй хэлбэлзэлтэй байлаа.

Валютын ханшны саяхны огцом хэлбэлзэл нь төлбөрийн тэнцлийн нэмэгдэж байгаа дарамтыг бууруулах, хөрөнгийн шинэ дотогшлох урсгалыг татахад чиглэгдсэн зөв эдийн засгийн бодлого хэрэгтэйг илэрхийллээ. Богино хугацааны зээллэг болон богино хугацааны гадаадын багцын хөрөнгө оруулалтын улмаас гадаад валютын зах зээлд хөрөнгийн огцом гадагшлах урсгалаас үүдэлтэйгээр томоохон

эрсдэл үүсдэггүй, гэвч энэ нь хэд хэдэн сөрөг мэдээллийн улмаас “онцлог эрсдэл”-д өртөмтгий болгож байна. Саяхан батлагдсан шинэ Хөрөнгө оруулалтын хууль нь төлбөрийн тэнцлийн тэнцвэргүй байдлыг зөөлрүүлэх, зах зээлийн сул сентиментыг сайжруулахад эерэг алхам болох талтай. Одоогийн байгаа гадаадын хөрөнгө, өр төлбөрийн бүрэлдэхүүнээс харахад, тухайн бүс нутагт бусад хэд хэдэн орнууд өртөөд байгаа хөрөнгийн гадагшлах урсгалын том сөрөг нөлөө хараахан алга байна. 2013 оны 6 дугаар сарын байдлаар, гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдэл хэмжээ 15 тэрбум ам.доллар байна. Монгол улс дахь гадаадын багцын хөрөнгө оруулалтын үлдэгдэл хэмжээ зөвхөн 2.7 тэрбум ам.доллар байгаагаас ихэнх нь урт хугацааны бондын хөрөнгө оруулалт ажээ.

Ерөнхий үнэлгээ болон бодлогын зөвлөмжүүд

Төлбөрийн тэнцлийн дарамт нэмэгдэж байгаа энэ үед одоогийн суларсан эдийн засгийн бодлогууд нь тогтвортой бус бөгөөд макро эдийн засгийн цаашдын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлнө. Засгийн газраас эдийн засагт тулгарч байгаа эрсдлийг даван гарах зорилгоор хэд хэдэн эерэг нааштай алхамуудыг авч хэрэгжүүлсэний дотор хөрөнгө оруулалтын шинэ хуулийг баталсан мөн төсвийг сайжруулах төлөвлөгөөг боловсруулсан явдал юм. Гэвч одоогийн эдийн засгийн бодлогын хүрээнд, импортын эрэлт тогтмол өндөр байгаа, мөн уул уурхайн зах зээл сэргэх байдал тодорхойгүй энэ үед төлбөрийн тэнцлийн томоохон дарамт нь ойрын жилүүдэд шууд их хэмжээгээр арилгахгүй байх талтай байна. Бүс нутгийнхаа орнуудтай харьцуулбал, Монгол улсын эдийн засгийн удирдлага нь өндөр тэлэлттэй байгаа бөгөөд энэ нь их хэмжээний урсгал дансны алдагдал, өндөр инфляцийг үүсгэж байна. (Хайрцаг 9). Хэрвээ одоогийн энэхүү тэлсэн, суларсан эдийн засгийн бодлогууд үргэлжилбэл төлбөрийн тэнцлийн дарамт тогтворгүй болох бөгөөд дунд хугацаанд эдийн засгийн хүчтэй зохицуулалтын үйл явц хийхэд хүргэх талтай.

Монгол улсын эдийн засаг нь гадаад эдийн засгийн тааламжгүй нөхцөл байдалд өртөх байдал улам нэмэгдэж байх талтай. Хятад улсын эдийн засаг нь хөрөнгө оруулалтад чиглэсэн өсөлтөөс илүү хэрэглээнд суурилсан өсөлт бий болгохоор өөрчлөгдөж байгаа нь Хятадын өсөлтийг цаашид бууруулах талтай. Хөгжсөн орнуудад сүүлийн жилүүдэд огцом нэмэгдүүлж байсан тоон сулруулалтыг багасгаж эхэлж байгаа нь шинээр үүсч байгаа орнуудад орох хөрөнгийн дотогшлох урсгалыг сулруулж, зээллэгийн өртөгийг нэмэгдүүлэх талтай. Дэлхийн уул уурхайн зах зээл ойрын жилүүдэд хангалттай нийлүүлэлт, голлох эрдэс бүтээгдэхүүн экспортлогч орнуудын дунд өрсөлдөөн нэмэгдэж байгаа энэ үед уг зах зээл сул хэвээрээ байхаар байна.

- **Өсөлтөд чиглэсэн эдийн засгийн бодлогуудыг эдийн засгийн тогтвортой байдалд чиглэсэн болгон өөрчлөх шаардлагатай байна.** Макро эдийн засгийн удирдлагын тэргүүлэх чиглэлүүд нь дараах зүйлд үндэслэх шаардлагатай: (i) дотоод хүчин зүйлээс үүсч байгаа төлбөрийн тэнцэлийн дарамтыг бууруулах; (ii) тэлж байгаа бодлогуудаас үүсэх гарч болох макро эдийн засгийн болон санхүүгийн эрсдлийг шийдвэрлэх; (iii) урт хугацаанд тогтвортой, тогтмол өсөлтийг хангах халхавч бодлогуудыг дахин сэргээх. **Төсвийн бодлогыг цаашид үргэлжлүүлэн чангалж, төсвийн орон зайг дахин бүрдүүлж эхлэх хэрэгтэй.** Зардлаа танах талаар саяхан мэдэгдсэн нь мэдэгдэхүйц амжилт; гэвч ихээхэн хэмжээний төсвөөс гадуурхи зарлага нь төсвийг сайжруулах төлөвлөгөөгөөр удирдагдахгүй хэвээрээ үлдэж байна. Төсөв нь орлогын бодитой таамаглал, үндэслэл сайтай зарцуулалтын төлөвлөгөөнүүд дээр үндэслэн ТТБТХуулийн дүрмүүдийг чандлан сахих ёстой. Нэн тэргүүнд төсвөөс гадуурхи зардлыг төсвийн нэг хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Дунд хугацааны төсвийг сайжруулах стратеги нь төсвөөс гадуурхи зарцуулалтыг оролцуулаад нэгдсэн төсвийн алдагдлыг аажмаар бууруулж, тухайн жилд ТТБТХуулийн 2 хувийн хязгаарт барих зөв хөшүүрэг болж өгнө. Урт хугацаандаа төсвийн бодлого нь хамгаалалтын зорилго бүхий бодлогын халхавчуудыг бүрдүүлж эхлэх хэрэгтэй юм. Одоогоор боловсруулж байгаа баялагийн сангийн хууль эрх зүй нь институцийн сайн суурийг бүрдүүлнэ.
- **Төсвийн бодлого “сайн зарцуулахад” чиглэгдэх ёстой.** Дэд бүтцийн салбарын зарлагын хэрэгцээг өсгөхдөө Засгийн газрын төлөвлөлт, хэрэгжүүлэх хүчин чадал болон тухайн эдийн засгийнхаа шингээх чадвартай уялдуулах хэрэгтэй. Үндэсний хөгжлийн стратегид тогтвортой төсвийн замд оруулах дунд хугацааны оновчтой улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө чухал байна. Монгол улс нь хөгжлийн эхэн үе шатандаа байгаа энэ үед бүх зүйл нь чухал санагдах боловч тэргүүлэх чиглэлээр нь ангилах нь төсвийн хязгаарлагдмал нөөц бололцоотой үед урт хугацааны хөгжлийн амжилттай эх суурь чухал үүрэгтэй.
- **Мөнгөний бодлого нь эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чиглэгдэх ёстой.** Сүүлийн саруудад бий болсон зээлийн хурдацтай өсөлт нь мөнгөний бодлого боловсруулагчид удирдлагуудад мөнгөний бодлогыг сулруулснаар эдийн засгийн чухал үзүүлэлтүүд, тухайлбал төлбөрийн тэнцэл болон инфляцид хэрхэн нөлөөлж байгааг дахин үнэлэх, зээлийн хурдацтай өсөлт нь сүүлийн саруудад буурч байгаа хандлага ажиглагдаж байгаа боловч голлох зээлийн

хөтөлбөрүүд үргэлжилж байгаа тохиолдолд мөнгөний бодлогын сулралт хэвээрээ байна. Нийгмийн чанартай, зорилготой бодлогын зээлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай бол, тэд хэрвээ үнэхээр шаардлагатай бол төсвөөр дамжин хэрэгжих ёстой.

- **Банкны тогтолцооны хяналт шалгалтыг сайжруулах хэрэгтэй.** Энэ жилийн эхээр хөрөнгийн хүрэлцээтэй байдлыг сайжруулах, Хадгаламжийн Даатгалын Корпорацийг байгуулсан нь сайн эхлэлийг тавьсан. Санхүүгийн салбарын эрсдлүүдээс зээлийн хурдацтай өсөлтөөс сэргийлэхийн тулд зохицуулалтын болон хяналт шалгалтын хүрээг илүү хүчтэй болгох, ялангуяа системийн хувьд чухал банкуудын хөрөнгийн хүрэлцээтэй байдлын үзүүлэлт, зээл гаргах явцыг сайжруулах, дотоод хяналтыг дээшлүүлэх нь чухал байна. Одоогийн зээлийн өсөлт хурдацтай байгаа энэ үед барилгын болон орон сууцны салбаруудад илүү өндөржүүлсэн хяналт шалгалт хэрэгтэй. Бодлогын зээлүүдэд оновчтой зохицуулалтыг зөөлрүүлсэнийг зогсоох шаардлагатай бөгөөд энэ зээлийн эрсдэл нь банкны тогтолцоонд муугаар нөлөөлөх талтай.
- **Хөрөнгө оруулалтын орчинг үргэлжлүүлэн сайжруулах.** Саяхан баталсан Хөрөнгө оруулалтын тухай хууль нь гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдад бизнесийн илүү таатай орчинг бүрдүүлэх замаар хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэхэд тусална. Хөрөнгө оруулалттай холбоотой зохицуулалт, бодлогын уялдаатай хэрэгжилтийг хийснээр энэхүү эерэг эхлэлийг улам сайжруулна.

Бүлэг I. Дэлхийн болон бүс нутгийн эдийн засгийн хөгжил, хэтийн төлөв[1]

Сүүлийн саруудад томоохон хөгжсөн орнуудад сэргэлт гарч эхэллээ

Голлох хөгжсөн эдийн засгуудад сэргэлт бий болж эхэлснээр, дэлхийн эдийн засгийн өсөлтийн хэтийн төлөв илүү нааштай болж байна. 2010 оны дунд үеэс хойш анх удаа Евро бүс нутаг, Япон, АНУ нь (улирлын нөлөөг арилгасан хэмжээг өмнөх улиралтай нь харьцуулбал) 2013 оны хоёр дугаар улиралд эерэг өсөлттэй гарлаа. (Зураг 1). 18 сарын турш үргэлжилсэн эдийн засгийн уналтын дараа Евро бүс нутаг нь 2013 оны 7 дугаар сараас хямралаас гарч эхэлсэн бөгөөд Япон улсын засгийн газраас илүү тэлсэн мөнгөний болон төсвийн бодлогуудын хэрэгжүүлэх шийдвэр гарсны үр дүнд гуравдугаар улиралд эдийн засгийн өсөлт нь хүлээгдэж байснаас өндөр өссөн байна. АНУ-ын эдийн засаг 2012 оны хоёрдугаар хагаст буурч байсан бол 2013 оны 2 дугаар улиралд эргээд өсөх хандлагатай байна.

Өсөлтийн байдал зарим томоохон хөгжиж буй орнуудад ч мөн эрчимжиж байна. (Зураг 2) БНХАУ-ын улирлын өсөлт нь өсөн хоёрдугаар улиралд 7.5 хувьд хүрсэн бөгөөд энэ нь нэгдүгээр улиралд 6.3 хувь байснаа 3 дугаар улиралд 7.8 хувь болсон, мөн сүүлийн үеийн аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, худалдааны тоо мэдээнээс харахад 2013 оны 3 дугаар улиралд нийт үйлдвэрлэл улам нэмэгдэхээр байна. Үүнтэй зэрэгцээд зарим хөгжиж буй гол орнуудад өсөлт хурдассан байна (6 хувийн жилд шилжүүлсэн өсөлт), Өмнөд Африк (3 хувь), мөн Турк (8 хувь). Гэвч бүх томоохон хөгжиж буй орнуудад өсөлт сайжраагүй л байна. (жишээлбэл, Энэтхэг, ОХУ).

Зураг 5. Голлох хөгжсөн орнуудад сэргэлт бий болж эхэллээ …

ДНБ өсөлт, %, өмнөх улиралтай харьцуулсан, улирлын нөлөөг тооцсон



Эх үүсвэр: Thomson Datastream.

Зураг 6. … хөгжиж буй орнуудад ч мөн адил

ДНБ өсөлт, %, өмнөх улиралтай харьцуулсан, улирлын нөлөөг тооцсон



Эх үүсвэр: Thomson Datastream болон ДБ-ны мэргэжилтнүүдийн тооцоо.

Дэлхийн эдийн засаг энэ оны тооцоолж байсантай зэрэгцэж очихоор байна—2.4 хувь, энэ нь өмнөх жилийн 2.5 хувиас бага зэрэг доогуур. Хоёрдугаар улиралд хөгжсөн орнуудад өсөлт хурдассан нь жилийн туршид үргэлжилэхээр байна. Өндөр орлоготой орнуудад улирлын өсөлт аажмаар эрчимжиж байгаагаас бүтэн жилийн өсөлт 2014 онд 2.1 хувь, 2015 онд 2.3 хувьд хүрэхээр

[1] Энэ хэсэг нь "Зүүн Ази, Номхон далайн эдийн засгийн тойм" дүгнэн авч үзсэн (2013 оны 10 дугаар сар)

байна. Харин хөгжиж буй орнуудад өсөлт энэ жилийн 4.8 хувиас сайжран 2014 онд 5.3 хувьд 2015 онд 5.6 хувьд хүрэхээр байна. Дэлхийн эдийн засгийн өсөлт 2014 онд 3.1 хувь харин 2015 онд 3.4 хувь байна. Гэвч 2014 болон 2015 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн таамаглал нь 2006 олон 2007 оны хямралаас өмнөх өсөлтийн хувь 4.0 хувиас доогуур үлдэхээр байна.

Өсөлтийн эрч нэмэгдэж байгаа ч түс бүс нутаг дахь хөгжиж буй орнуудад эдийн засгийн өсөлт 2013 онд зөөлрөх хандлагатай байна

Зүүн Ази, Номхон далайн орнуудын ихэнх улсуудад хоёр болон гуравдугаар улиралуудад эдийн засаг өсөлт хурдасч байгаа боловч өмнөх онтой харьцуулсан өөрчлөлт нь буурах хандлага үргэлжилж байна. (Зураг 3) Хятад улсын эдийн засгийн өсөлт нь тус улсын эдийн засаг нь зээлийг дэмжсэн, хөрөнгө оруулалтад чиглэсэн эдийн засгаас илүү тогтвортой хэрэглэгч- болон үйлчилгээнд чиглэгдсэн өсөлтөд шилжиж байгаатай уялдаж буурах хандлагатай байна. Дэлхийн түүхий эдийн үнүүд буурч байгаа нь экспортын орлогыг багасгаж, Индонезийн эдийн засгийн капитал- түлхүү хэрэглэх салбаруудад хийгдэх хувийн хөрөнгө оруулалтыг бууруулж, нийт өсөлтийг доош татаж байна. Тайланд улсын өсөлт нь 2013 оны хоёрдугаар улиралд огцом хурдацтайгаар буурсан нь үерийн дараах дахин сэргээлтийн ажил дуусах шатандаа орж, зарим нэг урамшуулалтын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээ зогсоосонтой холбоотой байна. Малайз улсын эдийн засаг нь хоёрдугаар улиралд хүлээгдэж байснаас багаар тэлсэн бөгөөд экспортын өсөлт буурч байгаа нь өсөлтийг нь доошлуулж байна.

Дэлхийн санхүүгийн хямралын дараах ЗАНДБүс нутгийн орнууд дахь өсөлтийн гол хөдөлгөгч хүчин зүйл нь дотоодын эрэлт байсан нь буурч байна. Томоохон хэмжээний урамшуулалтын хөтөлбөрүүдээр хувийн хэрэглээ болон хөрөнгө оруулалтыг дэмжиж байсан нь 2009 оноос хойш хөгжиж буй Зүүн Азийн өсөлтийн 90 гаран хувийг бүрдүүлж байлаа. Гэвч урамшуулалын хөтөлбөрүүд дэс дараатайгаар зогсож, дотоодын эрэлт суларч байна. Хятад улс цаашдаа өөрийн эдийн засгийг зээлийн өсөлт болон хөрөнгө оруулалтыг бууруулах замаар дахин тэнцвэржүүлэлт хийх арга замыг хайж байгаа ч түүний хурд нь нийт өсөлтөөсөө хамаарна. 2012 оны дунд үеэс Индонезийн эдийн засаг нь дэлхийн түүхий эдийн үнийн бууралт болон хувийн хөрөнгө оруулалт буурсан нөлөөнд автаж байна. Хувийн салбарын өр өндөр байгаа нь Малайз болон Тайланд улсад өөрсдийн эдийн засгаа дэмжих чадавхийг бууруулж байна.

Зураг 7. Тухайн бүс нутагт гол хөгжиж буй орнуудын өсөлт буурч байна

ДНБ өсөлт, хувиар, өмнөх жилтэй харьцуулсан, өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлс, пунктийн хувиар



Эх үүсвэр: Haver Analytics Болон ДБ-ны мэргэжилтнүүдийн тооцоо.

АНУ-ын Холбооны нөөцийн шийдвэрээр тоо хэмжээний зөөлрүүлэлт (ТХЗ) хийхээ хойшлуулсан нь шинээр үүсч буй зах зээлүүдэд орох капиталын урсгалыг сэргээж удирдлагуудад ирээдүйд үүсэх хэлбэлзлээс эрсдлээ бууруулах арга хэмжээ авах хоёр дахь боломжийг олгож байна. Тоо хэмжээний сулруулалтыг байхгүй болгох гэснээс үүдэж үнэт цаасны зах зээлд борлуулалт явагдаж, мөнгөн тэмдэгтүүдийн ханш сулран, дотоодын бондын өгөөж огцом

өсөхөд хүргэсэн билээ. Үүнд Индонез улс хамгийн ихээр өртсөн бөгөөд түүний дараа Тайланд, Филиппин, Малайз зэрэг улсууд өртсөн. Тус бүс нутгийн улсуудад харьцангуй их хэмжээний хөрөнгийн таталт явагдсан бөгөөд эдгээр нь тэдгээрийн санхүүгийн зах зээлд гадаадын өндөр оролцоотой хэсэг байсан нь эдгээр улсуудыг хэлбэлзэлд өртөх эрсдлийг улам нэмэгдүүллээ. Холбооны шийдвэрийн ТХЗ-ийн хийхээ хойшлуулахаар шийдсний дараагаар санхүүгийн зах зээлүүдийн тогтворжиж— ЗАНДБүс нутгуудад хамгийн хэрэгцээтэй байсан цаашдаа бүр бууруулах шийдвэрт хүрэхэд илүү сайн бэлтгэлтэй байх хоёр дахь боломжийг олголоо. Зөөлрүүлэлтийг байхгүй болгохоос үүдэх эрсдлүүдийг багасгах арга замуудад богино хугацааны болон гадаад валютаар илэрхийлэгдэх өрөөс хэтэрхий хамаарлаа багасгах, хэрвээ өсөлт боломжит түвшнээс бага байгаа тохиолдолд арай сул валютын ханшийг сонгох, мөн дэлхийн хөрвөх чадварт өөрчлөлт ороход бодлогын халхавчуудыг бий болгох явдал орно.

Дэлхийн түүхий эдийн зах зээл суларсан нь тухайн бүс нутгийн нөөц экспортлогч орнуудад хүндрэл үүсгэж байна. Метал болон эрдэс бүтээгдэхүүний үнүүд хамгийн их буурсан—2011 оны 2 дугаар сард хямралын дараах үеэс энэ оны 7 дугаар сар хүртэл 46 хувиар буурсан (Зураг 4). Тухайн бүс нутагт нөөц экспортлогч орнууд эрдэс бүтээгдэхүүний зах зээл сул байгаагаас нэлээд түүнд хүчтэй өртөж байгаа бөгөөд ялангуяа Индонез, Монгол улс орж байна. Индонез улсын[2] худалдааны нөхцөл 2012 дунд үеэс хүчтэй огцом муудсан. Малайз болон Вьетнам улс[3] нь шатахууны экспортоос ихээхэн хамааралтай бөгөөд мөн л түүхий эдийн сул зах зээлд хүчтэй өртөж байна. Зүүн Азийн нүүрс, газрын тос, байгалийн хийн экспортууд 2012 оны дунд үеэс бууралттай байсан бөгөөд үүнд Монгол улс болон БНЛаос[4] улсуудад хүчтэй нөлөөллөө. Тухайн бүс нутагт бусад түүхий эд экспортлогч орнуудтай харьцуулбал, Монгол улсын урсгал дансны алдагдал (ДНБ-ий 30 гаран хувь) хамгийн өндөр байгаа бөгөөд түүний дараагаар Лаос улс (ойролцоогоор 20 хувь), Папуа Шинэ Гвиней (ойролцоогоор 12 хувь) мөн Индонез (3.4 хувь) байна.

Дэлхийн эдийн засгийн өсөлт сайжирч байгаа нь хөгжиж буй Зүүн Азийн өсөлтийг 7 хувиас дээгүүр өсөлттэй байлгахаар байгаа бөгөөд энэ байдал нь түүний дэлхийн эдийн засагт тэргүүлэх байр суурийг хадгална. Дэлхийн банк хөгжиж буй Зүүн Азийн өсөлтийн таамалалаа бууруулж энэ жилд 7.1 хувь, 2014 онд 7.3 хувь гэж шинэчиллээ. (Хүснэгт 1) Хятад улсын өсөлт нь 2013 онд тавьсан албан ёсны тоон зорилтдоо хүрэхээр байна. Дунд хугацаанд Хятад улсын өсөлт нь 7.5 болон 7.7 хувийн хооронд байхаар байгаа бөгөөд удирдлагууд бүтээмж, шинэчлэлд илүү анхаарлаа хандуулан, хөрөнгө оруулалтад чиглэгдсэн эдийн засгаас хэрэглээнд суурилсан эдийн засаг болгохоор чиглүүлж байна. Хэдийгээр 2013 онд өсөлтөд бага зэрэг бууралт гарсан ч Зүүн Ази, Номхон Далайн Бүс нутаг (ЗАНДБН) нь дэлхийн эдийн засгийн тавны хоёр хувь, дэлхийн худалдааны гуравны нэгийг үйлдвэрлэж, энэ нь дэлхийн аль ч бус нутгаас өндөр байх болно.

Зураг 8. Түүхий эдийн зах зээл сул байгаа нь тухайн бүс нутгийн байгалийн нөөц экспортлогч орнуудад хүнд тусч байна.



Эх үүсвэр: ДБ, ОУВС тоо мэдээ, ДБ-ны мэргэжилтнүүдийн тооцоо.

[2] Түлш нь 2012 онд Индонезийн нийт экспортын 33 хувь нь байсан, мөн хүдэр болон метал 6 хувь.
[3] Түлшний экспорт нь 2012 онд Малайз улсын нийт экспортын 20 хувь нь байсан харин Вьетнамд 9 хувь байна.
[4] Хүдэр болон металын экспорт нь 2012 онд Лаос улсын нийт экспортын 53 хувь нь байлаа.

Хүснэгт 1. Зүүн Ази болон Номхон Далайн бүс нутаг: ДНБ-ий өсөлтийн таамаглал

			Таамаглал	Таамаглал
	2011	2012	2013	2014
Зүүн Ази	7.1	5.9	6.0	6.4
Хөгжиж буй Зүүн Ази	8.3	7.5	7.1	7.2
БНХАУ	9.3	7.8	7.5	7.7
Индонез	6.5	6.2	5.6	5.3
Малайз	5.1	5.6	4.3	4.8
Тайланд	0.1	6.5	4.0	4.5
Вьетнам	6.2	5.2	5.3	5.4
БНЛАУ	8.0	8.2	8.0	7.7
Монгол	17.5	12.4	12.5	10.3
Мьянмар	5.9	6.4	6.8	6.9
Папуа Шинэ Гвиней	10.7	8.7	4.5	10.0
Тимор-Листе	10.8	10.6	10.4	10.2
Гадаад орчны таамаглал:				
Өндөр орлоготой орнууд	1.8	1.6	1.3	2.1
Хөгжиж буй орнууд	6.3	4.7	4.8	5.3

Эх үүсвэр: Дэлхийн банк, Зүүн Ази болон Номхон Далайн Эдийн засгийн тойм, 2013 оны 10 сар

Тухайн бүс нутгийн эдийн засагт суурь эрсдэл байна

Зураг 9. Хятадын өсөлт удаашрахад Монгол болон Лаос улсууд хамгийн их өртөнө.

Хятад руу гаргаж буй экспорт, тухайн улсын нийт экспортод эзлэх хувь, 2012



Эх үүсвэр: ДБ, ОУВС тоо мэдээ, ДБ-ны мэргэжилтнүүдийн тооцоо.

Хятад улсад хөрөнгө оруулалт хүлээгдэж байснаас илүү буурсан нь Хятадын аж үйлдвэрлэлийн тэлэлт, дэд бүтцийн зардал болон үл хөдлөх хөрөнгийн хөгжлөөс хүртдэг капитал бүтээгдэхүүн болон аж үйлдвэрийн түүхий эд материал нийлүүлэгчдэд хүчтэй сөргөөр нөлөөлөх талтай. Хятад улсынх шиг том, олон талтай эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийнэ гэдэг нь нэлээд төвөгтэй, хүндрэлтэй олон талтай асуудал. Дэлхийн банкны үзэж байгаа суурь хувилбар нь экспорт болон хөрөнгө оруулалтад чиглэгдсэн өсөлтөөс хэрэглээ- болон үйлчилгээнд суурилсан өсөлтөд шилжих шилжилтийг илүү аажим бөгөөд дэс дараатай хийх хэрэгтэй юм. Гэвч дахин тэнцвэржүүлэх бодлого нь бараг гурван арван жил гараны туршид өсөлтийг бий болгож амжилттай хийгдэж байсан урт хугацааны өмнөх бодлогуудыг өөрчлөх (аж үйлдвэрлэл эрхлэгчид, улсын өмчит аж ахуйн нэгжүүд болон өмч бий болгогчдад бага хувийн хүүтэй байсан зээг) учраас тохируулга нь хурц, бөгөөд дэс дараагүй болох талтай. Хөрөнгө оруулалтыг огцом бууруулах нь өсөлтийг татах талтай учир нь нийт үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт өндөр хувь эзэлдэг мөн энэхүү бууралтыг даван гарч чадахаар хангалттай хэмжээгээр хэрэглээ өсөх нь хязгаарлагдмал. Хятад улсын өсөлт удааширч байгаа нь түүхий эд экспортлогчидод хамгийн их нөлөөлнө. Төрөлжилт багатай, Хятад улсаас экспортынх нь хамаарал нь хэт их болсон эдийн засгууд– жишээ нь Монгол, Лаос – Хятадын удааширч буй өсөлт нь хамгийн хүнд тусах талтай. (Зураг 5)

Хэдийгээр АНУ-д мөнгөний бодлогыг нормальжуулж байгаа нь хөгжиж буй орнуудад эцэстээ сайн нөлөөтэй ч тохируулга хийхэд төвөгтэй байх талтай. Мөнгөний урамшууллыг байхгүй болгож байгаа нь АНУ-д аж ахуйн нэгжүүд сэргэж байгааг илэрхийлж байгаа бөгөөд энэ нь дэлхийн хамгийн том эдийн засагтай худалдаа, санхүүгийн хувьд нэгдсэн орнуудад илүү ашигтай байна. Гэвч тохируулга хийхэд сөрөг талтай болж магадгүйг ТХЗ-ийг сулруулахад олон тооны хөгжиж буй орнууд санхүүгийн зах зээлд хэлбэлзэлд орсноос харж болно. АНУ-ын Холбооны Нөөц мөнгөний урамшууллаа аажмаар байхгүй болгохоор анх удаа анхааруулсан нь зээлийг хүүг өсгөж, багцын дотогшлох урсгалыг эсрэг болгон, Зүүн Ази болон бусад хөгжиж буй орнуудад хөрөнгийн үнэ буурсан. Хэдийгээр 9 сард зогсоохоо хойшлуулсан нь зарим тайвшралыг бий болгож байгаа ч санхүүгийн зах зээлүүдэд хэлбэлзэл тодорхой хугацаанд байсаар байхаар байна.

Тухайн бүс нутгийн орнуудад тэдгээрийн санхүүгийн зах зээлд томоохон гадаадын оролцоотой байсан том сангууд гарч явсныг тэд тайлагнаад байгаа бөгөөд энэ нь тэдгээрийг хэлбэлзэлд улам эрсдэлтэй болгож байна. Энэ орнууд мөн л ихээхэн хэмжээний урсгал дансны алдагдалтай (Индонез) эсвэл зээлийн огцом өсөлттэй байсан (Тайланд, Малайз). Эдийн засгийн тэнцвэргүй байдал болон санхүүгийн эмзэг байдал нь эдгээр эдийн засгуудыг дэлхийн санхүүгийн нөхцөл байдал сулрах үед эрсдэлд хүргэж байна. Хөрөнгийн гадагшлах урсгал болон урт хугацааны хүү нэмэгдэж байгаа нь бодит эдийн засагт үр нөлөөтэй. Хэдийгээр зээлийн хүү өндөр байх нь тогтмол хөрөнгө оруулалтад сөрөг талтай ч эцсийн дүндээ бодит өсөлтөд ч нөлөөлнө. Санхүүгийн зах зээлд нь гадны оролцоо багатай орнууд – жишээ нь Монгол улс – энэхүү богино хугацааны хөрөнгийн хэлбэлзлийн хөдөлгөөнд өртөх нь бага боловч гадаадын шууд хөрөнгө оруулалт багасах, олон улсын зээллэгийн өртөг нэмэгдэхэд өртөнө.

Бүлэг II. Монгол улсын эдийн засаг – Сүүлийн үеийн байдал болон хэтийн төлөв

Бодит салбарын байдал болон хэтийн төлөв

Монгол улсын эдийн засгийн өсөлт нь 2013 оны эхний хагас жилд удааширсан нь уул уурхайн зах зээлийн байдал сул байсантай холбоотой боловч бодлогын урамшуулалт болон хөдөө аж ахуйд тааламжтай нөхцөл байдал үүсссэнээс хоёр оронтой тоонд хэвээрээ байлаа. Эдийн засгийн өсөлт 2011 онд хамгийн өндөр түвшиндээ буюу 17.5 хувьд байснаас 2012 онд 12.4 хувиас бууран 2013 оны эхний жилд 11.3 хувиар өслөө. Эхний жилийн хоёр оронтой өсөлт нь нэгдүгээр улиралд 7.1 хувь байснаа хоёрдугаар улиралд огцом өссөнтэй (өмнөх онтой харьцуулбал 14.3 хувь) холбоотой байна. (Зураг 6). Уул уурхайн ДНБ нь уул уурхайн зах зээл сул байгаа ч эхний хагаст 6.1 хувьтай багахан тэлэлтийг хийсэн. Харин уул уурхайн бус ДНБ нь (уул уурхайн салбарыг хасаад) 2012 оны эхний болон хоёрдахь хагаст 13.3 хувь мөн 13.2 хувь байснаа 2013 оны эхний хагаст 12.3 хувиар өссөн байна. Төсвийн болон мөнгөний бодлогын хүчтэй дэмжлэгтэйгээр барилгын салбар нь эхний хагас жилд хоёр дахинаас илүү хэмжээтэйгээр өссөн нь хоёр оронтой эдийн засгийн өсөлтөд түлхэц өгсөн байна. Жилийн эхний хагаст хөдөө аж ахуйн тогтвортой хүчтэй өсөлт нь өсөлтөд сайн нөлөө үзүүлжээ (Зураг 7).

Зураг 10. Эдийн засгийн өсөлт хоёр оронтой тоонд хадгалагдсаар байна …



Эх үүсвэр: УСХ эмхэтгэл, ДБ-ны мэргэжилтнүүдийн тооцоо

Зураг 11…. хөдөө аж ахуй болон барилгын салбарын хүчтэй өсөлтөөр бий боллоо

Өсөлтийн хувь, үндсэн салбаруудаар (2013 оны 2 дугаар хагас, өох, %)



Зураг 12. Барилгын өсөлт барилга болон замын барилгад гарлаа

Барилгын үйлдвэрлэл, төрлөөр (тэрбум төгрөгөөр, өнөөгийн үнээр)



Эх үүсвэр: УСХ эмхэтгэл, ДБ-ны мэргэжилтнүүдийн тооцоо

Барилгын салбарын үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 129 хувиар огцом өссөн нь төсвийн болон мөнгөний бодлогоор дэмжсэнтэй холбоотой. ДНБ-ий үйлдвэрлэлтэд багахан хувийг эзэлдэг ч (2 хувь), барилгын салбарын өсөлт нь ДНБ-ий өсөлтийн 10 гаран хувийг бүрдүүлсэн байна. (11.3 хувь). Барилгын салбарын өсөлтийн нөлөө нь түүний үржүүлэгч үр нөлөөгөөр

бусад салбар болох тээвэр болон аж үйлдвэрлэлийн салбар тэлэхэд нөлөөлдөг.

Эхний улиралд 8.3 хувийн өсөлт үзүүлсний дараагаар, барилгын салбар нь хоёр дахь улиралд бодит утгаараа 154 хувиар өссөн нь мөнгөний болон төсвийн урамшуулах бодлогын үр нөлөө юм. Монгол банк (МБ) нь 1.8 их наяад төгрөг хүртэлх – томоохон хэмжээний хөнгөлөлттэй бодлогын зээлийг– Үнийг тогтворжуулах хөтөлбөр болон орон сууцыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд барилгын болон орон сууцны салбаруудад олгосон (Хайрцаг 6). Барилгын салбарын энэхүү огцом сэргэлт нь төсвөөс гадуурхи дэд бүтцийн хөтөлбөрүүдээс мөн үүдэлтэй. Монгол улсын хөгжлийн банк нь Чингис бондын орлогоор 4 дүгээр сараас эхлэн зам барилгын ажилд голдуу анхаарлаа хандуулж улсын дэд бүтцийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлсэн. Ийнхүү хүчтэй бодлогын дэмжлэгийн үр дүнд, орон сууцны болон арилжааны зориулалттай барилга байшин, мөн замын ажлууд хоёрдугаар улирлын туршид огцом нэмэгдсэн байна. (Зураг 8) Гэвч хөрөнгийн засварын ажилд өмнөх оноос бодит хэмжээгээр зөвхөн хоёр хувиар өссөн нь шинээр баригдаж байгаа барилга ихээр өсч байгаатай эсрэг зүйлийг үүсгэж байгаа бөгөөд шинэ төсөл хөтөлбөрүүд болон засварын үйлчилгээнд бага зарцуулдаг зөрүү үүсч байна.

Энэ жилийн цаг агаарын тааламжтай нөхцөл байдлын улмаас хөдөө аж ахуйн салбар нь эхний хагаст 20.6 хувиар өслөө. Хөдөө аж ахуй нь 2010 болон 2011 оны ширүүн өвлийн дараагаар (зудын) хүчтэй уналтад орсон ч зургаан улирал дараалан –20 гаран хувийн – хүчтэй өсөлтийг бий болголоо. ДНБ-ий бараг 16 хувийг бүрдүүлдэг хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь нийт өсөлтийн бараг дөрөвний нэгийг бий болгожээ. Хэдийгээр уг салбарын үйлдвэрлэлийн бүтцийн талаархи дэлгэрэнгүй тоо мэдээлэл байхгүй байгаа боловч улирлын хөдөө аж ахуйн ДНБ нь 2012 онд төрсөн их хэмжээний жижиг мал 2013 онд их насанд хүрснээр цаашид өндөр өсөлттэй байна. Энэ жилийн эцсээр хийгдэх малын тооллогын судалгааны үндсэн дээр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тоо мэдээ нь дахин шинэчлэгдэн гарна. ҮСХ-ны мэдээлж байгаагаар малын тоо нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бараг 80 хувийг бүрдүүлдэг байна.

Аж үйлдвэрлэлийн салбар болон бөөний/жижиглэнгийн худалдааны салбар нь эхний хагас жилд 6.6 хувь болон 3.1 хувиар тус тус өссөн байна. Аж үйлдвэрлэлийн салбар нь энэ хугацаанд дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувийг харин бөөний/жижиглэнгийн худалдааны салбар нь 11 хувийг бүрдүүлсэн. Дотоодын аж үйлдвэрлэлийн хязгаарлагдмал хүчин чадал мөн төрөлжөөгүй байдлаас үүдэж уг салбар хүнс, ундаа, нэхмэл эдлэлээс дийлэнх нь бүрдэж байгаа бөгөөд– энэ нь аж үйлдвэрлэлийн бараг хагасыг (хүнс, ундаа) мөн 10-15 хувийг (нэхмэл бүтээгдэхүүн) бүрдүүлж байна. Хоёрдугаар хагаст, хүнс болон ундааны үйлдвэрлэл 6.7 хувь, нэхмэлийн үйлдвэрлэл 6.8 хувь өссөн нь нийт аж үйлдвэрлэлийн өсөлтөд хүргэжээ.

Уул уурхайн үйлдвэрлэл даруухан өсөлт гаргасан буюу нүүрсний үйлдвэрлэл унасан ч эхний хагаст 6.1 хувийн өсөлтийг (өмнөх онтой харьцуулсан) бий болгожээ, гэвч Оюу толгойн уурхайн зэсийн үйлдвэрлэл огцом нэмэгдснээр хоёрдугаар хагаст нэмэгдэх хандлагатай байна.

- **Нүүрсний үйлдвэрлэл нь эхний 9 сарын хугацаанд 3.5 хувиар буурсан буюу өмнөх жилийн үед 18.9 сая тонн байснаа 18.2 сая тонн болжээ.** Нүүрсний үйлдвэрлэл буурсан нь Хятад улсад өрсөлдөөн нэмэгдэж байгаа, нүүрний арвин нийлүүлэлт байгаатай холбоотойгоор нүүрсний экспорт суларчээ: эхний 9 сард өмнөх жилтэй харьцуулбал нүүрсний экспорт 45 хувиар буурсан байна. Нүүрсний үйлдвэрлэл хүндрэлтэй нөхцөл байдалтай байгаа ба энэ оны эхээр голлох нүүрсний уурхайнуудад нүүрний үйлдвэрлэл зогссон, гол уул уурхайн компаний зээлжих зэрэглэлийг бууруулсан зэрэг нөхцөл байдалтай байна.

- **Нүүрсний үйлдвэрлэл нь одоо үргэлжилж байгаа бага үнэ, дэлхийн хүчтэй өрсөлдөөний дүнд сул хэвээрээ үлдэхээр байна.** Гэвч сүүлийн аж үйлдвэрлэлийн тоо мэдээнээс нүүрсний үйлдвэрлэл бага зэргийн сэргэлт гарсан байгаа харагдаж байна. 7 дугаар сар болон 9 дүгээр сарын хооронд нүүрсний үйлдвэрлэл нь 7 сар туршид үргэлжилсэн уналтаас сэргэж 18 хувийн (өмнөх оны мөн үетэй харьцуулбал) өсөлтийг гаргажээ. Эрдэнэс Таван Толгой компаний үйлдвэрлэлийн төлөвлөгөө хэрэгжиж эхэлбэл энэ нь энэ оны хоёрдугаар хагаст нүүрний үйлдвэрлэлийн сэргэлтэд нөлөөлнө.

- **Металын хүдрийн үйлдвэрлэлийн өсөлт нь ОТ уурхайн үйлдвэрлэл эхэлсэнтэй холбоотойгоор хүчтэй байна.** Эхний таван сарын уналтын дараа, металын үйлдвэрлэлийн өсөлт 6 дугаар сард эерэг болж, 7 болон 9 сарын хооронд 44 хувийн өсөлт гаргасан. Зэсийн үйлдвэрлэл нэгдүгээр улиралд 13 хувийн өсөлттэй байсан бол хоёрдугаар улиралд 30 хувиар, гуравдугаар улиралд 92 хувиар нэмэгдсэн. ОТ уурхай нь хоёрдугаар улиралд 13.1 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэсэн бол гуравдугаар улиралд 30.6 мянган тонн болж өссөн нь гуравдугаар улиралд зэсийн баяжмалын нийт үйлдвэрлэлийн 19 хувийг бүрдүүлж байна. Уг уурхайн үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх төлөвлөгөөр жилийн сүүлийн хагаст улам өсөхөөр байна.

- **Газрын тос болон алтны үйлдвэрлэл хүчтэй өссөн нь уул уурхайн эерэг өсөлтийг үзүүлэхэд тусаллаа.** Газрын тосны үйлдвэрлэл нь өмнөх оны мөн үеийнхээс 1-ээс 9 дүгээр сарын хооронд 39 хувиар өссөн. Алтны үйлдвэрлэл 9 сарын хугацаанд 67.8 хувиар мөн нэмэгджээ.

Зураг 13. Уул уурхайн салбар багахан хэмжээгээр өсч, уул уурхайн бус салбарын ДНБ нь хоёр оронтой өсөлтийг бий болголоо

Уул уурхайн болон уул уурхайн бус ДНБ өсөлт (%, өмнөх жил.)



Эх үүсвэр: УСХ эмхэтгэл, ДБ-ны мэргэжилтнүүдийн тооцоо

Зураг 14. Сүүлийн саруудад уул уурхайн үйлдвэрлэл нэмэгдэж байна

Уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт (3 сарын гулсмал дундаж, %, өм. жилийн мөн үетэй)



Зардлын талаас нь харвал, хүчтэй урамшууллын арга хэмжээний үр дүнд дотоодын хэрэглээгээр дамжин өндөр өсөлтөд хүрсэн. 2013 оны эхний хагаст эцсийн хэрэглээ нь 16.5 хувь өссөн нь (өмнөх оны мөн үетэй харьцуулбал) хоёрдугаар улиралд 25.8 хувийн өсөлт гаргасантай холбоотой – энэ нь 2008 оноос хойших улирлын хамгийн өндөр өсөлт – бөгөөд нэгдүгээр улиралд түүний өсөлт нь 6.6 хувь байсан (Зураг 11). Түүнчлэн дотоодын хөрөнгө оруулалт нь – сүүлийн хоёр жилд өндөр өсөлтөд хүргэж байсан бол – гадаадын хөрөнгө оруулалт буурсны улмаас эрчээ алдсан байна. Оны эхээр ОТ уурхайн хөрөнгө оруулалтын эхний үе шат дууссантай холбоотойгоор хоёрдугаар улиралд барилгын салбарт өндөр өсөлт гарсан ч эхний

хагаст дотоодын хөрөнгө оруулалт 16 хувиар буурчээ. 2011 болон 2012 онуудад, дотоодын хөрөнгө оруулалт 2011 онд 64 хувиар, 2012 онд 24 хувиар нэмэгдэж өсөлтөд нөлөөлж байжээ.

Барилгын салбарын өсөлтөөр бий болсон, хэрэглээнд чиглэсэн хоёр оронтой өсөлт нь төлбөрийн тэнцлийн дарамт нэмэгдэж буй энэ үед эдийн засгийн тогтвортой өсөлтөд санаа зовох асуудлыг бий болгож байна. Дотоодын аж үйлдвэрлэл нийлүүлэлтийн хүчин чадал багатай боловч уул уурхайн экспорт сул байгаа үед дотоодын эрэлт нэмэгдэх нь ойлгомжтой зайлшгүй үр дагаварт хүргэдэг нь – ихээхэн хэмжээний урсгал дансны алдагдал юм. 2011 оноос эхлэн эдийн засаг хоёр оронтой тоогоор өсөхөд, уул уурхайн экспортын өсөлт нь улам нэмэгдэж байгаа импортын өсөлтөө гүйцэхгүй урсгал дансны алдагдлыг ДНБ-ий 30 гаран хувьд хүргэж байсан (Зураг 12). Одоогийн өндөр өсөлт нь дунд болон урт хугацаанд тогтворгүй бөгөөд гадаадын хөрөнгийн дотогшлох урсгалд томоохон сэргэлт гарахгүй эсвэл дэлхийн уул уурхайн зах зээл сэргэхгүй бол урсгал дансны алдагдал үргэлжлэх нь хэвээрээ байна.

Зураг 15. Хоёр оронтой өсөлтийг хүчтэй дотоодын хэрэглээнээс бий болгожээ …

Зардлын бүрэлдэхүүн хэсгүүдийн өсөлтөд үзүүлэх нөлөө (2 дугаар улирлын ДНБ-ий өсөлт, %)



Зураг 16. … гэвч томоохон урсгал дансны алдагдлыг дагуулсан байна

Эдийн засгийн өсөлт болон урсгал дансны ДНБ-д харьцуулсан харьцаа (%)



Эх үүсвэр: УСХ эмхэтгэл, ДБ-ны мэргэжилтнүүдийн тооцоо

Хэдийгээр гадаад тааламжгүй нөхцөл байдлын эрсдэл байгаа, төлбөрийн тэнцлийн дарамт нэмэгдэж байгаа үед эдийн засгийн өсөлт 2013 онд хоёр оронтой тоонд хэвээрээ байхаар байна. Дэлхийн банк өмнөх 4 сард гаргасан эдийн засгийн тойм дахь өсөлтийн таамаглалыг (13 хувь) 12.5 хувь болгож шинэчиллээ. 2013 оны өсөлтийг буулгаж шинэчлэн тооцсон нь Хятадын эдийн засгийн өсөлт өмнөх 4 дүгээр сард таамаглаж байснаас сул байгаа мөн нүүрсний үйлдвэрлэлд сэргэлт удаан явагдаж байгааг илэрхийлж байна. Хэдийгээр бага зэрэг бууруулж таамаглаж байгаа ч эдийн засаг төсвийн болон мөнгөний тэлэх бодлогууд болон ОТ уурхайн үйлдвэрлэл нэмэгдэж байгаагаас 2013 онд хоёр оронтой тоонд хэвээрээ байхаар байна. Энэхүү эдийн засгийн өсөлт нь Зүүн Ази болон Номхон далайн бүс нутагтдаа хамгийн өндөр байхаар байна. (Зураг 13) ОТ уурхайн үйлдвэрлэл нэмэгдэж байгаа болон Чингис бондын орлогоор төсвөөс гадуурхи зарлага үргэлжилэх зэргээс үүдэж эдийн засгийн өсөлт 2014 онд хоёр оронтой тоонд хадгалагдахаар байна. Гэвч дунд хугацаанд дараах томоохон эрсдлүүдтэй учирч болно:

- **Дэлхийн уул уурхайн зах зээл цаашид суларна.** Сүүлийн үеийн уул уурхайн үйлдвэрлэлээс харахад багахан сэргэх хандлага ажиглагдаж байгаа ч дэлхийн нийлүүлэлт өндөр, өрсөлдөгч их байгаа үед Монгол улсын голлох уул уурхайн үйлдвэрлэл болон экспортын төлөв байдалд тодорхой бус байдал үүсгэж байна.

Зураг 17. Түс бүс нутаг дахь хөгжиж буй эдийн засгийн өсөлтийн таамаглал

Бодит ДНБ-ий өсөлтийн хандлага, таамаглал (%)



Эх үүсвэр: ЗАНДБ нүтгийн тойм, Дэлхийн банк (2013 оны 10 сар)

- **Хятадын эдийн засгийн өсөлт суларч байна.** Хятадын удирдагчид зээлийн хэт өсөлтийг хязгаарлах, хэрэглээнд илүү суурилсан эдийн засгийг бий болгохоор оролдож байгаа нь Хятад улсад хөрөнгө оруулалтыг бууруулж, эдийн засгийн өсөлтийг цаашид багасгах талтай. Монгол улсын нийт экспортын бараг 90 гаран хувь нь хятад улс руу хийгддэг тул Монгол улсын эдийн засаг нь Хятадын эдийн засгийн мөчлөгд хамгийн өндөр өртдөг. (Зураг 5).

- **Дэлхийн тоо хэмжээний сулралтыг байхгүй болгож байгаа нь сөрөг үр дагавар гарна.** Хөгжилтэй орнуудад мөнгөний бодлогоо чангаруулж байгаа нь шинээр үүсч буй эдийн засгуудад хөрөнгийн дотогшлох урсгалыг бууруулж, зээлийн өртөгийг нэмэгдүүлэх талтай. Дэлхийн хөрвөх чадварын нөхцөл байдал өөрчлөгдөж байгаатай уялдуулж хөрөнгө оруулагчид өөрсдийн бизнес төлөвлөгөөгөө тохируулах бөгөөд энэ нь Монгол улсад орох хөрөнгийн урсгалыг удаашруулах талтай.

- **Эдийн засгийн тэлэх бодлогуудыг үргэлжлүүлэх.** Уул уурхайн ихээхэн нөөцөөс үүдэлтэйгээр урт хугацааны эдийн засгийн төлөв байдал сайн байгаа ч төсвийн болон мөнгөний тэлэх бодлогуудаар дэмжигдсэн хүчтэй дотоодын эрэлт нь төлбөрийн тэнцлийн томоохон дарамтыг нэмэгдүүлж байна. Гадаадын хөрөнгө оруулалтын сул хэвээрээ байгаа энэ үед их хэмжээний урсгал дансны алдагдалтай байх нь эдийн засгийг төлбөрийн тэнцлийн тэнцвэргүй байдлыг эцэстээ шингээх хүчтэй зохицуулалтад оруулах талтай бөгөөд түүнийг валютын ханшны сулралт, дотоодын эрэлтийг огцом бууруулах байдлаар хийгдэх болно.

Хайрцаг 2. Ядуурлын хэмжээ 2012 онд 27.4 хувьд хүрч буурсан

Дэлхийн банкны техник туслалцаатайгаар, УСХ нь ядуурлын шинжилгээг хийсэн бөгөөд үүнд үндэсний хэмжээнд ядуурлын хувь 2010 онд 38.7 хувь байснаа 2011 онд 33.7 хувь болж 2012 онд цаашлаад 27.4 хувь хүртэл буурчээ, жилдээ 5 эсвэл 6 хувийн бууралт гаргасан байна. Ядуурлын хувь хөдөө нутаг болон хотын бүс нутагт аль алинд нь буурсан. Хотын бүс нутагт, ядуурлын хувьд хоёр жилийн туршид 9.9 хувиар буурлаа. Харин хөдөө нутагт ядуурал илүү өндөр хувиар буюу 13.5 хувиар буурчээ. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны тоо мэдээллээс харахад, нэг хүнд ногдох өрхийн хүнсний болон хүнсний бус бараг бүх ангилал өссөн дүнтэй байна.

Зураг 18. Ядуурлын түвшин нэлээд буурчээ

Албан ёсны ядуурлын түвшин (%)



Эх үүсвэр: УСХ, ДБ мэргэжилтнүүд

Албан ёсны 2010-2012 ядуурлын үнэлгээ нь Монгол улсад ядуурал буурч байгаа дэвшлийг хянах боломж олгож байна. Тэдгээрийг 2010 оны өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны тоо мэдээллээс гаргаж авсан ядуурлын шугам дээр үндэслэн цаг хугацааны хувьд харьцуулах боломжтой. Энэхүү цуваа нь хэд хэдэн арга зүйн шинэчлэлийг хийсэн. Нэгдүгээрт, өрхийн нийт хэрэглээнд өрх бүрээс цуглуулж авсан хэрэглээний түлшний тооцсон утгыг багтаасан. Энэ нь хөдөөгийн өрхийн ялангуяа Монголын урт, хүйтэн өвлийн түлшний хэрэглээг ойролцоолон гаргаж байна. Хоёрдугаарт, шинэ үнэлгээ нь өмнөх үеийнхийг бодвол одоогийн хүн амын тархалтын талаар илүү бодитой мэдээлэл дээр үндэслэсэн. Судалгааны түүврийн жин нь 2010 оны хүн амын судалгаанаас үндэслэн хот-хөдөө болон аймагийн хүн амын тархалтыг илүү харуулж чадсан, сайжруулсан. Гуравдугаарт, шинэ үнэлгээ нь 2010 оны суурь үнээр хүнсний бус ядуурлын шугамыг сүүлийн жилүүдэд тохируулга хийж шинэ албан ёсны ХҮИ-ийн тоог (2012 онд гаргасан) хэрэглэсэн. Фишерийн хүнсний индекс нь[5] хүнсний ядуурлын шугамд тохируулга хийхэд ашиглагдан хэрэглэгдэж байна.

Ядуурлын шинжилгээний энэхүү аргачлал нь цаг хугацааны туршид ядуурлыг үнэлэхэд олон улсын стандарт практиктай уялдуулах боломжийг олгосон. Эдгээр шинэчилсэн тооцоонууд нь өрхийн хэрэглээний үнэн бодит байдлыг сайжруулж, өнөөгийн хүн ам зүйн өөрчлөлтийг илэрхийлнэ. Ийм сайжруулалт гарснаар бодлого боловсруулагчдад нийгмийн дэвшил хөгжлийг хянах, ядууралын талаарх төрийн бодлого, өсөлтийн нөлөөг тооцоход илүү бодитой үзүүлэлтийг хангаж өглөө.

Эх үүсвэр: ДБ-ны мэргэжилтнүүд

Инфляци

Инфляци жилийн туршид нэг оронтой тоонд байгаа боловч инфляцийн дарамт нэмэгдэж байгаа хандлага байна. Нэгдүгээр сард 13.0 хувь байсан улсын инфляци 7 дугаар сард 8.3 хувь хүртэл буурч байсан бол 8 дугаар сард 9.4 хувь, 9 дүгээр сард өмнөх жилтэй харьцуулбал 9.9 хувь

[5] Фишерын үнийн индекс нь бараа, үйлчилээний үнийг хэмждэг, сагсны үндсэн дээр суурь болон өнөөгийн үед харьцуулан гаргадаг үнийн статистикд хэрэглэгддэг индекс юм. Энэ нь Ласперсийн үнийн индексийг (энэ нь зөвхөн суурь үеийн сагсанд хэрэглэгддэг) болон Паашийн үнийн индексүүдийн (энэ нь зөвхөн тухайн үеийн сагсанд хэрэглэгддэг) геометрийн дунджаар тодорхойлогддог . Иймээс Фишерийн үнийн индексийг (АНУ-ын эдийн засагч Ирвинг Фишерээр нэрлэсэн) үнийн индексийн " хамгийн боломжит" хэлбэр гэж үздэг (Eurostat. http://epp.eurostat.ec.europa.eu/statistics_explained/index.php/Glossary:Fisher_price_index).

болжээ. Харин нийслэл хотын инфляцийн түвшин нь 1 дүгээр сард 12.7 хувиас буурч 7 дугаар сард 7.0 хувь хүрэн буурч 8 болон 9 дүгээр саруудад 8.4 хувь болон хурдассан байна. (Зураг 15)

Зураг 19. Сүүлийн саруудад инфляци өсч байна …



Зураг 20. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнүүд дахин өсч байна



Эх үүсвэр: ҮСХ эмхэтгэл, ДБ-ны мэргэжилтнүүдийн тооцоо

Хүнсний бүтээгдэхүүний инфляци 8 дугаар сард 5.6 хувь байснаа 9 дүгээр сард 9.7 хувьд хүрэн хурдасч, өмнөх саруудад байсан тогтвортой удааширч байсан хандлагаас эргэсэн байна. (Зураг 16) Хүнсний бүтээгдэхүүний инфляцийг 8 дугаар сард 5.1 хувь байснаа 9 дүгээр сард 9.6 хувь болгон хурдасгахад махны үнүүд нөлөөлсөн. Ихэнх махны бус хүнсний бүтээгдэхүүний үнүүд 8 болон 9 дүгээр саруудад мөн өсчээ. Талх болон тарианы үнийн өсөлт нь– мөн гол үзүүлэлт бөгөөд – 7 дугаар сард 10.9 хувь байснаа 8 дугаар сард 12 хувиар, 9 дүгээр сард 14 хувьд хүрчээ. Сүү, бяслаг болон өндөгний үнүүд 7 дугаар сард 6.7 хувиас 8 дугаар сард 9.7 хувь, 9 дүгээр сард улам хурдсан 18.5 хувьд хүрчээ.

Сүүлийн саруудад суурь инфляци нэмэгдэж байгаа нь инфляцийн дарамт нэмэгдэж байгааг харуулж байна. Өмнөх жилийн мөн үетэй харьцуулсан суурь инфляци 7 дугаар сард 7.9 хувьтай байсан бол 8 дугаар сард 9.8 хувьд хүрч өсөөд харин 9 дүгээр сард 9 хувьд болж буурчээ. Суурь инфляци өсч байгаа нь 7 сараас хойш валютын ханшны хэлбэлзэлд тохируулга хийж хэрэглээний үнүүд өөрчлөгдсөн, мөн макро эдийн засгийн тэлэх бодлогуудаас үүдэх эрэлтийн дарамт нэмэгдэж байгааг илэрхийлж байна. 7 болон 9 дүгээр саруудын хооронд суурь инфляцийн үнүүд хурдасч байгаа нь дараах зүйлд ажиглагдсан: тээврийн үйлчилгээ (1.6 хувиас 3.6 хувь) орон сууцны бүтээгдэхүүний үнэ (3.9 хувиас 11.8 хувь), боловсролын зардал (16.1 хувиас 28.4 хувь). Эрчим хүчний үнүүд 2012 оны 5 сараас хойших үнээс 11.4 хувиар өсчээ. (Зураг 17).

Сүүлийн саруудад түрээсийн байрны үнүүд мөн өсч байгаа нь удирдлагууд анхаарлаа хандуулах хэрэгтэйг илэрхийлж байна. 8 дугаар сард орон сууцны түрээсийн үнийн индекс 20.1 хувиар, 9 дүгээр сард өмнөх үеийн мөн үетэй харьцуулбал 16 хувиар өсчээ. (Зураг 18) Бодлогын зээлийн хөтөлбөрүүдээр дамжуулан барилгын салбарын өсөлтийг бий болгож байгаа ч орон сууцны түрээсийн үнэ нэмэгдэж байгаа нь анхаарлаа хандуулахыг шаардаж байгаа бөгөөд энэ нь үл хөдлөх хөрөнгийн үнүүд нэмэгдэж байгаагийн дохио болох талтай. Засгийн газар болон мөнгөний удирдлагууд аль алин нь орон сууцны зах зээлийн талаар илүү мэдээллийг (жишээ нь орон сууцны үнийн үзүүлэлтүүд) цуглуулж, хяналт тавих хэрэгтэй байна.

Зураг 21. Суурь инфляци сүүлийн саруудад эргээд өсөх хандлагатай боллоо …

Хүнсний бус, эрчим хүчний бус гол нэрийн бүтээгдэхүүний



үнүүд (өөх, %)

Зураг 22. Түрээсийн үнүүд мөн өсч байна

Орон сууцны түрээсийн үнийн индекс, инфляци



Эх үүсвэр: ҮСХ эмхэтгэл, ДБ-ны мэргэжилтнүүдийн тооцоо

Ирэх саруудад инфляци өсөх хандлагатай байна. Зээл тэлж байгаа, мөнгөний бодлого суларч байгаа ч Монголбанк инфляцийг жилийн туршид нэг оронтой тоонд багтааж байна. Өнгөрсөн 11 сард эхлүүлсэн – Үнийг тогтворжуулах хөтөлбөр нь – гол үнүүдийг, тэдгээрийн нийлүүлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлтэйгээр санхүүгийн туслалцаа үзүүлэх замаар тогтвортой барихад дэмжлэг үзүүлсэн. Гэвч сүүлийн саруудад валютын ханш буурч байгаа нь импортын бүтээгдэхүүний өртөгийг нэмэгдүүлж, нийлүүлэгчдэд дотоодын үнээ бариад байхад төвөгтэй байдал үүсгэж байна. Валютын ханшны өнөөгийн байгаа байдал, макро эдийн засгийн тэлэх бодлогуудын нэмэлт дарамтаас үүдэж мөнгөний бодлогын удирдлагуудад инфляцийг нэг түвшинд барихад улам төвөгтэй болгох талтай.

Хайрцаг 3. Импортын барааны хэрэглээ болон суурь үнэ

Хэрэглээний сагс. 2010 оны үнэд суурилсан ХҮИ зах зээлийн сагсыг 11,323 өрхүүдээс Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаагаар цуглуулсан зарлагын мэдээлэлд үндэслэдэг бөгөөд уг судалгааг ҮСХ нь 2007[6] оноос хийж эхэлж байна. ӨНЭЗС-аас гадна, Монголын өрхүүдийн өөрсдийн орлогын түвшиндээ тааруулан бараа үйлчилгээний хэрэглээг төлөөлөх сагсыг тодорхойлох зорилгоор ҮСХ нь импорт болон аж үйлдвэрлэлийн тоо мэдээлэлд судалгаа хийдэг. Уг судалгааг ҮСХ нь 5 жил тутамд шинэчилдэг. Одоогийн сагс нь 12 бүлгийн 329 бараа, үйлчилгээнээс бүрдэж байна: хүнс болон ундаа, орон сууц, хувцас хэрэгсэл, тээвэр, эрүүл мэндийн үйлчилгээ, амралт, боловсрол, харилцаа холбоо болон бусад бараа үйлчилгээнүүд.

Импортын хэрэглээний бараа. ХҮИ-ийн сагсны хүнсний хэсэгт, 52.7 хувь нь импортын бараа, 47.3 хувь нь дотоодод үйлдвэрлэгдсэн бараа ордог. Хүнсний бус 235 хэрэглээний бараанаас, 55 хувь нь импортлогддог байна. Эдгээр импортын бараа нь хятадын юань болон бусад валютаар худалдан авагдаж, дотоодын хэрэглэгчдэд дотоодын мөнгөн тэмдэгтээр очдог. Энэхүү импортлогдсон бүтээгдэхүүнд хамааралтай хэрэглээтэй байгаа нь дотоодын аж үйлдвэрлэлийн хүчин чадал хязгаарлагдмал, мөн уул уурхайн экспортын өсөлт хүчтэй биш үед өсч байгаа эдийн засагт худалдаааны алдагдлыг улам нэмэгдүүлж байгааг тайлбарлаж байна. Мөн сүүлийн саруудад ханшны хурдацтай сулралт нь импортлогдсон инфляцийн дарамтыг өсгөх талтай боллоо, ялангуяа импортлогдсон барааны борлуулалтын үнийн бодит зохицуулалт болон мөнгөн тэмдэгтийн ханшны уналтын хооронд цаг хугацааны хоцрогдолтой байгааг илэрхийлж байна.

Зохицуулалттай үнэ. Засгийн газраас 2013 оны 8 дугаар сараас цахилгаан дулаан, эрчим хүч, усны хураамжийг нэмэгдүүлсэн. Эрчим хүч болон усны төлбөр нь Монгол улсад “суурь үнэ” гэж нэрлэгдэх бөгөөд Засгийн газрууд эдгээр үнүүдийн үнийг нэмэх дургүй байдаг учир нь цахилгаан, усны үнүүд нэмэгдснээр бусад

[6] Өрхийн орлого зарлага болон амьжиргааны түвшний судалгаануудыг нэгтгэж өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа болгосон.

барааны үнүүд нэмэгдэнэ гэсэн асуудал гардаг. Саяхны энэ шийдвэрээс өмнө Засгийн газар 2010 оноос хойш 2-хон удаа өсгөсөн; 2010 оын 6 дугаар сард 16.6 хувиар мөн 2011 оны 5 дугаар сард 5.5 хувиар нэмэгдэж үйлдвэрлэлийн өртөгийн өсөлтийг шингээсэн. Эдгээр суурь үнүүд өссөн нөлөө нь бусад бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртөгийг нэмэгдүүлж (аж үйлдвэрлэлийн болон хөдөө аж ахуйн), ирэх саруудад бусад хэрэглээний үнүүдийг өсгөх талтай.

Эх үүсвэр: ДБ мэргэжилтнүүд

Ажил эрхлэлт

Ажиллах хүчний судалгааны тоо мэдээллээс харахад, хоёрдугаар улиралд ажилгүйдэл буурсан байна. Албан ёсны ажилгүйдлийн тоо нь – Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний төвд бүртгэгдсэн ажилгүйчүүдийн хоёр хувийг багтаадаг бөгөөд – уг тоогоор ажилгүйдлийн түвшин нь 2013 оны 1 дүгээр сард 3.4 хувь байснаа 8 дугаар сард 3.0 хувь болсон байна. Гэвч энэ тоо нь ажилгүйдлийн жинхэнэ түвшинг дутуу харуулах хандлагатай бөгөөд зарим хүмүүс удирдлагуудад ажилгүй гэдгээ бүртгүүлдэггүй байх талтай. Энэ ч утгаар, Ажиллах Хүчний Судалгаа (АХС)[7] нь ажилгүйдлийн түвшингийн талаар илүү тод харуулдаг.

ҮСХ-оос гаргасан сүүлийн АХС-ны тоогоор ажилгүйдлийн түвшин эхний улиралд 9.3 хувь байснаа хоёрдугаар улиралд 7.3 хувь болсон байна. (Зураг 19) Нийт ажиллах хүч нь 1.2 сая хүн байдаг бөгөөд эмэгтэйчүүд нь 602 мянга буюу нийт ажиллах хүчний бараг тал хувь нь байдаг. Эмэгтэй ажиллах хүчний ажилгүйдлийн түвшин нь 9.7 хувиас 7.6 хувь болж буурсан бол эрэгтэйчүүдийнх 6.9 хувь байсан.

Зураг 23. Хөдөлмөрийн зах зээлийн гол үзүүлэлтүүд



Эх үүсвэр: ҮСХ, Улирлын ажиллах хүчний судалгаа, ДБ-ны мэргэжилтнүүдийн тооцоо

Зураг 24. Ажилгүйдэл, хүйсээр



Ажил эрхлэлтийн төрлөөс харахад, хэдийгээр ажилгүйдлийн түвшин буурч байгаа ч ажлын чанарын асуудал муудаж байх талтай. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн – голдуу жижиг хэмжээтэй, гэртээ хийдэг бизнес буюу мухлаг, жижиг лангуу ажиллуулдаг– нийт ажил эрхлэлтэд

[7] АХС нь бүртгэлтэй болон бүртгэлгүй ажилгүйчүүдийг аль алиныг нь гаргадаг.

эзлэх хувийн жин нь өмнөх улиралд 16.5 хувь байснаа хоёрдугаар улиралд 22.2 хувьд хүрсэн байна. Энэ хугацаанд мөн хөлс авдаггүй гэрийн ажиллагсадын эзлэх хувь 1.7 хувь байснаа 3.3 хувь болсон. Мөн цалинтай ажиллагсадын эзлэх хувь 51.6 хувиас 47.5 хувь болж бууран цалинтай ажиллагсадын хэмжээ нь ойролцоогоор гурван мянган хүнээр багасчээ. Энэ нь бизнесийн төлөв байдал муудаж байгаагаас томоохон, илүү албан ёсны бизнесийн байгууллагууд хязгаарлагдмал болохын хирээр жижиг гэр бүлийн эсвэл хувиараа эзэмшдэг бизнесээр (жишээ нь, мухлаг лангуу) өсч буй ажиллах хүчин шингээгдэж байна.

Ажил эрхлэлтийг салбараар нь үзвэл ажиллах хүчин хөдөө аж ахуйн бус салбарууд руу шилжиж байгаа бөгөөд уул уурхайн салбар хүндрэлтэй байгааг үзүүлж байна. Хоёрдугаар улиралд нийт ажил эрхлэлтийн 29 хувь нь хөдөө аж ахуйд ажиллаж байсан боловч нийт ажил эрхлэлтийн эзлэх хувийн жин нь 2007 онд 42 хувь байснаа буурах хандлагатай байна. Уул уурхайн салбарын эзлэх хувийн жин нь 2010 оноос нийт ажил эрхлэлтийн ойролцоогоор 4 хувь байсан боловч (Зураг 21), уул уурхайн салбарын ажиллагсадын хэмжээ нь хоёрдугаар улиралд 11 хувиас (өмнөх жилтэй харьцуулбал) 20.7 хувь болж (өмнөх улиралтай харьцуулбал) буурсан нь бизнесийн сул төлөв байдлыг илэрхийлж байна. Нүүрсний салбарын ажиллах хүч нь 1 дүгээр сараас 9 дүгээр сарын хооронд 120 хүнээр багассан. Металын хүдрийн салбар буюу зэсийн үйлдвэрлэл мөн ордог салбарт ажиллагсадын өсөлт мөн удааширсан: 2013 оны эхний 7 сард металын хүдрийн үйлдвэрлэлд ажиллагсадын тоо нь 4,700 гаран хүнээр өссөн. Хэдийгээр 8 болон 9 дүгээр саруудад аж үйлдвэрлэлд ажиллагсадын тоо нь удаан хурдацтайгаар нэмэгдэж байгаа ч сүүлийн өнгөрсөн хоёр сарын хугацаанд 165 хүнээр өсчээ.

Хоёрдугаар улирлын туршид барилга, аж үйлдвэрлэл болон бөөний/жижиглэнгийн худалдааны салбарт ажиллагсадын тоо нэмэгдсэн (зураг 22). Хоёрдугаар улиралд барилгын ажиллагсадын тоо 17 хувиар (өмнөх улиралтай харьцуулбал) мөн 20 хувиар (өмнөх жилтэй харьцуулбал) тус нэмэгдсэн нь уг хугацаанд барилгын салбарын өсөлт байсныг харуулж байна. Аж үйлдвэрлэл болон бөөний/жижиглэнгийн салбар нь илүү ажиллагсадыг авч ажиллуулсан нь хувиараа ажиллагсадын тоо өсч байгааг илэрхийлэх талтай.

Зураг 25. Ажил эрхлэлт, салбараар

Нийт ажил эрхлэлтийн салбараар эзлэх хувь (%):
2013 оны 2 дугаар улирал



Зураг 26. Голлох салбараар ажиллах хүчний өөрчлөлт

Голлох салбаруудад ажиллаж байгаа ажиллагсадын тоо(мянган хүнээр)



Эх үүсвэр: УСХ, Улирлын ажиллах хүчний судалгаа, ДБ-ны мэргэжилтнүүдийн тооцоо

Мэдээллийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалж, албан ёсны тоо мэдээ нь хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлыг төдийлөн бодитоор харуулахгүй байх талтай. Хэдийгээр албан ёсны мэдээгээр ажилгүйдлийн түвшин буурч сайжралт гарч байгаа боловч уул уурхайн салбарын хүндрэл нь хөдөлмөрийн зах зээлд нөлөө үзүүлж, санаа зовоож байна. Нүүрсний зах зээлийн хэтийн төлөв сул байгаатай холбоотойгоор нүүрсний зарим компаниуд үйл ажиллагааныхаа зардлыг бууруулах тал дээр ажиллаж, ажиллагсадаа халах талтай. 7 дугаар сард ОТ уурхай нь уурхайн газрын гүний хөрөнгө оруулалт хойшлогдсонтой холбогдуулан 1,700 гаран ажиллагсадаа халах болно гэж мэдэгдэж байсан. Хөдөлмөрийн зах зээлд нөлөөлсөн өөр нэг үзэгдэл нь 9 дүгээр сард “Нарантуул” хар захад гал гарсан нь уг зах дээр ажилладаг даатгалгүй, найдваргүй хөдөлмөрийн нөхцөл байдалд ажилладаг, тэдгээрийн ихэнх нь эмэгтэйчүүд байдаг гэж мэдэгдэж байгаа бөгөөд тэдгээрт гэнэтийн алдагдал авчирсан. Зарим салбаруудад хөдөлмөрийн нөхцөл байдлыг чангатгасан нь нийт хөдөлмөрийн тоо мэдээнээс харагдахгүй байгаа бөгөөд түр зуурын ажил эрхлэлт нэмэгдэж байгаа нь (жишээ нь барилгын үйл ажиллагаа, төрийн засварын ажил эхлэх зэргээр) ажилгүйчүүдийг шингээж байх талтай.

Төсвийн байдал болон хэтийн төлөв

Төсвийн бодлого нь их хэмжээний төсвөөс гадуурхи зарлагын улмаас тэлэлтийн байдалтай хэвээрээ байна. 2013 оны төсвийн гүйцэтгэл нь төсвийн бодлогын бодит нөхцөл байдлын талаар холимог, магадгүй буруу дохио болсон. Нэг талаас төсвийн жинхэнэ гүйцэтгэлээс төлөвлөж байснаас бага орлого авсан. Мөн өнгөрсөн 2012 оны 11 сард гаргасан Чингис бондын орлогыг ашиглан Монгол улсын хөгжлийн банкаар (МУХБ) дамжуулан төсвөөс гадуурх зарлага огцом нэмэгдсэн. Хэдийгээр МУХБ-ны зарлагын талаарх албан ёсны тоо мэдээлэл нийтэд хүртээмжгүй байгаа ч нийт төсвийн бодлого нь төсвөөс гадуурхи зарлагаар дамжин тэлэлтийн байдалтай хэвээрээ байгаа бөгөөд төсвийн алдагдал нь МУХБ-ны төсвөөс гадуурхи зарлагыг оруулан тооцвол ДНБ-ий 12 гаран хувьд хүрэх бөгөөд өмнөх жилийн түвшингээс өндөр болно (10.9 хувь).

Төсвийн албан ёсны зарлага – энэ нь МУХБ-ны хийсэн зарлагыг хасаад– нь болгоомжлох түвшинтэй байгаа нь орлого нь төлөвлөж байснаас нэлээд их хэмжээгээр бага байгаатай холбоотой. Төсвийн зарлагын гүйцэтгэл бага байсантай холбоотойгоор албан ёсны төсвийн тэнцэл 5 сар хүртэл ашигтай байсан боловч 6 сараас эхлэн алдагдалтай болж хувирсан. 1 дүгээр сар болон 9 сарын хооронд нийт төсвийн алдагдал нь 93 тэрбум төгрөг байгаа нь – өмнөх оных буюу 531 тэрбум төгрөгөөс хамаагүй доогуур байна.

- **Өсөлт харьцангуй сайн байгаа ч төсвийн орлогын гүйцэтгэл нь таамаглаж байснаас нэлээд сул байна.** Эхний 9 сарын байдлаар, нийт төсвийн орлого нь (3.5 их наяд төгрөг) төсөвлөсөн жилийн орлогын (7.3 их наяд төгрөг) зөвхөн 55 хувь нь байна. Өнөөгийн хурдаар, жилийн төсвийн орлогын дутагдал нь төлөвлөгдсөн төсвийн орлогын 15-20 хувьд хүрэхээр байгаа бөгөөд энэ нь манай сүүлийн Монгол улсын эдийн засгийн улирлын тоймын орлогын төсөөлөлтэй ойролцоо байна. (2013 оны 4 сар). Орлогын дутагдал нь голдуу худалдаа болон уул уурхайтай холбоотой татварын орлогууд хүлээгдэж байснаас бага байгаатай холбоотой (Зураг 23).

- **Төсвийн орлогын дутагдалтай байх нь өмнө нь таамаглагдаж байсан бөгөөд учир нь төсвийн орлогын таамаглалыг хэт өөдрөг, бодитой бус таамаглал дээр үндэслэн бэлтгэсэн байсан.** 2013 оны төсөв нь худалдааны талаарх хэт өөдрөг таамаглал дээр үндэслэн татварын орлогыг хэт өндрөөр тооцоолсон байсан нь импортын НӨТ болон гаалийн хураамжид ихээхэн хэмжээний дутагдал бий болоход хүргэлээ. Оюу толгой компаниас нэмэлт орлого (445 тэрбум төгрөг) оруулсан нь – төсвийг бэлтгэх явцад тодорхойгүй, маргаантай байсан нь– татварын төлбөрийг оруулаад хэд хэдэн асуудал дээр сунжирсан хэлэлцээрийн улмаас орлогын зайлшгүй дутагдалд хүрсэн.

Зураг 27. Төсвийн орлогын дутагдал их байна

2013 оны орлогын өсөлт 2012 оны гүйцэтгэлээс (%): 2013 оны төсвийн төсөөлөл болон жинхэнэ гүйцэтгэл (1 сараас- 9 сар)



Эх үүсвэр: УСХ, ДБ мэргэжилтнүүд

- **Төсвийн гүйцэтгэл нь өмнөх үетэй харьцуулбал бага байгаа ч төсвийн удирдлагууд орлого сул байгаад болгоомжтой хандсан хэвээрээ байна.** Төсвийн илүү болгоомжилсон гүйцэтгэлтэй байгааг: 1 дүгээр сараас 9 сарын хооронд хийгдсэн хөрөнгийн зарцуулалтын гүйцэтгэлээс харж болох бөгөөд энэ нь нийт жилийн төсвийн зарцуулалтын төлөвлөгөөний 32 хувь нь байна. Мөн эхний 9 сарын байдлаар урсгал зардлын 65 хувь нь хийгдсэн байна (Зураг 24).

Зураг 28. Төсвийн гүйцэтгэл нэлээд доогуур байна



Зураг 29. Албан ёсны төсвийн алдагдал мөн харьцангуй бага байна



Эх үүсвэр: ҮСХ эмхэтгэл, ДБ-ны мэргэжилтнүүдийн тооцоо

Төсвийн орлогын ихээхэн хомсдолтой байгаатай уялдуулж, Засгийн газраас төсвийг сайжруулах төлөвлөгөөг зарласан бөгөөд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн (ТТБТХ) бүтцийн алдагдлын ДНБ-ий хоёр хувьд хүргэх шаардлагыг хангах зорилгоор 10 дугаар сард 2013 оны төсөвт тодотгол хийгдсэн. Төсвийн бүтцийн алдагдлын хоёр хувийн зорилтыг биелүүлэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- **Нэмэлт өөрчлөлт орсон төсөвт орлогын дутагдлыг 1.1 их наядад хүрнэ гэж таамагласан (анхны таамаглалын 14 хувь).** Нэмэлт өөрчлөлт орсон төсвийн төлөвлөгөөгөөр орлогын 920 тэрбумын дутагдлыг янз бүрийн эх үүсвэрээс нэмэлт татварын эх үүсвэр бүрдүүлэх замаар бүрдүүлэх (жишээ нь онцгой албан татвар, хөрөнгийн татвар, болон нийгмийн даатгалын шимэтгэл).

- **Төсвийн зарлагыг 10.9 хувиар бууруулах (814 тэрбум төгрөг).** Хөрөнгийн зардлыг 620 тэрбум төгрөгөөр бууруулах: (i) мэдэгдэхүйц дэвшил гаргаагүй улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг зогсоож 459 тэрбум төгрөг; (ii) гадаадын зээлээр санхүүжигдэх байсан ч хойшлогдсон 156 тэрбумын төслийг; мөн (iii) засвар үйлчилгээний зардалд 5 тэрбум төгрөгийг. Нэмэлт 234 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны зардлыг танах, хойшлогдсон гадаад өрийн зээлийн хүүгийн төлбөрийг бууруулах замаар багасгана. Зардлыг бууруулах хэмжээ нь төсвийн анхны сайжруулалт хийнэ гэж мэдэгдэж байсан хувилбараас бага байна (945 тэрбум төгрөг)

Сайжруулах төлөвлөгөө нь төсвийн илүү тогтвортой хүрээг бий болгоход дэвшил гарч байгааг харуулж байна. Зарлагын томоохон хэмжээний тохируулгын төлөвлөгөө нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зарчмыг дагах амлалтыг мөн харуулж байна. Шинээр хийгдсэн

төсвийн таамаглал нь өнөөгийн орлогын гүйцэтгэлийн хандлагыг илэрхийлж, илүү бодитой харагдаж байна. Гэвч удирдлагууд өнөөгийн орлогын гүйцэтгэл сул байгаа энэ үед нэмэлт татварын орлогыг олохоор төлөвлөсөн нь зарлагыг улам илүү танах хэрэгтэй болно.

Төсвийг ТТБТХуулийн шаардлагыг хангахын тулд чангаруулж байгаа боловч засгийн газрын ихээхэн хэмжээний зарлага нь төсвийн гадуур үлдэж байна. Монгол улсын хөгжлийн банкаар голчилон (МУХБ) дамжуулан Чингис бондын ихээхэн хувийг төсвөөс гадуурх хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдийг санхүүжүүлж байна. Хэдийгээр Чингис бондын орлогын зарцуулалтын талаар албан ёсны тоо байхгүй байгаа ч Ерөнхий сайдын хэвлэлийн бага хуралд хийсэн мэдэгдлээр Засгийн газар нь Чингис бондын орлогын (1.5 тэрбум ам.долларын) 0.7 тэрбум ам.долларыг– ДНБ-ий 6 орчим хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг 2013 оны 5 сараас 9 сарын хооронд хэрэглэсэн. Жилийн сүүлийн 4 сарын хугацаанд ойролцоогоор 0.2-0.3 тэрбум ам.долларыг зарцуулна гэж үзвэл Чингис бондын нийт зарлага нь 2013 онд ДНБ-ий 8 хувь орчимд байхаар байна.

Монгол улсын хөгжлийн банк нь 2012 оноос эхлэн төсвөөс гадуурхи төслүүдийг гүйцэтгэж байна. Санхүүжилтийн гол эх үүсвэр нь 2012 онд гаргасан 5 жилийн хугацаатай Евро бондын орлого[8] (580 сая ам.доллар) мөн Чингис бондын орлого юм. Дэлхийн банкны тооцож байгаагаар 2012 онд гаргасан Евро бондын (580 сая ам.доллар) орлогын 60 хувийг 2012 онд Хөгжлийн банк зарцуулсан мөн Евро бондын үлдсэн хэсгийг 2013 онд зарцуулж байна. МУХБ-аар дамжуулан зарцуулсан төсвөөс гадуурхи нийт зарлага нь (Чингис бондоор зарцуулсан төслүүдийг оролцуулаад) 2013 онд ДНБ-ий 10 орчим хувьд хүрэхээр байна. Бүх зарлагуудыг тооцвол, төсвийн нийт алдагдал нь ДНБ-ий 12 гаран хувьд хүрэхээр байна. Монгол улсын төсвийн алдагдал нь тус бүс нутаг дахь хөгжиж буй орнуудтай харьцуулбал онцгой өндөр байна (Зураг 28).

Төсвийн тэнцэл үргэлжилэн муудаж байгаа, мөн засгийн газрын зарлагын өсөлт хурдтай байгаа нь нийт эрэлтийг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцэл болон дотоодын үнэд дарамт үүсгэж байна. Засгийн газрын зарлагын ДНБ-д эзлэх хувийн жин (МУХБ-ны зарлагыг оролцуулаад) нь 2010 оноос хойш огцом өссөн: 2010 онд 36.6 хувь байснаа 2012 онд 46.7 хувь болсон. Харин 2013 онд, засгийн газрын зарлагын ДНБ-д эзлэх хувийн жин ДНБ-ий 47 гаран хувьд хүрэхээр байна. (Зураг 29). Үүнээс гадна, засгийн газрын орлогын ДНБ-д эзлэх хувийн жин нь ДНБ-ий 40 хувиас доогуур хэвээрээ байгаа бөгөөд 2013 онд 35-40 хувьд байхаар байна.

Их хэмжээний төсвөөс гадуурхи зарлага нь засгийн газрын төсвийн байдалд буруу дохио үүсгэх талтай. Төсвийн зарчмыг дагах амлалт болон албан ёсны төсвийг сайжруулах төлөвлөгөөнийхөө эсрэг, төсвөөс гадуурхи зардлыг гаргаж байгаа нь төсвийн нийт бодлогыг гурван жил дараалан хэт тэлэлтийн замд оруулаад байна (Зураг 26). Албан ёсоор буурууллахаар шинэчилсэн төсөв нь төсвийн бодлогыг хумиж байна гэсэн үг бус харин төсвөөс гадуурхи зарлагыг заавал оруулах ёстой; хөрөнгийн зарлага нь өнгөрсөн оны түвшингээс 30 гаран хувиар нэмэгдэхээр байгаа бөгөөд энэ өсөлт нь нэрлэсэн ДНБ-ийхөө өсөлтөөс хамаагүй өндөр байгаа юм. Чингис бонд нь Засгийн газрын шууд гадаад зээлжилтээр санхүүжигдэж байгаа бөгөөд бондын орлогыг ашиглан санхүүжих нь төсвийн алдагдлыг тэр хэмжээгээр нэмэгдүүлэх ёстой. МУХБ-ны төсвөөс гадуурхи зарлагыг оруулахгүйгээр төсвийг өнөөгийн байдлаар удирдах нь (ялангуяа Чингис бондын орлогыг) Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон төсвийн удирдлагын олон улсын зарчмуудтай уялдахгүй байна. Чингис бонд болон МУХБ-аар санхүүжигдэж байгаа төслүүдийн талаар сар бүрийн тайланг төсвийн албан ёсны тоо мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар гаргадагтай адил хэвлэн гаргаж байх нь чухал, учир нь тэдгээрийн макро эдийн засагт үзүүлэх төсвийн дарамт өндөр билээ.

[8] МУХБ нь 5 жилийн хугацаатай Евро бондыг (580 сая ам.долларыг) 2012 оны 3 дугаар сард 5.75 хувийн хүүтэй гаргасан өмнө нь 2011 оны 12 сард эхний 20 сая ам.долларын Евро бондыг гаргасан (нэг жилийн хугацаатай 6 хувийн хүүтэй).

Зураг 30. Төсвөөс гадуурхи зарлага нэмэгдэж байна

*Эх үүсвэр:*ҮСХ эмхэтгэл, ДБ мэргэжилтнүүдийн тооцоо

Зураг 31. Төсвөөс гадуурхи зарлагыг оролцуулаад төсвийн нийт тэнцэл ДНБ-ий 12 гаран хувийг эзлэх болно



Зураг 32. Монгол улсын төсвийн алдагдал нь Зүүн Азийн орнууд дотроо хамгийн өндөр нь байна



Зураг 33. Засгийн газрын зардлын ДНБ-д эзлэх хувь ДНБ-ий 47 хувиас давахаар байна



*Эх үүсвэр:*ҮСХ эмхэтгэл, ДБ мэргэжилтнүүдийн тооцоо

Хайрцаг 4. Төсвөөс гадуурхи зарлага болон Чингис бонд

Төсвөөс гадуурхи зарлага. Төсвөөс гадуурхи зарлага гэдэг нь засгийн газрын зарлага боловч эдгээр нь албан ёсны төсөвт бүртгэгдээгүй зарлагаар тодорхойлогдоно. Зарчмын хувьд, засгийн газрын бүх зарлагууд– засгийн газрын татварын/ татварын бус орлого болон зээллэгээр санхүүжигдэж байгаа зарлагыг– төсвийн зарлага гэж бүртгэгдэх ёстой. Тухайн санхүүгийн жилд засгийн газрын төсвийн зарлага нь нийт орлогоос (мөн тэтгэмж) давж гарч байвал төсвийн алдагдал үүснэ. Уг алдагдал нь голдуу дотоодын зээллэг (жишээ нь засгийн газрын бонд эсвэл төв банкны зээл) эсвэл гадаад эх үүсвэрээр (жишээ нь засгийн газрын гадаад бонд) санхүүжигддэг. Засгийн газрын зээллэг нь засгийн газрын орлого маягаар бүртгэгдэхгүй (шугамнаас дээш) харин хувь хүмүүс банкнаас зээлсэн мөнгөө өөрийн орлогын нэг хэсэг гэж үздэггүйтэй адилаар санхүүгийн ажил гүйлгээ гэж (шугамнаас доогуур) бүртгэх ёстой.

Төсөвт байгаа бүхий л зарлага, орлого болон санхүүгийн ажил гүйлгээг бүртгэх нь маш чухал учир нь энэ нь тухайн улсын засгийн газрын үйл ажиллагаа (эсвэл сангийн бодлого) нь төсвөөр дамжин хэрхэн эдийн засагт нөлөө үзүүлж байгааг болон засгийн газрын санхүүгийн өр төлбөр үүний үр дүнд хэрхэн өөрчлөгдөж болохыг харуулдаг. Зарчмын хувьд, хэрвээ засгийн газар нь өөрийн орлогоос илүүг зарвал (өөрөөр хэлбэл төсвийн алдагдал), засгийн газар зээлээр эдийн засгаа урамшуулж байна гэсэн үг. Иймээс хэрвээ засгийн газрын

өрөөр санхүүжүүлж байгаа хэсэг нь төсөвт бүртгэгдэхгүй байвал тухайн засгийн газрын үйл ажиллагааны эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг дутуу үнэлэн, зээлээр санхүүжүүлж байгаа бодит зарлагыг(мөн төсвийн алдагдал) бууруулж байгаа бөгөөд сангийн бодлогын бодит тэлэлтийг дутуу харуулна.

Чингис бонд. Монгол улсын хувьд, Чингис бонд нь төсвөөс гадуурхи зарлагын маргааны төв нь байсаар ирсэн. Чингис бондыг 2012 оны 11 сард Засгийн газар шууд гаргасан бөгөөд бондыг татвар төлөгчдийн мөнгөөр 2017 болон 2022 онд эргэн төлөх ёстой. Иймээс Чингис бондын орлогыг засгийн газар хүлээн авахдаа санхүүгийн гүйлгээтэй адил авч үзэх ёстой (энэ нь засгийн газрын гадаад өр төлбөрийг нэмэгдүүлж, Төв банк дахь засгийн газрын хадгаламжийг харгалзан нэмэгдүүлнэ). Засгийн газар орлогыг ашиглан тодорхой төслүүдийг санхүүжүүлэхээр эхэлсэн бол бондын орлого нь засгийн газрын хадгаламжаас гарах бөгөөд уг хэмжээг нь төсвийн зарлага байдлаар бүртгэгдэх ёстой – эсвэл шууд зардлаар (хэрвээ энэ нь шууд засгийн газраас зарцуулсан бол) эсвэл Монгол улсын хөгжлийн банкинд өгсөн цэвэр зээллэгээр (хэрвээ энэ нь МУХБ-д шилжиж, уг банк улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлж байгаа бол). 2012 онд гаргасан МУХБ-ны бонд нь засгийн газрын шууд баталгаатайгаар гаргасан бондтой адилхан. МУХБ бондын орлогыг ч мөн хугацаа нь дуусахаар МУХБ хөрөнгө оруулсан төслүүдээсээ эргэн төлөх санхүүгийн үр өгөөж босгож чадахгүй бол татвар төлөгчдийн мөнгөөр эргэн төлөх ёстой. Иймээс Чингис бонд болон МУХБ-ийн санхүүжүүлж байгаа төслүүдийг албан ёсны төсвөөс гаргах нь засгийн газрын зарлагын хэмжээ болон төсвийн алдагдлын хэмжээг дутуу тайлагнаж байна гэсэн үг.

Эх үүсвэр: ДБ-ны мэргэжилтнүүд

Улсын өр нэмэгдэж байна. (Зураг 30) Монгол улсын өр 2012 онд 8.8 их наядад хүрсэн – энэ нь ДНБ-ий 63 хувьтай тэнцүү. Энэ нь 2011 онд 4.3 их наяд байсан бол нэмэгдэж ДНБ-ий 30 хувиас илүү гарсан. Гадаад өр 2011 онд 2.2 тэрбум ам.доллар байснаа 2012 онд 4.8 тэрбум ам.долларт хүрч бараг хоёроос илүү дахин нэмэгдсэн нь нийт улсын өрийн 77 хувийг, ДНБ-ий 48 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн жилийн гаргасан гадаад бондуудыг, үүнд, Чингис бонд (1.5 тэрбум ам.доллар) мөн МУХБ-ны бонд (580 сая ам.доллар) илэрхийлж байна. Үүний үр дүнд гадаад өрийн бүтцэд томоохон өөрчлөлт гарсан. 2012 он хүртэл, улсын гадаад өрийн дийлэнх нь хөнгөлөлттэй зээл байсан– энэ нь 2011 онд улсын нийт гадаад өрийн 56 хувь байсан. Гадаад өрийн олон талт зээлдүүлэгчээс (жишээ нь, ДБ, АХБ, ОУВС) авсан хөнгөлөлттэй зээлийн эзлэх хувийн жин нь 2012 онд огцом 26 хувь хүртэл буурсан, мөн арилжааны зээлийн гадаад өрд эзлэх хувийн жин нэг жилийн өмнө 0.2 хувь байснаа 2012 онд 43 хувьд хүрсэн байна. Албан ёсны хоёр талт өрийн нийт өрд эзлэх хувь 24 хувийг эзэлж байна. Дотоод өр 1.2 их наядаас 2 их наядад хүрч өссөн нь голдуу төсвийн алдагдлыг санхүүжүүлэхээр гаргасан засгийн газрын бондын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой. Алдагдлыг санхүүжүүлэхээр дотоодын өрийг нэмэгдүүлж байгаа болон валютын ханшны сулралтаас үүдэж улсын өрийн ДНБ-д харьцуулах харьцаа 2013 онд цаашид нэмэгдэхээр байна.

Улсын өрийн түвшин хурдацтай өсч байгаа энэ үед удирдлагууд өрийн удирдлагын үр дүнтэй стратеги боловсруулах тал дээр илүү анхаарлаа хандуулах ёстой. Арилжааны нөхцөлтэй гадаад өр нэмэгдэж байгаагаас улсын өрийн өртөг болон эрсдлийг илүү урагшаа харсан байдалтайгаар удирдаж, нарийн хяналт, шинжилгээ, төлөвлөлтийг шаардаж байна. Удирдлагууд цаашдаа яамдуудын хооронд илүү хүчтэй зохицуулалттайгаар албан ёсны өрийн удирдлагын хэвлэгдсэн хүрээнд гадаад өрийн шийдвэрийг гаргаж байх ёстой. Гадаадын, арилжааны зээлээр санхүүжигдэж буй улсын зарлагад зээлийн дарамт илүү хүнд учир орлого бий болгох төслүүдийг санхүүжүүлэхээр тэргүүлэх чиглэлүүдийг гаргах ёстой. Дунд хугацааны макро эдийн засгийн бодлогын хүрээ нь улсын өрийн удирдлагад томоохон нөлөөтэй. Өнөөгийн гадаад өрөөр санхүүжигдэх, төсвөөс гадуурхи зарлагын схем дээр суурилсан төсвийн сул бодлогыг үргэлжлүүлэх

нь улсын өрийн түвшинг улам нэмэгдүүлж, дунд болон урт хугацаанд өрийн дарамтын эрсдлийг өсгөнө.

Зураг 34. Улсын өрийн ДНБ-д эзлэх хувь 2012 онд 63 хувьд хүрсэн

Дотоодын өрийн ДНБ-д харьцуулсан харьцаа (%)



Зураг 35. Хөрөнгийн зардал хурдацтай өсч байна

Хөрөнгийн болон урсгал зарлагын ДНБ-д харьцуулсан харьцаа



(%)

*Эх үүсвэр:*YCX эмхэтгэл, ДБ мэргэжилтнүүдийн тооцоо

Сүүлийн жилүүдэд хурдацтайгаар хийгдсэн зарлага нь дийлэнхдээ хөрөнгийн зарлагад төвлөрч байна. Нэрлэсэн хөрөнгийн зардал нь 2002-2012 оны хооронд 27 дахин нэмэгдсэн байхад нэрлэсэн ДНБ энэ арван жилд 9 дахин нэмэгдсэн байдаг. Үүний үр дүнд хөрөнгийн зардлын ДНБ-д эзлэх хувийн жин нь 2002 онд 4.4 хувь байснаа 2012 онд 13.4 хувьд хүрсэн байна. Хөрөнгийн зардлын өсөлтийн хурдац сүүлийн хоёр жилийн хугацаанд хамгийн хурдацтай өссөн: 2012 онд хөрөнгийн зардлын түвшин нь 2010 оны түвшнээс гурав дахин нэмэгдсэн. 2013 онд төсвөөс гадуурхи улсын хөрөнгө оруулалтаас үүдэж хөрөнгийн зардал нь 2012 оныхоос бараг хоёр дахин нэмэгдэхээр байгаа бөгөөд, ДНБ-ий 20 гаран хувьд хүрэхээр байна (Зураг 31).

Дэд бүтэц султай хөгжиж буй орнуудад улсын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь чухал. Гэхдээ хөрөнгийн огцом өсөлт нь хэд хэдэн асуудлыг үүсгэдэг:

- **Хөрөнгийн зардлын огцом өсөлт нь тухайн эдийн засгийн үйлдвэрлэлийн хүчин чадлаас давж гаран, төлбөрийн тэнцлийн дарамт болон барилгын өртөгийн инфляцийг нэмэгдүүлдэг.** Сүүлийн хоёр жилийн хугацаанд, барилгын материалыг нийлүүлэх дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадал нь өсөн нэмэгдэж байгаа эрэлттэй нь нийцэхгүй байснаас барилгын материалын импорт бараг хоёр дахин нэмэгдсэн байна. Дэлхийн банкны саяхны судалгаанаас харахад[9] бүртгэлтэй зам барилгын 186 компаниас зөвхөн 59 нь идэвхитэй үйл ажиллагаатай бөгөөд эдгээрийн 59-оос 10 нь л 2011 оны барилгын улирлын үед 50 км-ээс урт зам барих хүчин чадалтай байсан байна. Дотоодын хүчин чадал дутагдалтай байснаас сүүлийн гурван жилийн хугацаанд (2010-2012) гол нэрийн барилгын материалуудын үнүүдийг огцом нэмэгдүүлсэн; Дэлхийн банкны тооцоогоор, төмөр бетоны үнэ 82 хувиар, тоосгоны үнэ 80 хувиар мөн цементын үнэ 64 хувиар өссөн.

[9]Монгол улс: "өсөн нэмэгдэж буй дэд бүтцийн асуудлыг шийдэхийн тулд улсын хөрөнгө оруулалтыг сайжруулах нь", 2013 оны 1 дүгээр сар, Дэлхийн банк

- **Улсын хөрөнгө оруулалтын төслүүд хурдацтай өсөх нь тэдгээрийг бэлтгэх, хэрэгжүүлэх Засийн газрын хязгаарлагдмал байгаа хүчин чадалд улам хүндрэл учруулж байна.** Шинэ төсөл нэмэгдэж байгаа нь Засгийн газрын төслийг бэлтгэх хүчин чадлаас хэтэрч, өрсөлдөөнт тендер зарлах гэхээсээ илүүтэйгээр шууд гэрээг ашиглах хандлага нэмэгдэж байна. Хэдийгээр тоо мэдээлэл байхгүй ч ихэнх төсвөөс гадуурхи төслүүд нь шууд гэрээгээр хийгдэж байх шиг байна. 2013 оны төсвийн хөрөнгийн зардал их хэмжээгээр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь хийгдэх ажил нь хэдийнээ засгийн газрын хүчин чадлаас давсан, шинэ хөрөнгө оруулалтыг гүйцэтгэх эдийн засгийн хүчин чадлаас хэтэрснийг харуулж байна. Чингис бондоор төсвөөс гадуурхи томоохон хөрөнгө оруулалтыг хийлгэж байгаа үед, барилгын хүчин чадал нь их хэмжээний энэхүү төсвөөс гадуурхи төслүүдийг шингээж, илүү ил тод улсын худалдан авалтын үйл явц шаардсан төсөвт байгаа төслүүдийг шахан гаргаж байна.

- **Өөр нэг асуудал нь ихэнх төслүүдийг их хурлаар хэлэлцүүлдэг бөгөөд тэдгээрийн ихэнх хэсэг нь оновчтой төслийн бэлтгэл, үнэлгээ дутагдалтай байх талтай.** Сүүлийн үеийн Дэлхийн банкны судалгаагаар[3] 2008 онд их хурал шинэ төслүүдийн тоог 60 хувиар нэмэгдүүлсэн, мөн тухайн жилийн хөрөнгийн зардлыг 25 хувиар өсгөсөн нь хөгжиж буй болон ЭЗХАХОрнуудын стандартаас аль алинаас нь онцгой өндөр оролцоо юм. Мөн судалгаагаар, эдгээр төслүүд нь салбарын яамдуудын баримталдаг схемүүдээс дутуу бэлтгэгдсэн, техникийн үндэслэл болон өртөгийн үнэлгээ зэрэг үндсэн баримтууд голдуу дутагдаж байгааг харуулжээ.

Мөнгөний болон банкны салбар

Монголбанк 2013 оны эхэнд хувийн салбарын зээлийн өсөлт удааширч байхад түүнийг дэмжиж, эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор мөнгөний хүчтэй бодлого явуулж эхэлсэн. 2012 оны эцэст, мөн энэ оны эхэнд дотоодын эрэлт удааширсан учраас мөнгөний бодлогын удирдлагууд 2013 оны 1 дүгээр сараас эхлэн мөнгөний хэд хэдэн бодлогуудыг боловсруулсан: (i) хүүг 1, 3 болон 6 саруудад 13.25 хувиас 10.5 хувь болгож 275 нэгжээр бууруулсан; (ii) 3 тэрбум төгрөг гаран хэмжээний мөнгөний сулруулах бодлогыг бодлогын янз бүрийн сувгуудаар дамжуулж хийсэн (ДНБ-ий 20 хувьтай тэнцэх).

Мөнгөний бодлогын сулралт нь дараах бодлогын зээлийн хөтөлбөрүүдээр дамжин хийгдсэн: (i) 718 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2012 оны 11 сараас эхлэн Үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд сонгосон салбаруудад олгосон; (ii) 5 сараас эхлэн нэг жилийн хугацаатай 900 тэрбум төгрөгийн хадгаламжийг банкуудад хөрвөх чадварыг нэмэгдүүлэхээр олгосон; мөн (iii) бага хувийн хүүтэй орон сууцны зээлд 1.1 тэрбум төгрөгийг, барилгын компаниудад 430 тэрбум төгрөгийн зээлийг 6 сараас эхлэн барилгын болон орон сууцны салбарын хөгжлийг дэмжих хөтөлбөрөөр (Хайрцаг 4, Хайрцаг 5) тус тус олгосон. Эдгээр арга хэмжээнүүдийн үр дүнд, төв банкны арилжааны банкуудад олгосон зээлийн өрийн үлдэгдэл нь Үнийг тогтворжуулах хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2012 оны 11 сараас эхлэн өнгөрсөн 11 сард 181 тэрбум төгрөг байснаа 3.4 их наядаар нэмэгдэж – 2013 оны 9 сард 3.6 их наяд төгрөгт хүрчээ. (Зураг 32)

Зураг 36. Төв банкнаас арилжааны банкуудад хөрвөх чадварыг нэмэгдүүлэхээр мөнгө оруулсан нь хувийн салбарын зээлийн өсөлтийг хурдасгаж байна

Private Sector Credit and Central Bank loan to Banks



Эх үүсвэр: МБ, ДБ-мэргэжилтнүүдийн тооцоо

Зураг 37. Түс бүс нутагийн хөгжиж буй бусад эдийн засагтай харьцуулбал зээлийн өсөлт өндөр, хэлбэлзэл ихтэй байна …

Domestic Credit Growth (in percent, year-on-year)



Эх үүсвэр: МБ, ДБ-мэргэжилтнүүдийн тооцоо

Зураг 38….мөн дотоодын зээлийн ДНБ-д харьцуулсан харьцаа өсч байна …

Дотоодын зээлийн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа (засгийн газрын оруулаад, %)



Мөнгөний сул бодлого нь дотоодын болон хувийн салбарын зээлийг өсөлтийг хурдасгасан. Улсын төсвийн нэхэмжлэлийг оруулаад дотоодын зээлийн нийт үлдэгдлийн хэмжээний өмнөх жилтэй харьцуулсан өсөлт нь тогтмол өсч өнгөрсөн оны 12 сард 29.4 хувь байснаа 9 сард 61.6 хувьд хүрчээ. Банкуудын хувийн салбарт өгсөн зээлийн өсөлт нь 2012 оны эцэст 26 хувь байснаа 9 дүгээр сард 48.6 хувь болжээ. Сүүлийн саруудад өссөн Монгол улсын зээлийн өсөлт нь тус бүс нутгийн голлох эдийн засгуудын дотор хамгийн өндөр байна (Зураг 33). Дотоодын зээлийн өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 3 сард 48.6 хувиас өсч 9 дүгээр сард 67.8 хувьд хүрсэн. (Зураг 34)

Зээлийн өсөлт хурдан байгаагаас, зээлийн хадгаламжид харьцуулах харьцаа нь 2012 оны эцэст 99 хувь байснаа 9 дүгээр сард 128 хувьд хүрсэн байна. (Зураг 35) Зээлийн хадгаламжид харьцах харьцаа өсч байгаа нь банкуудын зээл болон хадгаламжийн өсөлтийн хоорондын ялгаа нэмэгдэж байгааг харуулж байна. Банкуудын хувийн зээлийн нийт өсөлт 9 дүгээр сард 48 хувиас илүү байхад нийт хадгаламж 8 болон 9 дүгээр саруудад ойролцоогоор 20 хувиар нэмэгдэж байна. 9 дүгээр сард хувийн салбарын зээлийн үлдэгдэл 10.2 их наяд төгрөгт хүрсэн байхад банкуудын нийт хадгаламж (засгийн газрын хадгаламжийг оролцуулахгүйгээр) 7.9 их наяд төгрөг байна.

Банкны хадгаламжуудыг валютын бүтцээр нь үзвэл гадаад тэнцвэргүй байдал өсч байгаа нь дотоодын мөнгөн тэмдэгтэд үзүүлэх зах зээлийн сентимент сул байгааг харуулж байна. Дотоодын мөнгөн тэмдэгтээр хийгдсэн банкуудын хадгаламжийн өсөлт нь зогсонги байдалтай байна, 8 дугаар сард 1.1 хувиар буурсан бол 9 дүгээр сард өмнөх сартай харьцуулбал 2-хон хувиар өсчээ. Харин гадаад валютаар хийгдэх банкны хадгаламж нь 7 дугаар сар (11.5 хувиар) мөн 8 дугаар сард (13.9 хувиар) огцом өссөн –жилийн эхний дөрвөн сарын хугацаанд тасралтгүй буурч байснаа огцом өсч, эргэлт хийсэн байгаа нь дотоодын мөнгөн тэмдэгтэд итгэх итгэл сул байгааг харуулж байна. 9 сарын дунд үеэс валютын ханш тогтворжиж эхэлсэнтэй холбогдуулж 9 дүгээр сард гадаад валютаар хийгдсэн хадгаламж 11.4 хувиар буурсан. Гадаад валютын данс нь нийт банкны хугацаатай хадгаламжийн 23 хувь, нийт банкны дансны 30 хувийг (хугацаагүй хадгаламжийг оруулаад) 9 сарын хувьд эзэлж байна.(Зураг 36)

Зураг 39. Зээлийн хадгаламжийн харьцаа өсч байна

Банкны зээл болон хадгаламжийн хандлага (өмнөх улирлатай харьцуулсан, % өөрчлөлт)

Зураг 40. Төгрөгийн болон гадаад валютын хадгаламж

% өөрчлөлт, өмнөх жилтэй харьцуулсан, 3 сарын гулсмал дундаж



Эх үүсвэр: МБ, ДБ-мэргэжилтнүүдийн тооцоо

Мөнгөний бодлогын удирдлагууд зээлийн огцом өсөлтөд анхаарлаа хандуулах ёстой. Уул уурхайн зах зээл сул байгаа энэ үед мөнгөний бодлогыг сулруулсан нь хоёр оронтой өсөлтөд хүргэхэд хувь нэмэр оруулсан мөн хөрвөх чадварыг нэмэгдүүлэхнд дэмжлэг үзүүлж, дотоодын зээлийн өндөр өсөлтийг хадгалан үлдлээ. Гэвч эдийн засгийн үзүүлэлтүүдээс харахад сүүлийн

саруудын зээлийн огцом өсөлт нь гадаад болон дотоод тэнцвэргүй байдлыг улам муутгаж эхэлж байна; валютын ханшны сүүлийн огцом хөдөлгөөн мөн инфляци нэмэгдэж эхэлсэн. Хувийн салбарын зээлийн өсөлт бараг 50 хувьд хүрэхэд ойрхон байгаа энэ үед мөнгөний бодлогын удирдлагууд төлбөрийн тэнцлийн тэнцвэргүй байдал нэмэгдэх, инфляцийн дарамтад үзүүлэх сөрөг нөлөөг багасгах тал дээр анхаарлаа хандуулах хэрэгтэй байна. Удирдлагууд төлбөрийн тэнцэл, валютын ханш, инфляцийн түвшин болон банкны салбарын үзүүлэлтүүд зэрэг макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг анхааралтай харах ёстой.

Сүүлийн мөнгөний үзүүлэлтүүдээс харахад, мөнгөний сулралтын хурдац удааширч байгаа тэмдэг ажиглагдаж байгаа ч их хэмжээний бодлогын зээлийн хөтөлбөрүүд үргэлжлэх хандлагатай байгааа үед мөнгөний сулралт нь өндөр түвшинд хэвээрээ байна. Нөөц мөнгөний өсөлт нь өнгөрсөн 12 дугаар сард 30.5 хувиас 7 дугаар сард 59.3 хувьд өссөн (өмнөх оны мөн үетэй харьцуулбал) бол 8 дугаар сард 33.9 хувьд буурч 9 дүгээр сард 22.4 хувьд хүрчээ. (Зураг 37) МБ нь арилжааны банкуудын илүүдэл хөрвөх хөрөнгө 771 тэрбум төгрөгийг 8 болон 9 дүгээр саруудад Төв банкны үнэ цаасаар дамжуулан нээлттэй зах зээлийн үйл ажиллагаагаар шингээж авсан. Төв банкнаас богино хугацаатай хадгаламж байдлаар байршуулсан 900 тэрбум төгрөгийг МБанкинд 2013 оны сүүл гэхэд буцааж өгөхөөр төлөвлөсөн. Гэвч мөнгөний сул бодлогын томоохон хэсэг болон зээлийн бодлогын хөтөлбөрүүд нь хэрэгжиж байгаа хэвээрээ байна. Үнийг тогтворжуулах хөтөлбөр нь хоёроос илүү жилийн хугацаатайгаар хэрэгжихээр төлөвлөгдсөн бөгөөд бага хүүтэй орон сууцны зээлийн хөтөлбөрийг оролцуулаад барилгын болон орон сууцны хөгжлийн хөтөлбөрүүд нь нийгэмд нөлөөтэй хэвээрээ байгаа тул цаашид үргэлжлэх нь хэвээрээ. Энэхүү хоёр хөтөлбөр нь мөнгөний сулруулсан хөтөлбөрүүдийн дал гаран хувийг эзэлж байна.

Мөнгөний сул бодлогын арга хэрэгсэлүүд нь банкны тогтолцоонд гажуудал, өртөмтгийн байдлыг үүсгэх эрсдлийн хүчин зүйлсүүдийг агуулж байна. Нийт мөнгөний нөхцөл байдлыг дахин үнэлгээ хийхэд, цаашдаа дараах эрсдлүүдийг хянан авч үзэн, анхааралдаа авах хэрэгтэй:

Зураг 41. Нөөц мөнгөний өсөлт саяхнаас буурлаа

Reserve Money Growth and Central Bank Bills Issuance



Эх үүсвэр: МБ, ДБ-мэргэжилтнүүдийн тооцоо

- **Бодлогын зээлүүдэд хүүгийн хязгаар тогтоосон тул банкуудын зээлийн эрсдлийг давах чадвар хязгаарлагдмал боллоо.** Бодлогын зээлийн хөтөлбөрүүдэд нь арилжааны банкуудаар дамжуулан ашиг хүртэгчдэд (газрын тос, махны бөөний компаниуд, барилгын материалын үйлдвэрлэгчид, орон сууц худалдан авч байгаа хувь хүмүүс) хөнгөлөлттэй зээлийг олгох замаар хэрэгжиж байна. Бодлогын зээлтэй холбоотой зээлийн эрсдэл нь банкуудын балансад илэрхийлэгдэх ёстой боловч банкуудад зээлийн дээд хязгаар тогтоосон учраас хувь хүмүүс, зээлдэгчдийн зээлийн эрсдлийг бүрэнд үнэлж, зээлийн хүүнд оруулж чадахгүй байна.

- **Зохицуулалтыг сулруулсан.** Зарим бодлогын зээлүүд (жишээ нь Үнийг тогтворжуулах хөтөлбөр) нь зарим оновчтой зохицуулалтыг зөөлрүүлж, хөнгөлөлт үзүүлж байгаа нь банкны зээлийн үйл ажиллагаанд ёсзүйн сөрөг нөлөөг нэмэгдүүлж, банкны тогтолцооны эрүүл байдлыг муутгана.

- **Дахин санхүүжилтийн эрсдлүүд.** МБ-ны санхүүжилт нь хамгийн ихдээ гурван жил буюу тур зуурын байх зорилготой байсан. Энэ нь дахин санхүүжилтийн эрсдлүүдийг бий болгож байгаа, учир нь МБ нь бодлогын зээлээс гаргаж, банкууд бага хүүтэй МБ-ны санхүүжилтийг дахин санхүүжүүлэх хэрэгтэй болно. Зах зээлд адил төстэй санхүүжилтийн эх үүсвэрийн үнэлсэн үнэлгээ дутагдалтай байгаа тул одоогийн бодлогын зээл нь удаан хугацаанд үргэлжлэх, ялангуяа бага хүүтэй орон сууцны хөтөлбөр нь үргэлжлэх магадлалтай.

Зээлийн өсөлт нь барилгын салбарт төвлөрч байна. 2013 оны хоёрдугаар улиралд, ихэнх салбаруудад банкнуудын зээл бодлогын зээлийн улмаас огцом өсөлтийг үзүүлсэн. Энэ улирлыг өмнөх улиралтай нь харьцуулсан байдлаар нь авч үзвэл, барилгын салбарт өгсөн зээл 67.7 хувиар огцом нэмэгдэж, дараа нь бөөний салбарын зээл орж байна (22.8 хувь). (Зураг 38) Уул уурхайн салбарт өгсөн зээл нь 10.2 хувиар нэмэгдсэн бол аж үйлдвэрлэлийн зээлийн өсөлт 12 хувь байлаа. Үүний үр дүнд хоёрдугаар улиралд барилгын болон үл хөдлөхтэй холбоотой зээл нь 2012 оны эцэст 33.5 хувь байсан бол өсч 37.7 хувийг эзэлж байна. Бөөний салбар нь аж үйлдвэрлэлийн зээлийн 24.1 хувийг эзэлж байна. Уул уурхайн салбарт өгсөн зээл нь 14.7 хувийг эзэлж байгаа нь сүүлийн 3 жилд тогтвортой байх хандлагатай байна. (Зураг 39) Барилгын болон үл хөдлөх салбарын зээл ийнхүү нэмэгдэж байгаа нь эдгээр салбаруудад бодлогын зээлийн хөтөлбөрүүд төвлөрч байгаатай холбоотой. Нийт бодлогын зээлийн бараг 60 хувьд нь Үнийг тогтворжуулах хөтөлбөрийг оролцуулаад барилгын болон орон сууцны салбарт чиглэгдэхээр төлөвлөсөн бөгөөд 6 дугаар сард барилгын болон орон сууцны хөгжлийг дэмжих нэмэлт арга хэмжээнүүдийг оруулсан. (илүү дэлгэрэнгүйг Хайрцаг 6-аас харна уу.)

Банкны хянан шалгалтын удирдлагууд барилгын болон үл хөдлөх хөрөнгийн хөгжлийг нарийн хянах, мөн эдгээр салбаруудад зээлийн чанарыг хянах шаардлагатай. Барилгын зээлийн дийлэнх хувь нь орон сууцны барилгыг санхүүжүүлэхэд хэрэглэгдсэн бөгөөд энэ нь энэ оны эхний хагас жилд өмнөх үетэй харьцуулбал нэрлэсэн хэмжээгээр 287 хувиар өссөн. Барилгын болон үл хөдлөх хөрөнгийн салбарууд нь эдийн засгийн хямралд хамгийн өртөмтгий, эдийн засгийн уналт, өсөлтийн мөчлөгт хамгийн их өртөгөөрөө алдартай бөгөөд ялангуяа барилгын болон үл хөдлөх хөрөнгийн хөөс арилжааны зориулалтаар эсвэл бодлогын хэт урамшууллаас үүдэж огцом нэмэгддэг. Эдгээр салбаруудад зээлийг нэмэгдүүлж байгаа нь банкны салбарыг барилгын болон үл хөдлөх хөрөнгийн салбаруудад гарч болох уналтад илүү эмзэг болгож байна. ХҮИ дэх түрээсийн үнийн өсөлтийн дүнгээс харахад барилгын үнийн өсөлт нь түрээсийн үнэ нэмэгдэж эхэлснээр илэрч байна: 8 дугаар сард түрээсийн үнэ 20.1 хувь, 9 дүгээр сард өмнөх үетэй харьцуулбал 16 хувиар өсчээ.

Зураг 42. Барилгын зээл хурдацтайгаар өсч байна

Банкны зээлийн өсөлт салбараар (%, өмнөх улиралтай харь)



Эх үүсвэр: МБ, ДБ-мэргэжилтнүүдийн тооцоо

Зураг 43. Барилгын салбарын зээлийн эзлэх хувь өсч байна

Зээлийн өрийн үлдэгдэл, салбараар (%, 2 дугаар улирал)



Банкуудын чанаргүй зээлийн хэмжээ өсч байна. Чанаргүй зээлийн харьцаа (өмнөх хугацаа хэтэрсэн зээлийг хасаад) Хадгаламж банкны муу зээлээс үүдэж 6 дугаар сард 3.68 хувь байснаа 4.97 хувь болж өсчээ. Чанаргүй зээлийн харьцаа 9 дүгээр сард улам өсч 5.29 хувьд хүрсэн –энэ нь 2012 оны 4 сараас хойших хамгийн өндөр хэмжээ юм. (Зураг 40) Өнгөрсөн хугацаа хэтэрсэн зээлийг оруулсан чанаргүй зээлийн харьцаа нь адилхан өсөх хандлагатай байна, 7 дугаар сард 6.7 хувиас, 8 дугаар сард 6.66 хувь харин 9 дүгээр сард 6.8 хувьд хүрчээ. Харин чанаргүй зээлийн хэмжээ нь 8 дугаар 9 сар хүртэл 15.6 хувиар нэмэгдсэн нь – 2009 оны 6 сараас хойших өмнөх сартай харьцуулсан байдлаар авч үзвэл хамгийн өндөр түвшинд байна, үүнд өнгөрсөн 6 сарыг оролцуулаагүй, учир нь энэ сард Хадгаламж банкны муу зээл нэмэгдсэн. Өнгөрсөн хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ нь 8 дугаар сард огцом 15.6 хувь өссөнөө 9 дүгээр сард 17 хувиар буурчээ. (Зураг 41) Банкуудын эрүүл байдал ерөнхийдөө тогтвортой хэвээрээ байгаа боловч чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа нь зарим зээлдэгчийн санхүүгийн байдал муудсныг харуулж байна. Зээлийн өсөлт хурдацтай байгаа, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа энэ үед байнгын хяналт шалгалт хэрэгтэй.

Зураг 44. Сүүлийн саруудад ЧЗХ харьцаа өсч байна

Банкны чанаргүй зээлийн харьцаа (%)



Эх үүсвэр: МБ, ДБ-мэргэжилтнүүдийн тооцоо

Зураг 45. ЧЗХ хэмжээ нь 9 сард өслөө

% ЧЗ болон хугацаа хэтэрсэн зээлийн өөрчлөлт (өмнөх улиралтай харь.)



Монгол банк болон Сангийн яам нь Хадгаламж банкны муудаж байгаа нөхцөл байдалд хурдан арга хэмжээ авч хэрэгжүүлний үр дүнд банкны тогтолцооны тогтвортой байдлыг амжилттай хадгалж үлдсэн. Хадгаламж банк саяхан дампуурсан нь ил тод, хариуцлагатай байдлыг чухалчилан, зээлийн чанарыг илүү нарийн хянах шаардлагатайг харуулж байна. Үүнээс гадна, Хадгаламжийн банк дампуурсны дараа Төрийн банкийг дахин хөрөнгөжүүлэх өртөг нь засгийн газарт төсвийн нэмэлт дарамт болох талтай. (Хайрцаг 4)

Хайрцаг 5. Хадгаламжийн банкны саяхны дампуурал

Монгол банк нь 2013 оны 7 дугаар сард Хадгаламжийн банк төлбөрийн чадваргүй болох үед өөрийн оролцоог гаргасан. Хувийн өмчит Хадгаламжийн банк нь нийт банкны хөрөнгийн 8 хувийг эзэлдэг байсан (тухайн улсад томоороо тавд харин таван системын чанартай банкны хамгийн жижиг нь). Банк нь сул корпораци, холбоотой компаниудад олгосон зээл нь төлөгдөх чадваргүй болсны үр дүнгээс дампуурсан харагдаж байна. Холбоотой талын зээл нь хөрөнгөөс 2 дахинаас илүү хэмжээгээр давж гарсан (хамааралтай талуудад өгөх зээлийн хөрөнгийн хязгаарлалт нь 20 хувь, банкны хамааралтай талуудад өгөх зээлийн хязгаарлалт нь 5 хувь). Хадгаламж банк нь сүүлийн хоёр жилийн хугацаанд МБ-ны хяналт, шалгалтын тусгай хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байсан боловч дотоод/асуудлыг багасгаж чадаагүй бөгөөд түүний хөрөнгийн хүрэлцээтэй байдлыг сэргээж чадаагүй юм.

Хадгаламж банк нь хүлээн авагчид очсон. Холбоотой талуудын чанаргүй зээл болох 160 тэрбум төгрөг, бусад асуудалтай холбоотой 20 тэрбум төгрөгөөс бусад (хүлээн авагчид үлдсэн), Хадгаламж банкны бүх хөрөнгө, өр төлбөр нь ажиллагсад, IT систем, бусад биет бус хөрөнгүүдийн хамт Төрийн банкинд шилжсэн бөгөөд худалдан авалт болон үйл ажиллагааны ажил гүйлгээг МБ болон СЯ хамтран зохион байгуулсан.

Удирдлагуудын зоригтой шийдэл нь тогтолцоонд бүхэлд нь итгэл алдах гэнэтийн шокоос хамгаалж чадсан. Банкны тогтолцоонд байгаа хадгаламжууд нь ажил гүйлгээний дараах үе шатандаа үлдсэн. Гэвч түүний зардлыг Хадгаламж банкны хөрөнгө, өр төлбөрийг өвлөн авсан Төрийн банкны зарлагаар хийгдэж, Монгол улсын Хадгаламжийн Даатгалын Корпораци эсвэл түүний эзэмшигч болох засгийн газрын оролцоогүйгээр хийгдсэн. Төрийн банкны хөрөнгийн хүрэлцээ 18% хүрэхэд 205 тэрбум төгрөг хэрэгтэй гэж тооцоолсон. Удирдлагууд одоогоор Төрийн банкыг дахин хөрөнгөжүүлэх хувилбаруудыг бий болгосон (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Төрийн банкны баланс: Хадгаламжийн банкны үйл ажиллагааг шилжүүлэхээс өмнө болон дараа нь

	Гүйлгээнээс өмнөх Төрийн банк	Гүйлгээнд байсан Хадгаламжийн банк	Гүйлгээний дараах Төрийн банк
Хөрөнгө (тэрбум төгрөг*)	330	~1,070	~1,400
Хөрөнгө (сая ам.доллар)	~200	~640	~840
Ажиллагсадын тоо	~400	~3,300	~3,700
Салбаруудын тоо	30	510	540
ХХБК	18%	Сөрөг хөрөнгө, хөрөнгө өр төлбөрийн зөрүү нь 120тэрбум төгрөг	Шаардлагатай хамгийн бага түвшин 14% доогуур

Эх үүсвэр: ДБ мэргэжилтнүүдийн тооцо

*1 ам.доллар = 1,675 төгрөг (2013 оны 9 сарын 17)

Хадгаламж банкны дампуурал нь банкны хүчтэй хяналт шалгалт хэрэгтэй байгааг илэрхийлж байна. Уг банк нь Монгол улсын бусад банкуудтай адилаар сүүлийн жилүүдэд ихээхэн хэмжээний зээлийн өсөлттэй байсан. Банкны салбарын өсөлтийн хурдац нь оновчтой баталгааны арга хэрэгсэл, корпорацийн засаглал, дотоод хяналт зэрэгт асуудал авчирдаг. Үүнээс гадна салбарын дадаагүй байдал, цөөн тооны корпорацийн зээлдүүлэгчдэд зээлдүүлж байгаа нь уул уурхайн хамаарал, энэхүү өсөлтөд засгийн газрын зарлагын өсөлт зэрэгтэй холбогдож банкны тогтолцоонд эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Мөн сүүлийн үеийн валютын сулралт, мөн нийт зээлийн ойролцоогоор 30 хувь нь 2013 оны 6 сарын байдлаар гадаад валютаар хийгдэж байгаа зэрэг нь зээлийн эрсдлийг өндөр болгож байна. Банкны зохицуулагчийн хувьд Монгол банкнаас ирэх саруудад системийн болон банк болгоноор хөрөнгийн хүрэлцээтэй байдал, макро санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах чиглэлээр үргэлжилсэн хяналт шалгалт шаардлагатай байна.

Эх үүсвэр: ДБ мэргэжилтнүүд

Хайрцаг 6. Үнийг тогтворжуулах хөтөлбөр

Үнийг тогтворжуулах хөтөлбөр нь 2012 оны 10 сараас засгийн газар болон төв банкны хооронд “гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнүүдийг тогтвортой байлгах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх” Харилцан ойлголцлын санамж бичиг зурснаар хэрэгжиж эхэлсэн. Уг хөтөлбөр нь (ҮТХ) дөрвөн дэд хөтөлбөрөөс бүрдсэн: i) хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдал; ii) шатахууны жижиглэнгийн үнийн тогтвортой байдал; iii) импортын хэрэглээний бараануудын өртөгийг бууруулах; мөн iv) барилгын салбарыг дэмжих, орон сууцны тогтвортой үнийн түвшинд хүрэх.

Уг хөтөлбөр нь улирлын чанартай, үнийн өсөлтийн хэлбэлзэлийг үүсгэгч гэж үздэг бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн дутагдалтай байдлыг шийдэх зорилготой. Гэвч ҮТХ нь инфляцийн уламжлалт бус арга бөгөөд энэ нь сонгосон нийлүүлэгчдэд хөнгөлөлттэй зээлийг олгон оронд нь тэд үнийг тогтвортой байлгахыг амалсан. Энэ утгаараа ҮТХ нь эдийн засагт мөнгө нийлүүлэх гол хэрэгсэл болсон бөгөөд энэ нь гол хэрэглээний үнүүдийг де факто үнийн хяналтаар тогтоон барьж байна.

Өнгөрсөн 11 сараас 9 сар хүртэл ҮТХ-ийн бодит гаргасан мөнгө нь 642 тэрбум төгрөгт хүрсэн (орон сууцны зээлийн хөтөлбөрийг оруулахгүйгээр). Барилгын салбар нь барилгын материалын үйлдвэрлэл болон импортод зориулж 292 тэрбум төгрөгийг авсан, дараагаар нь газрын тосны компаниуд (192 тэрбум төгрөг), махны компаниуд (87 тэрбум төгрөг) мөн гурил үйлдвэрлэгчид (49 тэрбум төгрөг).

- ҮТХ-ийн хүрээнд газрын тосны үнийн тогтворжуулалт нь бензины үнийг импортлогдсон жижиглэнгийн газрын тосны бүтээгдэхүүний санхүүжилтийн өртөгийг бууруулах замаар тогтвортой байхад чиглэсэн. 9 сарын байдлаар, 192 тэрбум төгрөгийг 15 удаагийн олголтоор 11 газрын тосны компаниудад 3.8 хувийн хүүтэйгээр олгосон байна. 82.5 сая ам.долларын форвард хэлэлцээрийг 2-6 сарын хугацаанд төв банктай тохиролцсон оролцогч банкуудаар дамжуулан хийгдсэн бөгөөд 11 компаниуд тааламжтай нөхцөлийг авсан. Үүний үр дүнд дотоодын газрын тос импортлогчид бага өртөгтэй, ханшний эрсдэл багатайгаар өөрсдийн газрын тосны бүтээгдэхүүнүүдийг санхүүжүүлж чадсан. Энэхүү дэд хөтөлбөр нь урт хугацаанд үнийг тогтвортой барих зорилготой бус харин санхүүгийн дэмжлэг авч байгаагийн хувьд компаниудыг жижиглэнгийн үнийн өсөлтийн тохируулгаа хойшуулахыг л шаардаж байлаа билээ.

- Махны болон гурилын дэд хөтөлбөр – эдгээр нь нийт ХҮИ-ийн 20 хувийг бүрдүүлдэг харин хүнсний ХҮИ-ийн 60 гаран хувийг бүрдүүлдэг – бөгөөд зорилго нь махны болон гурилын нөөцийг нэмэгдүүлэх. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд, нэг жилийн хугацаатай 3.8 хувийн хүүтэй 122 тэрбум төгрөгийг гурван махны компаниуд (87 тэрбум төгрөг) мөн 24 гурилын компаниудад (49 тэрбум төгрөгийг) 9 сарын байдлаар олгосон. Үүний үр дүнд 11,446 тон махны нөөцийг гэрээ бүхий махны үйлдвэрлэгчид бэлтгэсэн. Гурилын үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд, гурилын нөөцийг бүрдүүлэх, гурилын нөөцийг арилжаалах болон хяналт тавих зорилготойгоор хэд хэдэн арга хэмжээг 24 гурилын компаниудаар дамжуулан хөнгөлөлттэй зээлээр авч хэрэгжүүлсэн. 9 сарын байдлаар, махны компаниуд өөрсдийн зээлийг бүрэн барагдуулсан бол гурилын үйлдвэрлэгчид 4.1 тэрбум төгрөгийг арилжааны банкуудаар дамжуулан төв банкинд төлнө.

- ҮТХ-ийн дэд хөтөлбөр, “барилгын голлох материалуудын үнийг тогтворжуулах”, хөтөлбөрөөр 292.1 тэрбум төгрөгийг гаргасан бөгөөд үүнээс 166.7 тэрбум төгрөгийг барилгын материал үйлдвэрлэдэг 68 компаниудад олгосон бол 55 компанид барилгын импортлодог материалын (цемент, арматур) үнийн улирлын хэлбэлзлийг бууруулахаар 125.4 тэрбум төгрөгийг олгосон. ҮТХ хүрээнд санхүүгийн дэмжлэг авч байгаа аж ахуйн нэгжүүд нь үнүүдийг тогтвортой барьсан: цементийн үнэ 132-138 мянган төгрөг, арматурын үнэ нь 2013 оны 2 болон 3 дугаар улирлын хооронд 1,100-1,130 мянган төгрөг байлаа. Гэвч ҮТХ гэрээний нөхцөлүүдийг биелүүлэхэд үйлдвэрлэл нэмэгдэж байгаа бөгөөд валютын ханш суларч байгаа нь импортын өртөг нэмэгдэж, биелэхэд улам төвөгтэй болж байна. 8 дугаар сард цементын үнэ 140-145 мянган төгрөг хүрсэн бол арматурын үнэ 1,150-1,170 мянган төгрөгт хүрсэн.

Эх үүсвэр: ДБ мэргэжилтнүүд

Хайрцаг 7. Барилгын болон Орон сууцны хөгжлийг дэмжих хөтөлбөр

Танилцуулга. 2013 онд Засгийн газраас барилгын болон орон сууцны салбарыг дэмжих чиглэлээр олон тооны арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Дэмжлэгийн арга хэмжээнүүдэд барилгын материалын үнүүдийг тогтворжуулах Үнийг тогтворжуулах хөтөлбөр болон барилгын компаниуд болон үл хөдлөх хөрөнгө компаниудад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн бөгөөд өрх гэр бүлд бага хүүтэй зээл олгосон. Үнийг тогтворжуулах Хөтөлбөрийн хүрээнд барилгын салбарт 292.1 тэрбум төгрөгийг олгосноос гадна (дэлгэрэнгүйг Хайрцаг 5-аас харна уу), Засгийн газар болон Монголбанк нь 6 сарын сүүлчээр барилгын болон орон сууцны салбарт нэмэлт арга хэмжээг авсан. Эдгээр арга хэмжээнд (i) орон сууцны татаастай зээллэгт зориулж арилжааны банкуудад 1,125 тэрбум төгрөг олгосон мөн (ii) орон сууцны барилгад арилжааны банкуудаар дамжуулан 430 тэрбум төгрөгийг 7 хувийн хүүтэй, 18 сарын хугацаатайгаар олгосон.

Эдгээр иж бүрэн арга хэмжээнүүдийн үр дүнд, барилгын салбартай холбоотой бодлогын зээлийн хэмжээ нь ойролцоогоор 1.8 их наядад хүрээд байгаа бөгөөд энэ нь янз бүрийн бодлогын зээлийн хөтөлбөрүүдийн нийт зээлийн (3.1 их наяд төгрөгийн) 60 гаран хувь болж байна.

Орон сууцны санхүүжилтийн хөтөлбөр. Орон сууцны санхүүжилтэнд зориулж Монголбанкнаас 4 хувийн хүүтэй 1,125 тэрбум төгрөгийг арилжааны банкуудад олгосон бөгөөд үүнийг инфляциас хамааруулан хувь хүмүүс, зээлдэгчид 20 жилийн хугацаатайгаар 7 болон 9 хувийн хооронд хэлбэлзэлтэйгээр олгогдсон. 2013 оны эхээр зах зээлд суурилсан хүү нь жилийн 27 хувьд хүрч байсан. Эдгээр татаас бүхий орон сууцны зээлийг Монголын Ипотекийн Корпораци үнэт цаасаар баталгаажуулж багцлагдсны дараа МБ болон Нийгмийн Даатгалын Сан (НДС) худалдана. Уг хөтөлбөр нь мөн одоогийн байгаа орон сууцны зээлийг татаас бүхий зээлийн хүүнд дахин санхүүжүүлэх арга хэмжээ багтаж байгаа нь багцын зээлийн удирдлагын арга хэмжээ гэж харагдаж байна. Үл хөдлөх хөрөнгө худалдан авах шалгуурт барьцаанд очих орон сууц нь 80 м^2 байх бөгөөд энэ нь одоогийн орон сууцны багцад дунджаар 50 м^2 гэж байгаагаас нэлээд өндөр байгаа юм. Зээлийг авах хүмүүс нь тогтмол ажилтай, 1 саяас дээш орлоготой байх шаардлагатай.

Орон сууцны санхүүжилтийн хөтөлбөрт өмнө нь хэд хэдэн амжилтгүй оролдлого байсан боловч орон сууцны зах зээлийн хөгжилд чиглэсэн иж бүрэн хандлагыг боловсруулах зорилготой байлаа. Энэхүү хөтөлбөр нь олон тооны оролцогчтой төвөгтэй (МБ, олон тооны яамдууд, НДС, хөрөнгийн зах зээлийн зохицуулагч, МИК болон голлох зээлдэгчүүд) and бөгөөд Монголын нөхцөлд шалгагдаагүй байна (орон сууцны борлуулалт нь бүрэн эрсдлийг шилжүүлэх, ОСХБаталгаажуулах, түүнийг гаргах, худалдаалах, НДС-ийн хөрөнгө оруулалт гэх мэт). Энэ нь өнөөгийн байгаа багцын үлдэгдлээс 32 хувиар илүү байгаа бөгөөд тоо хэмжээний хувьд жирийн орон сууцны зээлийн 5-6 жилийн хугацааны хөрөнгөтэй тэнцүү хэмжээтэй. Мөн энэд олон тооны хууль эрхзүйн зохицуулалт шаардлагатай ялангуяа хоёрдогч орон сууцны зах зээлийн үйл ажиллагаа болон МИК институцийн чадавхийн талд шаардлагатай.

Уг хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад асуудлууд үүсгэхээс гадна зах зээлийг ихээхэн хэмжээгээр гажуудуулах чадалтай. Хэрвээ тодорхой зорилтыг бий болгохгүй, оновчтой шалгуургүйгээр их хэмжээгээр орон сууцны зээлийг татаасжуулж хүн амд хүргэх нь үл хөдлөх хөрөнгийн бодит үнийг хурдацтай их хэмжээгээр нэмэгдүүлэх талтай. Мөн зээлийг хүртэх шалгуургүйгээр олгох нь хүн ам илүү их татаас хүсэх үед хөтөлбөрийг хэрэгжүүлсний дараагаар татаасгүй орон сууцны зээл олгох бизнесийн боломж олдохгүй. Орон сууцны санхүүжилтийн ¾ - нь одоогийн байгаа багцыг дахин санхүүжүүлэхэд очиж байгаа нь МБ нь орон сууцны зах зээлийн зээлийн эрсдлийг бууруулах, үл хөдлөх хөрөнгийн үнийг бууруулах зорилготой байсан гэж харагдаж байна.

6 болон 9 сарын дунд үеийн хооронд, одоогийн орон сууцны 448 тэрбум төгрөгийг дахин санхүүжүүлсэн (одоо байгаа багцын 53 хувь мөн хөтөлбөрийн 40 хувь) бол шинээр орон сууцны зээллэгт 411 тэрбум төгрөгийг гаргажээ (Хөтөлбөрийн 36 хувь). Шинээр олгож байгаа татаас бүхий зээлийн хэмжээ нь нэлээд өндөр байна – зах зээлийн хүүгээр олгогдсон жилийн хэмжээнээс бараг хоёр дахин байлаа – мөн энэ нь үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ өсөх дарамтыг бий болгох талтай. Ерөнхийдөө хөтөлбөрийн ¾ нь ашиглагдсан бөгөөд мөн Монголын орон сууцны багцын ½ нь дахин санхүүжигдэж, мөн татаастай хүүгээр хэрэгжиж байна.

Хөтөлбөрийн хөрөнгийн зах зээлийн бүрэлдэхүүн хэсэг нь ОСХБ төвөгтэй хэрэгсэлийг гаргахаар болж байгаа нь удахгүй хэрэгжих бөгөөд олон тооны эрхзүйн, зохицуулалтын болон институцийн хүчин чармайлт шаардагдана. Үүнээс гадна маш хурдан хугацаанд гаргаж байгаа нь МБ болон Засгийн газарт орон сууцны зээллэгт татаасыг үргэлжлүүлэх нийгмийн дарамт их байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь арилжааны банкуудын ашигт ажиллагаа болон зах зээлд суурилсан орон сууцны зээлийн бизнесийг үргэлжлүүлэх чадавхид сөргөөр нөлөөлөх талтай. Мөн МБ нь ирээдүйд орон сууцны үнийн өсөлтийг бууруулахын тулд

шинээр татаас бүхий зээлжилт олгохыг бууруулахыг зөвлөж байна.

Эх үүсвэр: ДБ мэргэжилтнүүд

Гадаад салбар

Дэлхийн уул уурхайн зах зээл сул байгаа, мөн дотоодын хүчтэй эрэлттэй байгаа үед худалдааны алдагдал 2012 онд хамгийн өндөр түвшиндээ 2.4 тэрбум ам.долларт (ДНБ-ий 23 хувь) хүрээд 2013 онд үргэлжилж байна. Гадаад худалдааны алдагдал нь эхний 9 сарын туршид 1.72 тэрбум ам.долларт хүрч, өмнөх жилийн хэмжээнээс 2.0 тэрбум ам.долларааc буурсан. (Зураг 42) Дэлхийн уул уурхайн зах зээл сул байгаа нь уул уурхайн экспортыг сулруулж, импортын эрэлт – их хэмжээний ГХШО-ын урсгалын нөлөөгөөр 2011 онд хоёроос илүү дахин өссөн– байна. Нийт импорт нь нийт экспортоос 1.6 дахин их байна.

Зураг 46. Их хэмжээний гадаад худалдааны алдагдал үргэлжилсээр

Нийт экспорт болон импорт (3 сарын гулсмал дундаж, улирлын хэлбэлзлийг оруулсан, тэрбум ам.доллар)



Эх үүсвэр: МБ, ДБ-мэргэжилтнүүдийн тооцоо

Эхний 9 сарын хугацаанд нийт экспорт өмнөх жилд 3.1 тэрбум ам.долларт хүрч байсан бол 4.1 хувиар буурчээ. Ихэнх гол нэрийн экспортын бүтээгдэхүүнүүд харьцангуй сайн гүйцэтгэл үзүүлсэн боловч нүүрсний экспорт огцом буурсан нь экспортыг бууруулах гол хүчин зүйл болсон.

- **Нүүрсний экспорт – нь 2012 оны нийт экспортын 43 хувийг эзэлж байсан бол – өмнөх жилийнхээс 45.3 хувиар буурсан, 1,432 сая ам.долларааc 783 сая ам.долларт хүрсэн (Зураг 43).** Нүүрсний экспортын бууралт нь 2012 онд Монгол улсын нүүрсний экспортын 98.5 хувийг шингээдэг Хятад улс руу гаргах нүүрсний экспортод огцом бууралт гарсантай холбоотой.

Зураг 47. Нүүрсний экспорт огцом буурсан

Нүүрсний экспортын жилийн хандлага (тэрбум доллар, өнөө хүртэл)



Зураг 48. Нүүрсний экспортын хэмжээ болон үнэ буурсан

% нүүрсний хэмжээ болон нэгжийн үнийн өөрчлөлт (өнөө хүртэл, өмнөх жилтэй харьцуулсан)



Эх үүсвэр: МБ, ДБ-мэргэжилтнүүдийн тооцоо

- **Хятадын нүүрсний нийлүүлэлт элбэг, нүүрс экспортлогч гол орнуудын хооронд өрсөлдөөн нэмэгдэж байгаа нь нүүрсний үнэ болон хэмжээнд аль алинд нь хүчтэй дарамтыг үүсгэлээ.** Хэдийгээр бусад өрсөлдөгчидтэй харьцуулбал Монгол улсын газарзүйн байршил нь гол нүүрсний зах зээлд ойрхон байгаа нь том давуу тал боловч

өртөг-хэмнэсэн тээвэрлэлт, хүргэлтийн тогтолцоо дутагдалтайн улмаас Монгол улсын нүүрсний өрсөлдөх чадварыг Хятад улсад хязгаарлаж байна. Нүүрсний зах зээлийн тааламжгүй нөхцөл байдлыг илэрхийлж, нүүрсний экспортын хэмжээ нь эхний 9 сарын байдлаар 20.4 хувиар буурч, өмнөх оны мөн үед 14.3 сая тонд хүрч байсан бол 11.3 сая тоннд хүрсэн байна. Нэгээс 9 сарын хооронд нэг тонн нүүрсний экспортын борлуулалтын үнэ нь 31.4 хувиар буурсан (Зураг 44).

- **Зэсийн экспорт – 2012 онд нийт экспортын 19 хувийг эзэлж байсан бол – 2012 онд 13 хувиар буурсны дараа эхний 9 сарын хугацаанд 8.4 хувиар (өмнөх жилийн мөн үетэй харьцуулбал) өсчээ.** Гурван сар дараалан унасны дараагаар, зэсийн экспортын өсөлт нь 7 дугаар сард эерэг болж, 8 дугаар сард 27.1 хувиар, 9 дүгээр сард 68.9 хувиар нэмэгдсэн нь Оюу толгойн уурхайн зэсийн баяжмалыг 7 сараас эхлэн нийлүүлж эхэлсэнтэй холбоотой. Зэсийн экспортын хэмжээний өсөлт нь 7 дугаар сард 10.8 хувь байснаа 9 дүгээр сард 49.4 хувь болжээ (Зураг 45). Ирэх саруудад Оюу толгойн уурхай нь үйлдвэрлэлээ нэмэгдүүлж экспорлохоор байгаа нь зэсийн экспортын хэмжээг өсгөхөөр байна.

Зураг 49. Сүүлийн саруудад зэсийн баяжмалын экспорт хурдан өслөө

Зэсийн экспортын хэмжээ болон үнэ (өмнөх жилтэй харьц, % өөрчлөлт)



Эх үүсвэр: МБ, ДБ-мэргэжилтнүүдийн тооцоо

- **Уул уурхайн бус экспорт[10] – нь 2012 онд экспортын 8 хувийг эзэлж байсан – ноолууран бүтээгдэхүүний хүчтэй экспортын улмаас эхний 9 сард 32.3 хувиар өсчээ.** Ноолууран бүтээгдэхүүний өсөлт нь 2012 онд 10.2 хувь байснаа 29.1 хувьд хүрчээ. Нэхмэл бүтээгдэхүүний экспортод ноолуур, арьс, ноос болон арьс шир орох бөгөөд энэ нь 2012 онд 5.8 хувь байснаа 26.1 хувь болж өсчээ. Эхний 9 сарын туршид, уул уурхайн бус экспорт нь нийт экспортын 12 хувийг эзэлж байгаа бөгөөд нийт уул уурхайн бус экспортын 48 хувийг ноолууран бүтээгдэхүүн эзэлж байна.

Эхний 9 сарын хугацаанд нийт импорт 8.0 хувиар буурчээ, өмнөх оны мөн үед 5.2 тэрбум ам.доллар байсан бол 4.8 тэрбум ам.долларт хүрсэн. Оюу толгойн уурхайн их хэмжээний хөрөнгө оруулалт дуусантай холбоотойгоор уул уурхайтай холбоотой хөрөнгө оруулалтын импорт 2012 оноос эхлэн буурснаар нийт импорт буурч байна. 2012 оноос эхлэн бууралт гарч байгаа ч импортын хүчтэй эрэлт нь 2013 онд нийт экспортоосоо 1.6 дахин илүү байсан нь өмнө нь 2011 онд ихээхэн хэмжээний гадаадын шууд хөрөнгө оруулалт болон төсвийн тэлэх бодлогын үр дүнд бий болж, одоогоор хоёр дахин илүү гарч байжээ.

- **Машин тоног төхөөрөмжийн импорт нь нийт импортын дөрөвний нэгийг эзэлдэг бөгөөд түүний бууралт хамгийн их байгаа нь ОТ уурхайн эхний үе шат дууссаныг**

[10] Уул уурхайн бус экспортын бидний тодорхойлолт нь алтны экспортыг оруулсан бол энэ нь мөн УСХ эмхэтгэлд нийт экспортын 19.9 хувийг эзэлж уурхайн бус экспортод орж байна. УСХ-ны ангилалаар, уул уурхайн бус экспорт (алтыг оруулаад) нь нийт экспортын 2012 онд 10.8 хувийг эзэлж байсан бол одоо 19.9 хувийг эзэлж байна.

оруулаад мөн дотоодын хөрөнгө оруулалтыг эрэлт удааширч байгааг илэрхийлж байна. Машин, тоног төхөөрөмжийн импорт нь 2012 онд 7.3 хувиар буурсны дараа 9 сарын туршид өмнөх оны мөн үеийнхээс 17.8 хувиар буурчээ.

- **Хүнсний болон барилгын үндсэн материалын импорт их хэмжээгээр нэмэгджээ.** Барилгын гол материалын (жишээ нь цемент, улаан тоосго) импорт 8 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 11.4 хувиар нэмэгджээ. Энэ нь улсын дэд бүтцийн болон орон сууцны барилгын ажил идэвхижсэнтэй холбоотойгоор зам болон барилгын хүчтэй эрэлт байгааг илэрхийлж байна. Хүнсний бүтээгдэхүүний импорт нь – нийт импортын 6 хувийг эзэлдэг – өмнөх оны мөн үеийнхээс 7.3 хувиар өсчээ.

Их хэмжээний худалдааны алдагдал, үйлчилгээний болон орлогын дансууд үргэлжилэн алдагдалтайн улмаас 2013 оны эхний 8 сарын байдлаар урсгал дансны алдагдал 2.4 тэрбум ам.долларт хүрсэн. (Зураг 46)I Худалдааны томоохон алдагдлын хажуугаар, үйлчилгээний болон орлогын дансууд үргэлжилсэн алдагдалтай байна. Үйлчилгээний данс нь төмөр замын ачаа тээврийн үйлчилгээнд алдагдалтай ажилласны улмаас 0.9 тэрбум ам.долларын алдагдалтай. Харин орлогын данс нь ажиллагсадын гуйвуулга болон хөрөнгө оруулалтын орлогод алдагдал нэмэгдэж байгаагаас 0.6 тэрбум ам.долларт хүрчээ.

Урсгал дансны алдагдал нь өнгөрсөн жилийн түвшинтэй ойртож очиж байгаа боловч 2013 онд гадаадын хөрөнгийн дотогшлох урсгал их хэмжээгээр буурсан нь төлбөрийн тэнцлийг том алдагдалд хүргэсэн. Эхний 8 сарын байдлаар, нийт санхүүгийн болон хөрөнгийн дансанд цэвэр 1.3 тэрбум ам.долларын урсгал орсон нь өмнөх оны мөн үеийн цэвэр капиталын урсгалын зөвхөн 51 хувь нь байна. Хөрөнгийн дотогшлох урсгал дутагдалтайгаас төлбөрийн тэнцэлд гадаад санхүүжилтийн 1.1 тэрбум ам.долларын ялгааг бий болгож, дотоодын мөнгөн тэмдэгтийн үнэ цэнэ болон гадаад валютын нөөцөд дарамтыг бий болгож байна.

Зураг 50. Урсгал дансны алдагдал өндөр хэвээрээ байна …

Урсгал дансны тэнцэл (сая ам.доллар, 12 сарын гулссан нийлбэр)



Зураг 51. …гэвч хөрөнгийн дотогшлох урсгал буурч байна…

Төлбөрийн тэнцлийн улирлын хандлага (тэрбум ам.доллар)



Эх үүсвэр: МБ, ДБ-мэргэжилтнүүдийн тооцоо

ГШХО болон багцын хөрөнгө оруулалт аль алинд гадаадын их хэмжээний дотогшлох урсгал буурлаа. (Зураг 47) 2013 оны эхний 8 сарын хугацаанд гадаад шууд хөрөнгө оруулалтын цэвэр дүн нь 1.8 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх жилийн 1 сараас 8 сарын хоорондох хэмжээний 53 хувь нь байна. Одоогийн байгаа хандлагаараа, жилийн ГШХО хэмжээ нь өмнөх хоёр жилийн ГШХО-ын хагаст хүрэхээр байна: 2011 онд 4.6 тэрбум ам.доллар, 2012 онд 4.4 тэрбум

ам.доллар байсан. 2013 оны багцын хөрөнгө оруулалт эхний 8 сарын хугацаанд 22 сая ам.долларын цэвэр гадашлах урсгалтай байсан. 2012 онд хувийн уул уурхайн компанийн гаргасан гадаад бондууд (0.6 тэрбум ам.доллар) Монгол улсын хөгжлийн банк (580 сая ам.доллар) болон засгийн газрын бонд (1.5 тэрбум ам.доллар) улмаас багцын хөрөнгө оруулалтын цэвэр дотогшлох урсгал 2.3 тэрбум ам.долларт хүрсэн.

Гадаад тэнцвэргүй байдал нэмэгдэж байгаа нь гадаад валютын зах зээл болон валютын нөөцөд дарамт үүсгэж байна. (Зураг 48) Жилийн туршид 6 сар хүртэл валютын ханш аажмаар суларсан. Дотоод валютын ам.долларын эсрэг ханш нь 1 сараас 6 сарын хооронд 7.7 хувиар суларсан. Гэвч сулралт 7 сараас хурдасч – 7 сараас 9 сарын хооронд дотоодын валютын төлбөрийн тэнцлийн хэтийн төлөвт зах зээлийн сентимент муудсны улмаас 10.4 хувиар буурчээ.

Валютын нөөцийн түвшин огцом буурсан нь төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэж байгааг харуулж байна. Нийт валютын нөөцийн түвшин 2012 оны эцэст Чингис бондын орлогын (1.5 тэрбум ам.доллар) улмаас 4,125 сая ам.долларт хүрсэн. Үүнээс хойш валютын нөөцийн түвшин жилийн туршид тогтвортой буурч, 2013 оны 9 сард 2,679 сая ам.долларт хүрчээ. Хандлага нь буурч байгаа ч валютын нөөцийн түвшин нь болгоомжлолтын зориулалтад хангалттай: нийт валютын түвшин нь дөрөв орчим сарын импортын түвшинтэй тэнцэх түвшинд байна.

Зураг 52. Гадаад валютын нөөц буурч байна

Гадаад валютын нөөц (тэрбум ам.доллар, өнөөг хүртэл)



Эх үүсвэр: МБ, ДБ-мэргэжилтнүүдийн тооцоо

Зураг 53. Богино хугацаатай гадаадын хөрөнгийн түвшин бага байна

Гадаадын хөрөнгө оруулалтын байдал (2013 оны 6 сар, сая ам.доллар)



Монгол улсын өнөөгийн гадаад хөрөнгө, өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсгийг харахад, тус бүс нутагт хэд хэдэн шинээр үүсч байгаа эдийн засгууд өртөөд байсан хөрөнгийн гадагшлах урсгалаас үүдэлтэй их хэмжээний сөрөг нөлөө алга байна. 2013 оны 6 сарын байдлаар, гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдэл 15 тэрбум ам.долларт байна (Зураг 49). Монгол улсад орсон гадаадын багцын хөрөнгө оруулалтын үлдэгдэл зөвхөн 2.7 тэрбум ам.доллар байгаагаас үүний дийлэнх нь өнгөрсөн онд гарсан Чингис бондын 1.5 тэрбум ам.доллар болон МУХБ-ны 580 сая ам.долларын урт хугацааны бондын хөрөнгө оруулалт байна. Одоогийн байгаа гадаад зээл нь ихэвчилэн урт хугацааны өр төлбөр байгаа ба богино хугацааны зээл нь нийт зээлийн (3.9 тэрбум ам.долларын) зөвхөн 9 хувийг (347 сая ам.доллар) эзэлж байгаа нь нийт гадаад зээлийн дийлэнх нь засгийн газрын хөнгөлөлттэй зээл байна.

Валютын ханшны саяхны огцом хэлбэлзэл нь зах зээлийн сентимент сул байгааг харуулж байна. Дотоод валютын ханш 8 сарын сүүл болон 9 сарын эхний 2 долоо хоногийн хооронд 9 хувиар суларсан. Саяхны энэхүү хэлбэлзэл нь их хэмжээний гадаад тэнцвэргүй байдлаас үүдэж

зах зээл суурь хүчийг илэрхийлж байгаа бөгөөд энэ нь дотоодын валютад итгэх итгэл муудснаас үүдэлтэй. Гадаад худалдааны тэнцвэргүй байдал их байгаа мөн ГШХО-д бууралт гарснаас хөрөнгийн дотогшлох урсгал буурсан нь жилийн туршид дотоодын валютын ханшид үргэлжилсэн дарамт үүсгэж байна. Төсвийн болон мөнгөний тэлэх бодлогууд нь эдийн засагт хэтэрхий урамшуулал олгосноор төлбөрийн тэнцэлд дарамт үүсгэж байна. ОТ асуудлаар сунжирсан маргаантай байдал, гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалтын хүрээ нь тодорхой бус байдал өндөртэй байгаа нь зах зээлийн сентиментыг сулруулж байна.

Валютын ханшны зах зээлд гарсан саяхны үзэгдэл нь төлбөрийн тэнцлийг дарамтад чиглэсэн, хөрөнгийн шинэ дотогшлох урсгалыг татах зөв бодлогуудыг хэрэгжүүлэхийг чухалчилж байна. Гадаад валютын зах зээл нь хөрөнгийн гэнэтийн гадагшлах урсгалаас үүдсэн их хэмжээний эрсдэл байхгүй учир нь богино хугацааны зээллэг болон гадаад багцын хөрөнгө оруулалт хязгаарлагдмал байгаатай холбоотой боловч зах зээл нь хэд хэдэн сөрөг мэдээллээс үүдэлтэйгээр онцгой эрсдэлд өртөмтгий байна. Энэ утгаараа, макро эдийн засгийн бодлогын удирдлага, хөрөнгө оруулалтын орчинд бүтцийн өөрчлөлт хийх нь валютын ирээдүйн хэлбэлзлээс сэргийлэхэд тустай.

Энэ нөхцөл байдлын эсрэг, саяхан шинээр Хөрөнгө оруулалтын хууль баталсан нь зах зээлд эерэг дохио өгч, зах зээлийн сентиментыг тогтворжуулахад тусаллаа. Шинээр батлагдсан хөрөнгө оруулалтын хууль нь гадаад болон дотоод хөрөнгө оруулагчид аль аль нь ажиллах суурь болох бөгөөд дунд хугацаанд хөрөнгө оруулалтын тогтвортой орчинг хангах зорилготой. (Хайрцаг 7). Ирэх саруудад холбогдох хуулийн орчинд үргэлжилэн сайжруулалт гарах нь шинэ Хөрөнгө оруулалтын хууль гаргасан эерэг суурийг улам сайжруулахад тустай.

Макро эдийн засгийн зөв бодлогууд нь төлбөрийн тэнцлийн дарамтын суурь шалтгаануудыг шийдэхэд чухал байна. Саяхны баталсан хөрөнгө оруулалтын хуулийг оруулаад хөрөнгө оруулалтын орчин сайжрах нь гадаад хөрөнгө оруулалтыг ирээдүйд татахад туслах бөгөөд гадаад хөрөнгө оруулагчид Монгол улсад шинэ хөрөнгө оруулалт хийх амлалт үзүүлэх, өөрсдийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт хийхэд тодорхой хугацаа шаардлагатай. Мөн төсвийн болон мөнгөний хүчтэй тэлэх бодлогоор дэмжигдсэн нийт эрэлт хүчтэй байгаа нь импортыг экспортоос даван гарахад хүргэж байна; хэдийгээр ОТ уурхайгаас экспортыг нэмэгдүүлж байгаа ч нийт эрэлт бууруулахгүй бол урсгал дансны алдагдал өндөр хэвээрээ байхаар байна. Энэ утгаараа макро эдийн засгийн бодлогууд нь өсөн нэмэгдэж байгаа урсгал дансны алдагдлыг шийдэхэд чухал байна.

Монгол улсын удирдлагууд олон улсын санхүүгийн зах зээл Монгол улсын эдийн засаг, улс төрийн орчинг хэрхэн харж байгаад онцгой анхаарлаа хандуулах хэрэгтэй. Сайн нэг үзүүлэлт нь Чингис бонд болон МУХБ-ны бондуудын хоёрдогч зах зээлийн үр өгөөж байх юм. Чингис бондыг 2012 оны 12 сард гарсан; таван жилийн хугацаатай 500 сая ам.долларыг 4.125 хүүтэй, мөн 1 тэрбум ам.долларыг арван жилийн хугацаатай 5.125 хувьтай гаргасан. Таван жилийн хугацаатай МУХБ-ны 580 сая

Зураг 54. Засгийн газрын бондын өгөөж хэлбэлзэлтэй байна

Хугацаа нь дуусах хүртэл зах зээлийн бондын өгөөж: Чингис болон МУХБ бонд (%)



ам.долларыг 2012 оны 3 дугаар сард 5.75 хүүтэй гаргасан.

Засгийн газрын бондын зах зээлийн өгөөж нь жилийн туршид тогтвортой өсөх хандлагатай байсан бол 6 сарын дунд үеэс хурдасч эхэлсэн нь төсвийн байдал, эдийн засгийн төлөв байдлаар асуудал нэмэгдэж байгааг илэрхийлж байна. 10 жилийн хугацаатай Чингис бондын өгөөж нь 9 сарын 9-нд валютын ханш хурдацтайгаар суларч байх үед хамгийн өндөр түвшиндээ буюу 8.1 хувиас илүү байлаа. Валютын ханшийг тогтворжуулсан, шинэ хөрөнгө оруулалтын тухай хууль гаргасан болон 2013 болон 2014 онуудад төсвийг сайжруулах төлөвлөгөө зэрэг хэд хэдэн эерэг мэдээллийн дараагаар 9 сарын дунд үеэс тогтворжиж эхэлсэн.

Засгийн газрын бондыг зах зээл хүлээн авч байна гэдэг нь Монгол улс дэлхийн санхүүгийн зах зээлийн нэг хэсэг болж байна гэсэн үг. Бондын өгөөж өндөр хэлбэлзэмтгий байна гэдэг нь дэлхийн санхүүгийн зах зээл Монгол улсын эдийн засгийн хөгжил, тогтвортой байдлыг түүний эдийн засгийн бодлогоор тогтмол хянаж байгааг хэлж байна. Засгийн газрын бондын өгөөж өндөр байна гэдэг нь ирээдүйн засгийн газрын гадаад санхүүжилт нь 2012 онд бидний харсан шиг тааламжтай нөхцөл байхгүй байгааг мөн илэрхийлнэ, энэ үед дэлхийн хөрвөх байдал нэмэгдсэн, АНУ хүчтэй тоо хэмжээний сулруулалт хийж эхэлснээр олон улсын хөрөнгө оруулагчид илүү өндөр өгөөжтэй бондыг хайх хандлагатай болсны улмаас шинээр үүсч байгаа бондын зах зээлд нэмэлт өсөлтийг авчирсан.

Олон улсын зээлжих зэрэглэлийн агентлагуудын[11] гаргасан хэд хэдэн зөвлөмжид олон улсын хөрөнгө оруулагчдын зүгээс засгийн газрын бондын өгөөжийг хэлбэлзүүлэхэд юу нөлөөлж байгааг гаргаж тайлбарласан байна. Бүх л зээлжих зэрэглэлийн агентлагууд Монгол улс нь баялаг байгалийн нөөцийн улмаас эдийн засгийн хүчтэй өсөлт үзүүлэх боломжтойг хүлээн зөвшөөрсөн. Гэвч олон тооны олон улсын зээлжих зэрэглэлийн агентлагуудыг хэлж байгаа нийтлэг эрсдлийн хүчин зүйлсүүдэд анхаарлаа хандуулах ёстой. Тэд: (i) дэлхийн уул уурхайн зах зээлийн мөчлөгийн хэлбэлзэмтгий байдлаас үүдэлтэйгээр тухайн улсын эдийн засаг нь уналт-өсөлтийн мөчлөгт хэт эмзэг байна; (ii) макро эдийн засгийн тэлэх бодлогуудын улмаас гадаад тэнцвэргүй байдал улам муудаж байгааг; (iii) төсвөөс гадуурхи зарлага дээр суурилсан мөчлөг дагасан сангийн бодлого болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төсвийн зарчмуудыг үл харгалзан өрөөр санхүүжих; (iv) хөрөнгө оруулалтын таамаглашгүй тогтолцоо; мөн (v) зээлийн хурдацтай өсөлтийн үед банкны салбарын эмзэг байдал болон ил тод байдал, Хадгаламж банкны саяхны үйл явдал.

[11] Мүүдийз (9 сарын 5), Эс энд Пи (5 сарын 15), Фитчс (7 сарын 29)

Хайрцаг 8. Хөрөнгө оруулалтын шинэ хуулийн гол шинжүүд

Монгол улс дахь хөрөнгө оруулалтын сентимент 2012 оноос эхлэн муудсан нь ОТ гэрээнд шинэ хэлэлцээрүүд хийсэн тодорхой бус байдлын хажуугаар стратегийн салбаруудад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтын хуулийг (СҮАЯБААНГХОЗТХ) баталснаас үүдэлтэй. (2012 оны 5 сар) Гадаадын хөрөнгө оруулалт 2013 онд мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан нь Монгол улсын Засгийн газраас хөрөнгө оруулалтын зохицуулалтыг сайжруулснаар хөрөнгө оруулагчийн итгэлийг дахин сэргээхийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч СҮАЯБААНГХОЗТХ болон хуучин Гадаадын Хөрөнгө оруулалтын тухай хуулийг (1993) шинээр боловсруулж эхэлсэн. Хуулийн бэлтгэлийг хөрөнгө оруулагчидтай олон удаа зөвлөлдсөн мөн Дэлхийн банк, ОУВС зэрэг олон улсын санхүүгийн институциудын техник зөвлөлгөөнд хийсэн.

Хөрөнгө оруулалтын хууль нь гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдын хуулийн эрх, сонирхолыг хамгаалах, татварын орчинг тогтворжуулах зорилготой. Энэхүү хуулийн гол шинжүүдэд:

- **Хөрөнгө оруулалтын батлах үйл явцыг хялбаршуулах.** Уг хууль нь СҮАЯБААНГХОЗТХуулийг өөрчилж, хөрөнгө оруулалтыг батлах эсвэл бүртгэх үйл явцыг хялбаршуулсан. Хуулиас стратегийн гэх салбаруудын тодорхойлолтыг гаргаж авсан. Гадаадын хувийн хөрөнгө оруулагчид нь засгийн газар эсвэл их хурлаас зөвшөөрөл авах шаардлагагүй боловч зөвхөн улсын агентлагт бүртгүүлэх ёстой.

- **Гадаадын засгийн газрын эзэмшил бүхий аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт.** Хэрвээ гадаадын засгийн газар нь хөрөнгө оруулагчийн 33 эсвэл түүнээс дээш хувийг эзэлж байвал тусгай үйл явц шаардагдана. Эдгээр хөрөнгө оруулагчдын хувьд, бүртгэлийг төрийн агентлагд өгөх бөгөөд түүний (i) үндэсний аюулгүй байдал, (ii) зах зээл дээрх өрсөлдөөн, (iii) засгийн газрын төсөв болон бодлогуудад хэрхэн нөлөө үзүүлж байгааг авч үзнэ. Уг шийдвэрийг бүртгэлийг авсны дараа 45 хоногийн дотор төрийн агентлаг нь гаргана.

- **Татварыг тогтворжуулах**. Уг хууль нь татварын дөрвөн төрөлд татварыг тогтворжуулах заалтыг оруулсан: ААНОАТ, Гаалийн татвар, НӨАТ, болон АМНАТ. Татварыг тогтворжуулах зорилгоор, тодорхой шаардлагуудыг хангасан хөрөнгө оруулалтад тогтворжуулах сертификатыг олгоно жишээ нь, шинэ ажлын байр эсвэл шинэ технологи бий болгож байгаа хөрөнгө оруулалт. Татварын тогтворжуулалтаар дөрвөн төрлийн татварын хувийг сертификатын үргэлжлэх хугацаанд өсгөхгүй бөгөөд сертификат бүхий хөрөнгө оруулагчид эдгээр татварын хувиуд буурахаас ашиг хүртэж болно.Тогтворжуулах сертификатын хугацаа нь салбар, хөрөнгө оруулалтын хэмжээ болон байршилаас өөр өөр байх бөгөөд таван бүсэд хуваагдана. Уул уурхай, хүнд аж үйлдвэрлэл болон дэд бүтцийн салбаруудад хөрөнгө оруулалтын хэмжээнээс (30 тэрбум төгрөгөөс эхлэн) хамаарч 18 жил хүртэл татварын тогтворжуулалт байна. Өөр салбаруудын хөрөнгө оруулалт нь хөрөнгө оруулалтын хэмжээ (10 тэрбум төгрөөс эхлэн) болон бүс нутгаас хамаарч татварын тогтворжуулалт нь 15 жил хүртэл байна. Тодорхой шалгууруудыг хангасан хөрөнгө оруулалтын хувьд татварыг тогтворжуулах хугацаа нь 1.5 дахин урт байна, жишээ нь импортыг орлуулагч эсвэл экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч эсвэл 500 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө оруулалт.

- **Татварын болон татварын бус урамшууллууд.** Татварын хөнгөлөлт болон урамшууллууд байх боловч татварын урамшуулын дэлгэрэнгүйг холбогдох татварын хуулиар цаашид зааж өгөхөөр болсон. Импортын техникийн тоног төхөөрөмжүүд нь гаалийн татвар болон НӨАТ-аас чөлөөлөгдөх боловч барилгын ажлын үед тэг хувьтай болох талтай. Холбогдох хуулийн зохицуулалтаар татварын бус урамшууллыг заагаагүй.

- **Хөрөнгө оруулалтын гэрээ болон хамгаалалт.** Монгол улсын засгийн газар нь хэрвээ хөрөнгө оруулагчийн хүсэлт нь бизнесийн үйл ажиллагааны орчинг тогтворжуулах зорилготой хүсэлтийг тавьж 500 тэрбумаас дээш хөрөнгө оруулалтыг хийхээр бол уг хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулна. Уг хууль бараг бүхий л стандарт баталгаанууд багтаасан бөгөөд энэ утгаараа Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиас (1993) илүү нарийн боловсруулагдсан. Мөн олон улсын болон дотоодын арбитрт хандах боломжтой болсон.

Уг хууль нь ССҮАЯБААНГХОЗТХуулиас эерэг ахиц болгосон учир нь энэ нь үйл явцыг нэлээд хэмжээгээр хөнгөвчилсөн мөн татварын дарамт болон хөрөнгө оруулагчийг хамгаалах чиглэлээр илүү тогтвортой орчинг бий болгосон. Хөрөнгө оруулалттай холбоотой хууль тогтоомжид цаашид хоорондоо уялдаатай сайжралтыг бий болговол шинэ хөрөнгө оруулалтын хуулиар бий болсон эерэг үр дүнг улам нэмэгдүүлнэ.

Эх үүсвэр: ДБ мэргэжилтнүүд

Хайрцаг 9. Монгол улс 2014 Бизнес хийх тайланд бизнес хийхийг хялбаруулах тал дээр амжилт гаргасан

Бизнес хийх тайлангийн талаархи танилцуулга. *Бизнес хийх* судалгаа нь Дэлхийн банкны дөрвөн чухал тайлангуудын нэг бөгөөд 2003 онд хийж анх удаа Бизнес Хийх 2004 тайланг нийтлүүлж байжээ. *Бизнес хийх* тайлан нь жижиг дунд аж ахуйн нэгжүүдэд хамаарч буй зохицуулалтыг тэдгээрийн үйл ажиллагааны мөчлөгөөр 11 хэсэгт авч үздэг: бизнесээ эхлүүлэх, барилгын зөвшөөрөх авах, цахилгаан эрчим хүчээ авах, өмчөө бүртгүүлэх, зээл авах, хөрөнгө оруулагчдыг хамгаалах, татвараа төлөх, хилээр дамжуулж худалдаа хийх, гэрээ хэлэлцээр хийх, төлбөрийн чадваргүй байдлыг шийдэх болон ажиллагсад авах.

Эдгээр хэсгүүдийг хоёр төрлийн үзүүлэлтээр авч үзнэ. Нэгдүгээр төрлийн үзүүлэлт нь зохицуулалтын үйл ажиллагааны төвөгтэй байдал болон өртөгийг хэмждэг—тухайн орон нутгийн аж ахуй хэрэглэгч нийтлэг ажил гүйлгээг тухайлбал компанитай нэгдэх эсвэл эрчим хүчтэй холбох зэрэг үйл ажиллагааг холбогдох дүрэм зохицуулалтын дагуу хийж дуусгах хугацааны үр ашгийг нь үнэлдэг. Хоёрдох төрлийн үзүүлэлтүүд нь хууль эрхзүйн институциудын хүчин чадлыг хэмждэг—энэ нь дотоодын бизнесийн хуулиудын онцлог хэв шинжүүдийг үнэлдэг, жишээ нь хөрөнгө оруулагчдыг хамгаалах эсвэл зээл авах зэрэгт. Эдгээр жишээнүүдэд хэв шинжүүдэд өндөр үнэлгээг авах тусмаа хөрөнгө оруулагчид эсвэл хамгаалагдсан зээлдэгчдэд хүчтэй хамгаалалт байгааг илэрхийлнэ.

Бизнес хийхэд хялбаршуулахад нийт зэрэглэлийг хийхэд арван зүйлийг оруулсан. Бизнес хийхийг хялбаршуулсан индекс нь эдийн засгуудыг 1-ээс 189 хүртэл зэрэглэсэн. Улс орон бүрт зэрэглэл нь *Бизнес хийх 2014* индексэд орсон арван зүйл тус бүрд авсан зэрэглэлийн хувийн энгийн дунджаар тооцсон.

Монгол улс нь Бизнес хийх 2014 тайланд нийт 189 орнуудаас бизнесийг хялбаршуулсан зэрэглэлээр 76th дугаар **байрт орж байгаа нь 2013 оны тайлангаас 4 зэрэглэлээр сайжирсан байна.** Энэхүү тайлангаар Монгол улсыг 2012 оны 6 сарын 1-ээс 2013 оны 6 сарын 1 хүртэл бизнесийг хийхэд хялбар болгоход гурван төрлийн зохицуулалтын шинэчлэл хийснийг хүлээн зөвшөөрсөн байна: (i) бизнесээ эхлүүлэх, (ii) барилгын зөвшөөрөл авахад, мөн (iii) цахилгаан эрчим хүчтэй холбох. Монгол улсад компаний статусыг авах, нотариатаар баталгаажуулах, шинэ компанийг татварын албанд бүртгүүлэх шаардлага зэргийг олон шаардлагуудыг байхгүй болгосноор бизнес эхлэхэд хялбар болгосон. Мөн барилгын зөвшөөрлийг авахдаа барилгын техникийн шаардлагыг бага болон дунд хэмжээний эрсдэл бүхий барилгын төслүүдэд улсын байгууллагаар дахин хянах шаардлагыг байхгүй болгож хялбаршуулжээ. Мөн түүнчлэн цахилгаан эрчим хүчийг авахад хялбар болгосон, хэрэглээний дотоод үйл явцыг сайжруулсан, холболтын үйл явцын янз бүрийн үе шатанд цаг хугацааны хязгаарлалтыг хялбаршуулж, суурилуулах тестэд төлөх төлбөрийг байхгүй болгожээ.

Бизнесийн зохицуулалтын гурван салбарт шинэчлэл хийгдснээр Монгол улсын хязгаарлалтын үзүүлэлтийн зай 60.2 байснаа 61.6 болж сайжирчээ. *Бизнес хийх тайлан 2012 –д* хязгаарын хэмжүүрт ойртох хэмжээ гэдэг үзүүлэлтийг бий болгосон бөгөөд энэ нь тухайн орны үйлдвэрлэл эрхлэгчдэд зохицуулалтын орчин хэрхэн сайжирсныг абсалют утгаар нь хэмжиж үзүүлэ бөгөөд үзүүлэлтүүдийг анх цуглуулсан 2003 оноос эхлэн бүх эдийн засгийн хувьд *Бизнес эрхлэх* тайлангийн үзүүлэлт бүрийн ажиглагдаж байсан хамгийн сайн үзүүлэлтийг харуулж чадах “хязгаар” үзүүлэлтэд нь тухайн эдийн засгийн харьцуулах замаар зайг үзүүлнэ. Уг үзүүлэлтийг 0-100 хооронд нормальжуулах бөгөөд 100 гэдэг нь хязгаарыг үзүүлнэ.

Бизнес эрхлэхийг хялбаршуулах тал дээр дэлхийд Сингапур улс хамгийн өндөр зэрэглэлтэй бөгөөд үүний дараагаар Хонг Конг, БНХАУ, Шинэ Зеланд, Малайз болон БНСУлс эхний 10-т орж байна. Энэ жилийн хувьд Филиппин улс хамгийн сайн сайжралт гаргасан дэлхийн 10 оронд багтсан—эдгээр эдийн засагт сүүлийн жилийн хугацаанд бизнесийн зохицуулалтад хамгийн их сайжралтууд гарчээ. Зүүн Ази болон Номхон далайн 25 эдийн засагт, Вьетнам болон БНХАУ нь хамгийн их бизнесийн зохицуулалтын шинэчлэлийг хэрэгжүүлсэн. Вьетнам энэ хугацаанд хамгийн их буюу 21 шинэчлэлийг хийсэн бол араас нь БНХАУ нь 18 шинэчлэлийг хийжээ. Зүүн Ази болон Номхон далайн 25 эдийн засгийн 15-д нь 2012 оны 6 сарын 2-оос 2013 оны 6 сарын 1-ны хооронд хамгийн бага шинэчлэлийг хийжээ—нийтдээ 25 шинэчлэл. БНХАУ нь 2005 оноос хойш дэлхийн сайн практикийн ялгааг бууруулах тал дээр ажилласан 20 эдийн засгийн нэгэнд орж байна. Лаос, Тимур Лесте, Малайз, Камбожи, Соломоны арлууд нь энэхүү ялгааг багасгасан эхний 50 улсад багтаж байна.

Эх үүсвэр: Бизнес эрхлэх тайлан 2014, Дэлхийн банкны бүлэг (2013 оны 10 сар)

Бүлэг III. Эдийн засгийн хөгжлийн ерөнхий үнэлгээ болон бодлогын зөвлөмжүүд

Эдийн засаг нь төлбөрийн тэнцлийн тэнцвэргүй байдал нэмэгдэж байгаа болон эдийн засгийн тодорхой бус байдлаас асуудалтай тулгарч байна …

Монгол улсын эдийн засаг нь сүүлийн хоёр жилд онцгой дэвшил гаргасан бөгөөд дунд хугацааны хэтийн төлөв нь өөдрөг байна. Сүүлийн хоёр жилийн хугацаанд дэлхийд хамгийн хурдан өсч буй эдийн засаг болж гарч ирсан бөгөөд орлого нэмэгдснээр энэ хугацаанд ядуурлын түвшин 11.3 хуиар буурахад тусалсан. Хэдийгээр гадаад орчин тааламжгүй байгаа ч өсөлт 2013 онд хоёр оронтой тоонд байхаар байна. Уул уурхайн голлох үйлдвэрлэлүүд, зэс, нүүрс болон алтны үйлдвэрлэл нэмэгдэхээр байгаа нь дунд хугацааны хэтийн төлөвийг өөдрөг болгож байна.

Эдийн засаг нь уул уурхайн хэлбэлзэл ихтэй зах зээлийн мөчлөгт илүү өртөмтгий болж байгаа бөгөөд гадаадын дотогшлох урсгалаас илүү хамааралтай боллоо. 2011 онд 17.5 хувийн өсөлт гаргасан нь гадаадын хөрөнгийн дотогшлох урсгал болон төсвийн тэлэх бодлогын үр дүн байсан. Хоёр оронтой өндөр өсөлт нь гадаад шокод өртөх байдлыг нэмэгдүүлсэн. Импорт бараг жилийн хугацаанд бараг хоёр дахин нэмэгдсэн нь тухайн цаг үед уул уурхайн зах зээл сайн байснаас экспорт 65 хувиас илүү хэмжээтэйгээр нэмэгдсэн нь импорт нь экспортын өсөлтийг даван гарсан. Энэ нь дэлхийн уул уурхайн зах зээлд гэнэтийн уналт болоход их хэмжээний худалдааны алдагдал бий болсныг үзүүлэх бөгөөд гадаад худалдааны алдагдлыг их хэмжээний гадаадын хөрөнгийн дотогшлох урсгалаар нь тогтоон барих боломжтой. Дэлхийн уул уурхайн зах зээлийн байдал хүчтэй сулрахад 2012 онд гадаад нөхцөлд өртөмтгий байдал илт нэмэгдсэн. Дэлхийн нүүрсний зах зээл унаснаар нийт экспорт буурч, 2011 онд бий болсон импортын хүчтэй эрэлт нь 2012 онд урсгал дансны алдагдлыг өсгөж, ДНБ-ий 32 хувиас дээш хэмжээнд хүрсэн. Гэвч хэрвээ эдийн засагт их хэмжээний хөрөнгийн дотогшлох урсгал орж урсгал дансны алдагдлыг бүрэн санхүүжүүлж байвал урсгал дансны алдагдал нэмэгдэх нь том эрсдэл бус юм.

2013 онд Монгол улсын эдийн засаг нь ГШХО урсгал буурсан, уул уурхайн экспорт сул байгаагаас гадаад тэнцвэргүй байдлаас үүссэн асуудалтай тулгараад байна. Хөрөнгийн дотогшлох урсгал буурч байгаа нь урсгал дансны алдагдлын зөвхөн тал хувийг л санхүүжүүлэх боломжтой байна. Төлбөрийн тэнцлийн дарамт нэмэгдэж байгаа нь гадаад валютын нөөц болон гадаад валютын зах зээлд тусч эхэллээ. Гадаад валютын нөөц 2012 оны эцэст хамгийн өндөр түвшинд хүрч байснаас ойролцоогоор 30 хувиар буурчээ. Гадаад нөхцөл байдал муудснаас дотоодын мөнгөн тэмдэгт дарамтад орж, 7 сараас эхлэн их хэмжээний хэлбэлзэлтэй байна.

Төлбөрийн тэнцэл асуудалтай байгаа нь 2011 оноос хойш эхэлсэн мөчлөгийг дагасан эдийн засгийн удирдлагын үр дүн нь нийт эрэлтийг өсгөснийг мөн илэрхийлж байна. Уул уурхайгаар эхэлсэн хөгжлийн эхэн үед улс орон худалдааны алдагдал өндөр байдаг талтай учир нь уул уурхайн хөрөнгө оруулалтын тоног төхөөрөмжийг өсөлтийг шаарддаг. Оюу толгойн уурхайн бүтэн хүчин чадал нь – бүрэн дүүрэн ашиглавал нийт эдийн засгийн өсөлтийн гуравны нэгийг

бүрдүүлэх боломжтой – боловч түүний далд уурхайн хөрөнгө оруулалт дуусаагүй үед хэрэгжих боломжгүй. Гэвч сүүлийн хоёр жилийн мөчлөгийг дагасан эдийн засгийн удирдлага нь нийт эрэлтийг ихээхэн нэмэгдүүлж гадаад худалдааны ихээхэн тэнцвэргүй байдалд хүргэсэн нь уул уурхайн зах зээлийн сунжирсан уналт бий болж байгаа үед дунд болон урт хугацаанд тогтворгүй байх талтай.

Макро эдийн засгийн бодлогууд нь зөвхөн эдийн засгийг болон өсөлтийг урамшуулахад чиглэгдэж байгаа нь төлбөрийн тэнцэл болон инфляцийн дарамтыг нэмэгдүүлж байна. Сүүлийн хоёр жилд үргэлжлүүлэн хуримтлагдсан төсвийн алдагдлын дараа ч 2013 онд төсвийн бодлого нь тэлэлт өндөртэй хэвээрээ байгаа нь их хэмжээний төсвөөс гадуурхи улсын хөрөнгө оруулалтын зарлагаас үүдэлтэй бөгөөд энэ нь төсвийн алдагдлыг ДНБ-ий 12 хувиас илүү түвшинд авчирч байна. Мөнгөний бодлого нь мөн 2013 онд тэлэх болсон бөгөөд ДНБ-ий 20 гаран хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг төв банкны татаас бүхий зээллэгийн хэлбэрээр салбаруудад оруулсан. Эдгээр тэлэх бодлогууд нь эдийн засгийг эхний хагас жилд хоёр оронтой байлгахад тусалсан боловч дотоодын хүчтэй эрэлтийн өсөлт болон импортоос хэт хамааралтай барилгын салбарын өсөлтөөс бий болсон өсөлт нь төлбөрийн тэнцлийн дарамтын эрчимжүүлж байна. Монгол улсын эдийн засгийн удирдлага нь нэлээд тэлэлт бүхий байсан нь их хэмжээний урсгал дансны алдагдал болон өндөр инфляцид хүргэлээ. (Хайрцаг 9).

- **Одоогийн хэрэгжүүлж байгаа эдийн засгийн сул бодлогууд нь төлбөрийн тэнцлийн дарамт нэмэгдэж байгаа энэ үед тогтворгүй бөгөөд макро эдийн засгийн ирээдүйн тогтвортой байдлыг муутгаж байна.** Засгийн газраас нэмэгдэж байгаа гадаад тэнцвэргүй байдал болон төсвийн санхүүжилтийн ялгааг бууруулах чиглэлээр хэд хэдэн эерэг арга хэмжээг авсан. Гэчв өнөөгийн эдийн засгийн бодлогын хүрээнд, их хэмжээний төлбөрийн тэнцлийн дарамт нь ойрын ирээдүйд ихээр буурахгүй байхаар байгаа нь их хэмжээний импортын эрэлттэй, уул уурхайн зах зээлийн сэргэлт тодорхой бус байдалтай байна. Тухайн бүс нутгийн улс орнуудтай харьцуулбал Монгол улсын эдийн засгийн удирдлага нь их хэмжээний тэлэлтийн байдалтай байгаа нь их хэмжээний урсгал дансны алдагдал болон өндөр инфляцийг бий болгож байна. (Хайрцаг 9). Хэрвээ одоогийн тэлэлт, эдийн засгийн сул бодлого үргэлжилбэл төлбөрийн тэнцлийн нэмэгдэж буй дарамт тогтворгүй бөгөөд дунд хугацаанд эдийн засгийн хүчтэй зохицуулалт хийх хэрэгтэй болно. **Өнөөгийн эдийн засгийн бодлогын хүрээнд төлбөрийн тэнцлийн их хэмжээний дарамт үргэлжилэхээр байна**: (i) импортын эрэлт нь– одоогоор экспортоос 1.6 дахин илүү байгаа бөгөөд – зээлийн хурдац хэвээрээ, МУХБ төсвөөс гадуурхи зарлага нэмэгдэж байгаатай холбоотойгоор хэрэглээ болон барилгын үйл ажиллагаа хурдасвал илүү хурдан өсөх болно; (ii) гол нүүрсний уурхайнуудад үйлдвэрлэл нэмэгдэх төлөвлөгөөтэй байгаа тул Хятад улсад нийлүүлэлтийн илүүдэлтэй байгаа болон хүчтэй өрсөлдөөний дүнд нүүрсний экспорт ирэх саруудад сул хэвээрээ байхаар байна; (iii) ОТ уурхайгаас үүсэх төлбөрийн тэнцлийн нөлөө ирэх саруудад хязгаарлагдмал байх болно учир нь уурхайн бүрэн хүчин чадлыг түүний хоёрдахь үе шат дууссаны дараа мөн экспортын орлогын нэлээд их хувийг нь уурхайн гадаад хөгжлийн зардлыг эргэн төлөхөд ашиглагдсны дараа гарч ирнэ; (iv) хэдийгээр шинээр Хөрөнгө оруулалтын хуулийг баталсан ч гадаадын их хэмжээний хөрөнгийн дотогшлох урсгал эргэн бий болоход цаг хугацаа шаардлагатай учир нь боломжит хөрөнгө оруулагчид өөрсдийн бизнесийн төлөвлөлт болон шинэ хөрөнгө оруулалтын амлалтуудад тохируулга хийгдэнэ.
- **Төлбөрийн тэнцэл үргэлжлүүлэн муудаж байгаа нь валютын нөөц болон гадаад валютын зах зээлд нэмэлт дарамт бий болгох талтай.** Хэдийгээр гадаад валютын нөөц нь хангалттай түвшинд байгаа ч өнөөгийн байдлаар нөөц буурвал дунд хугацаанд тогтворгүй болох талтай. Хэдийгээр өнөөгийн ханшны сулралт нь импортын эрэлтийг

бууруулах, экспортын өрсөлдөх чадварыг тодорхой хэмжээнд сайжруулахад тустай боловч импортын дотоодын хэрэглээ импортоос хамааралтай байдалд инфляцийн дарамтыг нэмэгдүүлж, банкны салбарын эрүүл байдалд сөрөг эрсдлийг үүсгэх талтай.

- **Төсвийн алдагдал болон улсын өр нэмэгдэж байгаагаас гадаадад байдалд үүсч болох шок болон уул уурхайн салбарын байдалд улам муудах үед удирдах төсвийн орон зай улам багасаж байна.** Улсын өрийн ДНБ-д харьцуулах харьцаа нь 2010 онд 35 хувь байснаа 2012 онд их хэмжээний гадаад өр гаргасан мөн дотоодын өр хуримтлагдснаас уг харьцаа 63 хувьд хүрсэн. Төсвийн чадавхи муудаж байгаа нь эдийн засгийн уналтын үед засгийн газрын гадаад санхүүжилтийг хийх чадавхид хязгаарлагдмал байдал үүснэ учир нь олон улсын санхүүгийн зах зээл нь төсвийн суларч байгаа байдлаас үүдэж илүү өндөр өртэгтэй зээллэгт хүрэх болно.
- **Хэдийгээр ГШХҮ буурч байгаа үед зээлийн өсөлтийг хадгалж байх нь чухал байсан боловч мөнгөний нэмэлт сулруулалт нь банкны тогтолцооны өртөмтгий байдлыг нэмэгдүүлж, эдийн засгийн тэнцвэргүй байдалд орох талтай.** Хувийн зээлийн өсөлт нь 9 дүгээр сард 48 хувь хүртэл хурдассан нь банкны салбарыг эдийн засгийн учирч болзошгүй уналтад илүү өртөмтгий болгож байна учир нь зээлийн өсөлт нь барилгын болон орон сууцны салбарт төвлөрсөн түүний эдийн засгийн мөчлөгт өртөмтгий байдал хэвээрээ байна. Үүнээс гадна зээлийн хурдацтай өсөлтийн макро эдийн засгийн тогтвортой байдалд үзүүлэх сөрөг нөлөө нь валютын ханшны сулралт хурдасч байгаа, инфляци нэмэгдэж байгаагаар илэрч байх талтай. Мөнгөний сулруулах хөтөлбөрийг хүрээнд оновчтой зохицуулалтыг бодлогын зээлүүдэд сулруулсан нь банкны зээлжилтэнд ёс суртахууны гажуудлыг нэмэгдүүлж, банкны салбарын ил тод байдлыг муутгана.

Хэрвээ Монгол улсын эдийн засаг нь дэлхийн эдийн засгийн тааламжгүй нөхцөл байдалд өртөж буй байдал нэмэгдвэл сөрөг эрсдэл нь улам өсөхөөр байна. Өнөөгийн бодлогуудад, эдгээр гарч болох гадаад шокыг давж гарах бодлогын хавхавчууд хязгаарлагдмал байна, учир нь төлбөрийн тэнцлийн дарамт нэмэгдэж байгаа, төсвийн алдагдал болон улсын өр өсч байгаа мөн инфляци өсч байна. Хятадын эдийн засгийн хөрөнгө оруулалтад чиглэсэн өсөлтөөс илүү хэрэглээнд суурилсан өсөлтөд оновчгүй замаар чиглүүлбэл энэ нь хятадын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлнө. Хөгжсөн эдийн засгуудад сүүлийн жилүүдэд эрчимтэй хийгдэж байсан тоо хэмжээний сулруулалтыг ойрын ирээдүйд зогсоовол шинээр үүсч буй эдийн засагт орох хөрөнгийн урсгалыг сулруулж, зээлжилтийн өртөгийг нэмэгдүүлнэ. Зарим шинээр үүсч буй орнууд– ялангуяа их хэмжээний урсгал дансны алдагдалтай, гадаадын хөрөнгөөс хэт хамаарсан – нь хэдийнээ хөрөнгийн хүчтэй гадагшлах урсгалыг амсөөд байгаа бөгөөд сүүлийн саруудад дотоодын валют суларч, дэлхийн санхүүгийн нөхцөл байдал өөрчлөгдөх үед макро эдийн засгийн бодлогын халхавчуудыг бэлтгэж, өөрсдийн хөрөнгө оруулалтынхаа орчинг сайжруулж эхлээд байна. Уул уурхайн зах зээл ойрын ирээдүйд сул хэвээрээ байхаар байгаа нь нийлүүлэлтийн нөхцөл байдал сайн, гол бүтээгдэхүүнүүд, нүүрс болон зэсийг оруулаад экспортлогчдын дунд өрсөлдөөн нэмэгдэж байна.

Хайрцаг 10. Монгол улс болон тус бүс нутагийн орнуудын макро эдийн засгийн бодлогууд

Эдийн засгийн бодлогуудын үнэлгээгээр, Монгол улсын эдийн засгийн бодлогын нөхцөл байдлыг тухайн бүс нутаг дахь орнуудынхтай харьцуулж болно. Энэ хайрцаг нь Зүүн Ази болон Номхон далайн орнуудын бусад орнууд болон Монгол улсын хооронд эдийн засгийн үндсэн параметрүүд болон бодлогын хувьсагчдыг харьцууллаа. (Зураг 51).

Хэдийгээр Монгол улс бүс нутагтаа хамгийн өндөр өсөлттэй байгаа боловч бусад орнуудтай харьцуулбал их хэмжээний үргэлжилсэн гадаад болон дотоод тэнцвэргүй байдалтай байна.

- Сүүлийн гурван жилд тус бүс нутаг дахь бусад орнуудтай харьцуулбал урсгал дансны

тэнцлийн ДНБ-д харьцуулсан харьцаа нь хамгийн өндөр байсан. Мөн Лаос болон Папуа Шинэ Гвинейн улсуудын урсгал дансны ДНБ-д харьцуулах харьцаа нь 15-20 хувьд оршиж байна. Бусад эрдэс баялаг экспортлогч орнууд (жишээ нь Индонез, Мьянмар) зэрэг улсуудад урсгал дансны алдагдал нь муудай байгаа боловч түүний ДНБ-д харьцуулсан харьцаа нь Монгол эсвэл бусад хоёр оронтой харьцуулбал бага байна.

- Монгол улсын инфляцийн түвшинд нь бүс нутагтаа Вьетнамаас бусдаас нь хамгийн өндөр байна. Гэвч Вьетнам улсын инфляцийн түвшин нь сүүлийн хоёр жилийн хугацаанд буурах хандлагатай байсан. Индонез улсад инфляци 2013 онд 9.8 хувь байсан нт 2005 оноос хойш анх удаа татаастай байсан түлшний үнийг нэмэгдүүлсэнтэй холбоотой.

- Монгол улсын нь сүүлийн гурван жилд их хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт буурсан. Монгол улс нь ДНБ-тэй харьцуулсан ГШХО урсгал нь хамгийн өндөр хувь байсан бол түүний хувь 2011 онд 58 хувь байснаа 2013 онд 20 хувиас доош буухаар байна.

Төсвийн болон мөнгөний бодлогын хувьсагчдаас харахад тэлэх бодлогууд нь өндөр өсөлтийг суурь нь байсан бөгөөд их хэмжээний гадаад болон дотоод тэнцвэргүй байдлын ч суррь болжээ. Монгол улсын төсвийн алдагдал сүүлийн хоёр жилд бүс нутагтаа хамгийн өндөр байсан бөгөөд 2013 онд цаашид өсөхөөр байна. Ихэнх орнууд дэлхийн санхүүгийн хямралыг удирдахын тулд бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаагийн улмаас төсвийн өндөр алдагдалтай байгаа нь түүний ДНБ-д харьцуулсан харьцаа нь Монгол улсынхаас хамаагүй доогуур байна. Эдийн засгийн параметрүүд болон бодлогы хувьсагчдын бүс нутгийн харьцуулалтаас харахад Монгол улс нь илүү тэлсэн эдийн засгийн бодлогуудаар дамжих илүү өндөр өсөлтөд хүрч байна. Үүний үр дүнд Монгол улс нь бүс нутгийн улсуудтай харьцуулбал их хэмжээний гадаад тэнцвэргүй байдалд орж инфляци өндөр байна.

Зураг 55. Эдийн засгийн үндсэн параметрүүд болон бодлоны хувьсагчдаар хийсэн бүс нутагийн харьцуулалт



Төсвийн алдагдал (ДНБ-д харьцуулсан)



Дотоодын зээлийн өсөлт (өмнөх оны мөн үетэй харьцуулсан, %)



Эх үүсвэр: ДБ мэргэжилтнүүдийн тооцоо, ЗАНДБ Бүс нутгийн тойм (2013 оны 10 сар)

Эдийн засгийн бодлогуудыг урт хугацаанд эдийн засгийн тогтвортой илүү байдлыг хангах, тогтвортой хөгжлийг хангахад шилжүүлэх хэрэгтэй …

Дэлхийн эдийн засгийн байдал тодорхойгүй, эдийн засгийн өртөмтгий байдал нэмэгдэж байгаа үед өнөөгийн өсөлтөд чиглэсэн эдийн засгийн бодлогууд нь эдийн засгийн тогтвортой байдал руу чиглэх ёстой. Макро эдийн засгийн удирдлагын тэргүүлэх чиглэлүүд нь: (i) дотоодын хүчин зүйлээс үүсч буй төлбөрийн тэнцлийн дарамтыг багасгах; (ii) тэлэх бодлогуудаас үүдэлтэй макро эдийн засгийн болон санхүүгийн эрсдлүүдэд чиглэсэн; (iii) урт хугацаанд тогтвортой өсөлтийг хангах халхавч бодлогуудыг сэргээх.

1. **Төсвийн бодлого нь цаашид улам чангарах ёстой бөгөөд төсвийн орон зайг дахин бий болгож эхлэх.** Төсвийн тогтвортой байдлын тухай хууль нь 2013 оноос эхлэн хүчин төгөлдөр болсон бөгөөд илүүдэл зарлагыг тогтоон барих төсвийн зарчмуудыг бий болгож (жишээ нь, тэнцвэржүүлсэн алдагдал ДНБ-ий 2 хувийн хязгаарт байх) мөн төсвийн бодлогыг уул уурхайн зах зээлийн мөчлөгийн хэлбэлзлээс тусгаарлах зорилготой. Саяхан зарлагыг танахаа зарласан нь мэдэгдэхүйц ахиц болсон; боловч их хэмжээний төсвөөс гадуурхи зарлага нь хяналтгүй хэвээрээ үлдлээ. Тэргүүлэх чиглэл нь төсвөөс гадуурхи зарлагыг төсвийн нэг хэсэг гэж хүлээн зөвшөөрч түүнийг ТТБТХуулийн хяналтад байлгах. Ингэснээр нэгдсэн төсөв нь орлогын илүү бодитой таамаглал, үндэслэлтэй зарлагын төлөвлөгөөнд үндэслэн ТТБТХуулийн дүрмүүдийг дагах болно. Төсвийн орон зайг дахин бий болгох нь ирээдүйд гадаад талаас үүдэх гэнэтийн шокын үед мөчлөгийн эсрэг бодлогуудыг явуулахад уян хатан байдлыг хангах төсвийн бодлогод их чухал (жишээ нь, улсын өрийн оновчтой түвшин, төсвийн хадгаламжийг бий болгох).

    - **Саяхан төсвийн зарлагыг 2013 болон 2014 онуудад танана гэж зарласан нь илүү тогтвортой төсвийн зам руу чиглэсэн мэдэгдэхүйц алхам боллоо.** Гэвч сайжруулах

төлөвлөгөө нь албан ёсны төсөвт хязгаарлагдмал байгаа бөгөөд их хэмжээний төсвөөс гадуурхи зарлага нь ний төсвийн алдагдлыг ДНБ-и 12 гаран хувьд хүргэж байна.

- **Төсвөөс гадуурхи зарлагыг төсвийн нэг хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой.** Засгин газар нь МУХБ-аар дамжуулан зарах зарлагыг жилийн эцэст удаашруулахаар төлөвлөсөн нь эерэг дохио юм. Гэвч Чингис бондоор санхүүжигдэх төсвөөс гадуурхи их хэмжээний зарлага нь ирэх жилд төсвөөс гадуур хэрэгжиннэ мөн энэ нь төсвийн төлөвлөлтийн үр ашгийг бууруулж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг үр ашгийг мөн бууруулж байна. Төсвөөс гадуурхи зарлагыг төсвийг сайжруулах төлөвлөгөөнд оруулах ёстой бөгөөд төсвөөс гадуурхи зарлагыг оролцуулаад нийт төсвийн алдагдлыг ТТБТХуулийн хязгаарт оруулах ёстой.

- **Дунд хугацааны төсвийг сайжруулах төлөвлөгөө нь итгэлтэй, бодитой байх замд оруулахад тустай.** Хоёрдахь сан хувилбар нь төсвөөс гадуурхи зарлагыг оруулаад төсвийн алдагдлыг бууруулж энэ жилд ТТБТХуулийн зорилго болох 2 хувьд багтаах. Гэвч дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хийх улс төрийн амлалт өгөгдсөн нөхцөлд энэ зорилго нь улс төрий хувьд төвөгтэй байх талтай. Энэ утгаараа, дунд хугацааны төсвийг сайжруулах стратеги нь нэгдсэн төсвийг (төсвийн болон төсвөөс гадуурхи) аажмаар бууруулж, төсвийн алдагдлыг зорилго бүхий жилд – жишээ нь гурван жилийн дараа ТТБТХуулийн зорилго 2 хувьд хүргэх сайн суурь болно. Макро эдийн засгийн таамаглалууд нь төсвийн орлогын хэт өөдрөг төсөөлөл, хэт үрэлгэн зарлагын төлөвлөгөө зохиогдохоос сэргийлж бодитой амьдралтай байх хэрэгтэй. Сангийн яамны Дунд хугацааны төсвийн хүрээ нь дунд хугацааны төсвийг сайжруулах төлөвлөгөөнд сайн суурь нь болох боловч зорилгодоо хүрэхийн тулд түүнийг сайжруулах хэрэгтэй учир нь энэ нь МУХБ зарлагыг оруулдаггүй бөгөөд түүний орлогын таамаглал нь хэт өөдрөг байх талтай байдаг. МУХБ-ны зарлага эсвэл засгийн газрын бондоор санхүүжиглэх төслүүдийг ТТБТХуулиар зохицуулж төсвийн зарлагын хэсэг гэдгийг хуулиар зохицуулж төсвөөс гадуурхи төсвийн зарлагыг нэгтгэж болно.

- **Орлогын таамаглалыг бодит үндэслэлээр хийж, улс төрийн нөлөөнөөс тусгаарлах хэрэгтэй.** Засгийн газраас оруулсан төсвийг сайжруулах төлөвлөгөө болон 2014 оны төсөв нь бодит эдийн засгийн төлөвтэй уялдаатай харагдаж байна. Гэвч өнгөрсөн туршлагаас харахад засгийн газраас оруулсан орлогын таамаглал нь их хурлаас хэлэлцэгдэх явцдаа нэмэлт төсвийн хөтөлбөрүүдийг оруулах замаар зарлага нэмэгдэхэд зэрэгцэн богинохон хугацаанд өндөр болох хандлага байдаг. Энэ жилийн хүнд туршлага – төсвийн 15-20 хувийн орлогын дутагдал – нь хэт өөдрөгөөр төсөөлөх нь төсвийн төлөвлөгөөний итгэлтэй байдлыг алдагдуулж, тухайн жилийн эдийн засгийн нийт удирдлагыг буруу чиглүүлэх талтай.

- **Урт хугацаанд, төсвийн бодлого нь гарч болон эдийн засгийн хямралыг удирдах бодлогын хавхлагыг барих шаардлагатай.** Төсвийн хадгаламжтай байх нь засгийн газрыг эдийн засгийн хямралын үед идэвхитэй, мөчлөгийн эсрэг сангийн бодлогыг зээлэхгүйгээр ажиллах боломжийг олгодог – зээлэх нь эдийн засгийг хямралтай байх үед нэлээд төвөгтэй байдаг. Сангийн яамны боловсруулж байгаа засгийн газрын баялагийн сангийн хууль нь уул уурхайн орлогын удирдлага болон төсвийн хадгаламжийг үр дүнтэй удирдах институцийн сайн суурь болно. Энэ утгаараа, тэнцвэржүүлсэн алдагдлыг 2 хувийн хязгаарт оруулж тэнцвэржүүлсэн тэнцэл гаргах нь (өөрөөр хэлбэл, тэнцвэржүүлсэн алдагдалгүй) урт хугацаандаа уул уурхайн орлого нь тэнцвэржүүлсэн орлогоос дээш үед төсвийн хадгаламжийг бй болгох замаар сайн эхлэл нь болдог.

2. **Төсвийн бодлого нь "сайн зарцуулах" тал дээр илүү анхаарлаа хандуулах ёстой.** Улсын хөрөнгө оруулалтын зарлагыг огцом нэмэгдүүлэх нь– өнгөрсөн арван жилийн хугацаанд хорин долоо дахин нэмэгдсэн нь – улсын хөрөнгө оруулалтын төслүүдийн чанарын талаар асуудал үүсгэж байна. Хэдийгээр хөгжиж буй орнуудад дэд бүтцийн зарлагыг нэмэгдүүлэх нь зайлшгүй чухал боловч түүний хурд нь Засгийн газын төлөвлөлт, хэрэгжилтийн чадавхи, болон эдийн засгийн шингээх чадвартай уялдах ёстой. Төсвөөс баталсан бүх төслүүд нь сайтар боловсруулсан техник эдийн засгийн үндэслэл, хэлбэр, зөв тооцоо судалгааг оруулсан төслийн баримт бичигтэй байх ёстой. Их хурлаар хэлэлцүүлэх явцад шинээр төслүүдийг, тэдгээр нь яаралтай хэрэгжих чухал гэдэг нь батлагдсан, сайн шинжилгээтэй, баримтаар баталгаажсанаас бусад тохиолдолд яаралтайгаар оруулахыг аль болохоор зайлсхийх ёстой,.

    - **Энэ утгаараа, оновчтой дунд хугацааны улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь үндэсний болон салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн дагуу бэлтгэгдэж, түүнд хүрэх зам нь байх ёстой.** Уг төлөвлөгөө нь өгөгдсөн цаг хугацаанд хүрэх хөгжлийн зорилтуудыг тодорхой зааж өгөх хэрэгтэй. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь ТТБТХуулийн хүрээнд дунд хугацааны төсвийн төлөвлөгөөнд авч үзсэн дунд хугацааны оновчтой орлогын төлөвийн хүрээнд бодитой хийгдэх ёстой. Хөгжлийн эхэн үед байгаа улс орны хувьд бүх л зүйл чухал санагдаж байгаа боловч тэргүүлэх чиглэлээр ангилах нь хязгаарлагдмал төсвийн нөөцтэй үед амжилттай хөгжилд чухал. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөр боловсруулагдсан стратегийн тэргүүлэх чиглэлүүд нь төсвийн хөрөнгийг стратегиар байршуулахад чухал суурь болно.

    - **Олон салсан улсын хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоог сайжруулах хэрэгтэй.** Уг тогтолцоо нь хоёр хэсэгтэй: (i) төсвийн доторхи албаны ёсны хөрөнгийн зардал мөн (ii) МУХБ-аар дамжуулах нэмэлт улсын хөрөнгө оруулалтын зарлага. Эдийн засгийн хөгжлийн яам нь энэхүү хоёр хэсгийг үр дүнтэйгээр хянаж байгаа боловч МУХБ-аар дамжиж байгаа улсын хөрөнгө оруулалтын хоёр дахь суваг нь үр дүнтэй төлөвлөлт болон ил тод байдлын хувьд асуудлууд үүсгэж байна. МУХБ нь томоохон улсын хөрөнгө оруулалтын төслүүдийн томоохон санхүүжигч болж байгаа ч төсөв болон МУХБ аль алиныг нь оруулсан үндэсний хөгжлийн төлөвлөгөө алба байна. МУХБ-д ил тод байдал дутагдаж байгаа нь улсын хөрөнгө оруулалтын чанарын асуудал үүсгэж байна. МУХБ нь жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө эсвэл түүний үйл явцын талаар аль алиныг нь нийтлүүлдэггүй бөгөөд түүний төслүүд нь төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдэд шаардагддаг нарийн худалдан авалт, хянаж шалгах шаардлагууд байхгүй байна. Ил тод байдал болон зохицуулалтгүйгээр, МУХБ-ны хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд нв улс төрийн нөлөөнд илүү автах мөн эдийн засгийн бус ...төслүүдийг багтааж байна.

3. **Мөнгөний бодлого нь макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдалд чиглэгдэх ёстой.** Мөнгөний сулруулалт нь энэ жилийн эхэнд зээлийн бууралт гарах нөлөөг багасгахад ашиг тусаа өгсөн боловч сүүлийн саруудад хувийн зээлийн хурдацтай өсөлт нь мөнгөний удидлагуудыг мөнгөний сулралт нь эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, тур дундаа төлбөрийн тэнцэл болон инфляцид ямар нөлөө үзүүлж байгааг дахин үнэлэх хэрэгтэйг онцолж байна.

    - **Төлбөрийн тэнцлийн дарамттай байгаа, инфляци өсөх хандлагатай үед удирдлагууд зээлийн өсөлтийг хязгаарлах ёстой.** Мөнгөний бодлогын удирдлагуудын хэрэгжүүлсэн бодлогын зээлийн хөтөлбөрүүд нь зээлийн өсөлтийг нэмэгдүүлсэн энэ нь бодлогын зээлүүд нь хөнгөлөлттэй нөхцөлөөр арилжааны банкуудад шууд өгсөн. Эдгээр бодлогын зээлийн хөтөлбөрүүдийг аажмаар үе шаттайгаар хэрэгжүүлж, аажимдаа дуусгах хэрэгтэй.

- **Мөнгөний бодлогын удирдлагууд мөнгөний сулруулалтын хурдыг багасгаж байгаа байдал харагдаж байгаа боловч их хэмжээний бодлогын зээлийн хөтөлбөрийг үргэлжлүүлж байгаа үед мөнгөний сулруулалт нь хэвээрээ байхаар байна.** Төв банкнаас богино хугацааны хадгаламж хэлбэрээр 900 тэрбум төгрөгийг арилжааны банкуудад байршуулсаныг Монголбанкинд 2013 оны сүүлээр эргүүлж өгөх ёстой. Гэвч мөнгөний сулруулах хөтөлбөрийн томоохон хэмжээ нь бодлогын зээлийн хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа тохиолдолд хэвээрээ үлдэхээр байна, үүнд Үнийг тогтворжуулах хөтөлбөр, барилгын болон орон сууцыг хөгжүүлэх хөтөлбөр зэрэг. Энэ хоёр хөтөлбөрийн хэмжээ нь мөнгөний сулруулах хөтөлбөрийн 70 гаран хувийг эзэлж байна.

- **Цаашдаа засгийн газраас тэргүүлэх чиглэлийн хөтөлбөр гэж үзсэн бол нийгмийн зорилготой бодлогын зээлийг төсвийн хүрээнд удирдах ёстой.** Засгийн газрын салбарын яамддын санаачилсан нийгмийн зорилготой бодлогын зээлийн хөтөлбөрүүд нь эдгээр төслүүдийг санхүүжүүлж чадахгүй төсвийн хязгаарлагдмал орлогын улмаас төв банкаар хэрэгжүүлж байна. Эдгээр хөтөлбөрүүдэд Үнийг тогтворжуулах хөтөлбөр, барилгын болон орон сууцны хөгжлийн хөтөлбөр орж байна. Төв банкаар дамжин хэрэгжиж байгаа эдгээр төсөв-шиг зарлагын хөтөлбөрүүдэд нь мөнгөний удирдлагуудад төсвийн дарамтыг шилжүүлж, ингэснээр засгийн газрын төсөвт нэмэлт алдагдал үүсгэхээс сэргийлж байгаа ч их хэмжээний мөнгөний сулруулалтын нөлөөг үүсгэж байна.

4. **Банкны тогтолцооны эрүүл байдлыг илүү хүчтэй хянах, шалгаж байх нь чухал.** Хөрөнгийн хүрэлцээтэй байдлыг бэхжүүлэх, энэ оны эхээр Хадгаламжийн Даатгалын Корпорацийг бий болгосон нь сайн ахиц гарсан. Шинээр санхүүгийн салбарын эрсдлийг үүсгэж зээлийн хурдацтай өсөлтөөс зайлсхийхийн тулд зохицуулалтын болон хяналт шалгалтын хүрээг илүү чангатгах хэрэгтэй ялангуяа системийн хувьд чухал банкуудын хөрөнгийн хүрэлцээтэй байдал болон зээлийг гаргах явц, дотоод хяналтад энэ нь илүү шаардлагатай байна.

- **Барилгын болон орон сууцны салбард зээлийн өсөлт хурдацтай өсч байхад, банкны тогтолцооны эрүүл байдлыг чангаар хянаж шалгах хэрэгтэй.** Мөнгөний сулруулах хөтөлбөрийн гаргаж байгаа зээлийн 60 гаран хувь нь барилгын салбарыг дэмжиж байна. Үүний үр дүнд орон сууцны барилга болон орон сууцны түрээсийн үнүүд нэмэгдэж байгаа нь үл хөдлөх хөрөнгийн үнийн хөөсрөлтийн эрсдлийг үзүүлж байна. Банкны салбарын эрүүл байдалд хүчтэй нөлөө үзүүлэх талтай тулд барилгын болон орон сууцны үнүүдийг байнга хянаж байх нь чухал. Дунд орлоготой айлуудын орон сууцны зээллэг нэмэгдэж байгаа тул өрхийн өрийн дарамтыг ч сайтар хянаж байх хэрэгтэй.

- **Бодлогын зээлүүдэд оновтой зохицуулалтыг зөөлрүүлж байгааг байхгүй болгох учир нь ээнэ нь банкны тогтолцоонд зээлийн эрсдлийг муутгах талтай.** Оновчтой зохицуулалтыг зөөллөсөн нь арилжааны банкуудыг энэ бодлогын зээлийн хөтөлбөрүүдийг оролцох урамшуулал болсон. Гэвч энэ нь банкуудын ийм санхүүгийн стрессийг удирдаж чадах санхүүгийн чадварт буруу мэдээллийг бий болгож, нийт банкны тогтолцооны итгэлтэй байдал болон ил тод байдлыг сулруулсан. Хадгаламж банкны саяхны дампуурал нь оновчтой зөв зохицуулалтын чухал байдлыг алдагдуулж байна.

- **Валютын ханш суларч байхад гадаад валютаар илэрхийлэгдсэн зээлээс үүсэх эрсдлийг анхааралтайгаар хянах хэрэгтэй.** Гадаад валютын зээлийн хэмжээ болон бүрэлдэхүүний талаар дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй ч дотоодын валютын ханш суларч

байгаа энэ үед гадаад валютын зээл нэмэгдэж байгаа нь валютын тэнцвэргүй байдалд хүрч хувийн салбарын зээлдэгчдийн (хамгаалагдаагүй) санхүүгийн дарамтыг үүсгэх талтай.

5. **Хөрөнгө оруулалтын орчинг үргэлжлүүлэн сайжруулах нь чухал.** Хөрөнгө оруулалтын орчинд шинэчлэл хийж байгаа нь – энэ нь өмнө нь ГШХО-д гол саад болж байсан нь – хэд хэдэн чухал нөлөөтэй: (i) ойрын хугацаанд зах зээлийн сул сентиментыг сайжруулах; мөн (ii) урт хугацаанд төлбөрийн тэнцлийн өсч буй дарамтыг бууруулах. ГШХО их хэмжээгээр буурсан нь энэ жил зах зээлийн итгэх итгэл буурсан гол зүйл байсан. Хөрөнгө оруулалтын зохицуулалтыг итгэлтэй боломжтой байдлаар сайжруулах нь гадаадын хөрөнгө оруулагчдад Монгол улсын эдийн засаг нь урт хугацааны хөрөнгө оруулалтад тогтвортой, таамаглаж болохуйц бизнесийн орчинг бий болгохыг ойлгуулах дохио болно.

   Энэ орчныг хүлээн зөвшөөрч Засгийн газраас 10 дугаар сард шинэ Хөрөнгө оруулалтын хуулийг гаргасан нь томоохон ахиц болсон. Шинэ хөрөнгө оруулалтын хууль нь бизнесийн илүү тааламжтай орчинг бий болгох замаар хөрөнгө оруулагчдын итгэх итгэлийг дахин олоход сайн эхлэлийг тавьсан. Монгол улсад хөрөнгө оруулах төлөвлөгөөг дахин тохируулах, шинэ хөрөнгө оруулалтын амлалт хийхэд цаг хугацаа шаардлагатай бөгөөд жилийн туршид хөрөнгө оруулагчдын итгэл суларсан байхад хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад хугацаа, нөөц хэрэгтэй. Гэвч шинэ хөрөнгө оруулалтын хууль гаргасан нь эерэг эхлэл болсон нь хөрөнгө оруулагчдйн итгэх итгэлийг эргүүлэх олж авах, гадаадын хөрөнгө оруулалтын тогтвортой, хүчтэй урсгалын тогтвортой суурийг бий болгоно, ялангуяа шинэ хуулийг хөрөнгө оруулалтай холбоотой зохицуулалт болон бодлогын арга хэмжээнүүдийг үргэжлүүлэн сайжруулснаар улам идэвхижинэ.

Эдийн засгийн гол үзүүлэлтүүд

	2011 жил	2012 жил	2013т жил	2014т жил	2015т жил
Үйлдвэрлэл болон үнэ					
Бодит ДНБ (%, өөмү)	17.5	12.4	12.5	10.3	10.0
Уул уурхайн ДНБ (%,өөмү)	7.3	8.0	13.4	25.6	15.3
ХҮИ, Улаанбаатар (%,өөмү)	9.4	14.2	10.5	12.0	9.5
Улсын салбар					
Засгийн газрын орлого (% ДНБ)	40.3	35.7	35.0	33.5	32.6
Засгийн газрын зарлага (%ДНБ)	45.1	46.6	47.3	41.1	38.5
Засгийн газрын тэнцэл (%ДНБ)	-4.8	-10.9	-12.3	-7.6	-5.9
Улсын өр (%ДНБ)	36.7	63.0[e]	..	..	..
Төлбөрийн тэнцэл					
Барааны экспорт (мян. Ам.доллар)	4,817	4,384	4,261	5,113	5,883
(%, өөмү өөрчлөлт)	65.6	-9.0	-2.8	19.9	15.0
Барааны импорт (мян. Ам.доллар)	6,598	6,738	6,522	6,717	7,388
(%,өөмү өөрчлөлт)	101.3	2.1	-3.2	2.9	9.8
Урсгал данс (мян. Ам.доллар)	-2,758	-3362	3,259	2,198	1,856
(% ДНБ)	-31.7	-32.8	29.7	16.7	11.6
Гадаадын шууд хөрөнгө оруулалт (мян. Ам.доллар)	4,620	4,407	1,951	2,228	..
Нийт албан нөөц (мян. Ам.доллар)	2,630	4,126	2,188	..	..
Санхүүгийн зах зээл					
Хувийн дотоодын зээл (%, өөмү, жилийн эцэст)	72.3	24.6	..	..	..
Бодлогын суурь хүү (%, өөмү, жилийн эцэст)	12.3	13.3	..	..	..
Валютын ханш (төгрөг/ам.доллар, хугацааны эцэст)	1,395.4	1,392.1	..	..	..
Бодит ханш (% өөрчлөлт, дундаж)	8.6	2.9	..	..	..
Санамж					
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөг)	11,088	14,013	16,963	20,362	24,027

Эх үүсвэр: улсын мэдээллийн эх үүсвэрүүд, ДБ мэргэжилтнүүдийн тооцоо
e = тооцоо
т = таамаглал

Эх үүсвэр: Монгол банк, Үндэсний статистикийн хороо, Сангийн яам, ДБ мэргэжилтнүүдийн тооцоо